

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралт

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 03							Багануур дүүрэг
Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж (МУЗГҮАХ, НЭЗНХҮЧ, НЗДҮАХ, ДЗДҮАХ, НХЖТ)	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2024	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1 ДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 1.1.Дүүргийн богино хугацааны бодлого, төлөвлөлт боловсруулж, батлах, дүүргийн удирдлагын шийдвэр гаргах түвшинд мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, олон нийтээр хэлэлцүүлж саналыг тусгах замаар оролцоог хангана. (АХ-2050-5.2, МУХТЖҮЧ-5.1.2, НЗДҮАХ-5.1.2, ДЗДҮАХ ХАХТ-5.1.1)							
1	1.1.1.Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.1.1.1)	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	22%	Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт энэ оны эхний хагас жилийн байдлаар 9.1%-тай хэрэгжсэн бөгөөд жилийн эцсийн хэрэгжилтийг нэгтгэж байна.	-

2	1.1.2.Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.1.1.2.)	-	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	90%	Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр А/31 дугаар захирамжаар батлуулж, 02 дугаар сарын 14-ний өдөр bnd.ub.gov.mn сайтад байршуулж, 63 байгууллагад 01/157 дугаартай албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөө 45.1%-тай хэрэгжсэн бөгөөд жилийн эцсийн хэрэгжилтийг нэгтгэж байна.	-
3	1.1.3.Улсын зэрэглэлтэй хот болох бэлтгэл ажлын хүрээнд нийгэм эдийн засгийн суурийг тодорхойлох зөвлөх баг ажиллуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.1.2.1)	-	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	30%	100%	Улсын зэрэглэлтэй хот болох бэлтгэл ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт байгууллагын бүтэц чиг үүргийг тодорхойлсон 3 судалгааг гаргаж хүргүүлсэн. Багануур, Багахангай, Налайх дүүргийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр боловсруулах тендерт СЭЗИСургууль шалгарсан бөгөөд зөвлөх багтай хамтран ажиллах ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/284 дүгээр захирамжаар байгуулсан.	100%

Зорилт 1.2.Төрийн албан хаагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. (АХ-2050-5.4,5.6, ЗГҮАХ-4.2.1, 4.2.2.5, МУХТЖҮЧ-5.4.3, 5.6, НЗДҮАХ-5.1.15, 5.1.11 АН-9.3, ДЗДҮАХ ХАХТ-5.1.4, 5.1.6)

4	1.2.1.Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.1.4.1)	ДТ 300.0	Боловсруулж, батлуулах хөтөлбөрийн тоо	1	1	Нийслэлийн удирдах ажилтнуудын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит шуурхай зөвлөгөөнөөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал хүндрэхтэй холбогдуулан нийгмийн баталгаа, хөтөлбөр төслүүдийг түр зогсоох чиглэл өгсөнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан санхүүжилт ДИТХ-аар хэлэлцэгдэж хасагдсан. Төсөл хөтөлбөрийг хойшлуулсантай холбогдуулан “Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг Сургах, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. Хэрэгжилт 92 хувьтай.	-
			Хөтөлбөрийн хэрэгжилт	Хөтөлбөр 80%-тай хэрэгжсэн.	Хөтөлбөрийг 90%-тай хэрэгжүүлсэн байна.		
5	1.2.2.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. (ДЗДҮАХ ХАХТ-5.1.6.2)	ДТ 5.0	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн	-	90%	Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж,	100%

			хэрэгжилтийн хувь			төлөвлөгөөний хэрэгжилт 90.9%-тай байна. Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд гишүүдийн мэдээллийг бүрэн оруулсан. Мөн ёс зүйн зөрчилтэй холбоотой мэдээллийг бүртгэж оруулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн мэдээллийн дагуу зөрчил гаргасан албан хаагчдаас тайлбар мэдээллийг авч, зөрчил гаргасан тухай дүгнэлт гарган Тамгын газрын даргад танилцуулсан ба зөрчил гаргасан албан хаагчидтай биечлэн уулзаж, хатуу анхааруулга өгсөн. Төрийн албан хаагчдад “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” гарын авлага бэлтгэн тараахын зэрэгцээ Монгол Улсын Ёс зүйн хорооноос бэлтгэн гаргасан Ёс зүйн хэм хэмжээний постеруудыг байгууллагын facebook хуудсанд байршууллаа. Мөн Ёс зүйн дэд хорооны 01, 02, 03 дугаар улирлын тайланг bnd.ub.gov.mn сайтад байршуулсан. Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 03 дугаар сард зохион байгуулж, 101 албан хаагч хамрагдсан бол Монгол	
--	--	--	----------------------	--	--	--	--

						Улсын Ёс зүйн хороотой хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэглээ", "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" сэдэвт сургалтыг 05 дугаар сард зохион байгуулж, 37 байгууллагын 217 албан хаагч оролцсон. Засаг даргын Тамгын газрын хэлтэс, алба, хороодын дунд төрийн албан хаагчийн "Ёс зүй" сэдэвт аяныг 06 дугаар сарын 09-20-ны өдрүүдэд зохион байгуулсан ба Тэргүүн байранд Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, дэд байранд 5-р хороо, гутгаар байранд Цэргийн штаб тус тус шалгарлаа. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс "Сайн жишигийг бид эхлүүлье, Хамтдаа хэвшүүлье", Цэргийн штаб "Цэвэр цэмцгэр хувцаслалт, гадаад үзэмж дээр анхаарч байгууллагын соёлыг түгээцгээе", 5-р хороо "Хүндлэлтэй харилцаж, шуурхай үйлчилье" уриаг дэвшүүлэн, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	
Зорилт 1.3.Төсвийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, саналыг тусган боловсруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, үр дүнг иргэд, олон нийтэд ил тод мэдээлнэ. (НЗДҮАХ-3.1.1, АН-8.4, ДЗДҮАХ ХАХТ-3.1.2)							
6	1.3.1.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж буйд хяналт тавина. (ДЗДҮАХ ХАХТ-3.1.2.1)	-	Хяналт тавих байгууллагын тоо	41	41	2025 оны 11 дугаар сарын 25-ний өдрийн байдлаар нийслэлээс дүүрэгт олгох санхүүгийн дэмжлэг 2,606.6 сая төгрөг, орон нутгийн төсөвт 22,627.4 сая төгрөгийн орлого төвлөрч, орон нутгийн 8	100%

						байгууллагад 22,592.5 сая төгрөг, улсын төсвийн 14 байгууллагуудын байр ашиглах тогтмол зардалд 3,221.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, төсвийн байгууллагын өдөр тутмын гүйлгээнд холбогдох баримтыг үндэслэж фрибаланс программын батлагдсан төлөвлөгөө, төсвийн зарцуулалт эрхийн хүсэлт баталгааг үндэслэн нийт 42 байгууллагын 17,682 ширхэг 105,700.5 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хянан шалгаж баталгаажуулаад байна.	
7	1.3.2.Дотоод болон хөндлөнгийн аудитын шалгалтаар илэрсэн акт, албан шаардлага, зөвлөмжийг бууруулах арга хэмжээг зохион байгуулж, зөрчилгүй стандарт дүгнэлт авна. (ДЗДҮАХ ХАХТ-3.1.2.2)	-	Дүүргийн нэгдсэн тайлангийн дүгнэлт	Стандарт	Стандарт	Дүүргийн төсвийн 26 байгууллага, ААТҮГ-уудын 5 байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үйл ажиллагаанд Нийслэл дэх төрийн аудитын байгууллага хяналт шалгалт хийж, нэгтгэсэн санхүүгийн тайланд Зөрчилгүй стандарт дүгнэлт өгсөн байна. Үүнд: Акт -5,9 сая, албан шаардлага -185,8 сая, зөвлөмж 103,9 сая төгрөгийн зөрчилтэй гарсан ба 11 сарын байдлаар акт зөвлөмжийн биелэлт 93 хувьтай байна. Актын төлбөр бүрэн барагдсан.	93%
8	1.3.3.Мэргэжлийн сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.1.2.3)	ДТ 3.0	Зохион байгуулах сургалтын тоо	2	4	Санхүүгийн Си ти Эс компанитай хамтарч төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарт 02 дугаар сарын 14-ний өдөр 2024 оны санхүүгийн тайлангийн нэгтгэл хийхэд анхаарах асуудал, санхүүгийн программын өөрчлөлт, өмчийн программын талаарх сургалтыг зохион байгуулж нийт 32 санхүүгийн	100%

						ажилтан, нийслэл дэх төрийн аудит, дүүргийн дотоод аудитын албатай хамтран 06 дугаар сарын 19-ний өдөр “Санхүүгийн тайлангийн 2024 онд аудитаар илэрсэн зөрчил, шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх” сэдэвт уулзалт зохион байгуулж, төсвийн байгууллагуудын удирдлага болон санхүүгийн 80 гаруй ажилтан, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттай хамтран 6 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд нярвын сургалт зохион байгуулж 38 иргэд, 10 дугаар сарын 24-ний өдөр “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем”-ийг нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулж 57 хуулийн этгээдийн 130 гаруй ажилтан тус тус хамрагдсан.	
9	1.3.4.“Иргэдийн төсөв” эмхэтгэлийг бэлдэж, иргэдэд танилцуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.1.2.4)	ДТ 2.0	Хэвлүүлэх эмхэтгэлийн тоо	-	450	Дүүргийн төсвийн 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр, салбараар ангилж хороо тус бүрээр салгаж нэгтгэн Иргэдийн төсөв эмхэтгэлийг боловсруулан ном хэлбэрээр хэвлэн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 31-ний өдрийн хооронд зохион байгуулсан. Иргэдэд мэдээлэл	100%

						хүргэх, санал хүсэлтийг хүлээн авах уулзалтаар нийт 5 хорооны иргэдэд 450 ширхэгийг тараан төсвийн тухай мэдээлэл өгч ажиллалаа.	
10	1.3.5.ААНБ, Иргэдэд төсөв, санхүүгийн чиглэлээр өдөрлөг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.1.2.5)	-	Зохион байгуулах өдөрлөгийн тоо	-	1	09 дүгээр сарын 25-ны өдөр төрийн банктай хамтран дүүргийн иргэдэд банк, төсөв санхүүгийн чиглэлээр “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг зохион байгууллаа.	100%
11	1.3.6.Дүүргийн 2026 оны төсвийн талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулна.(ДЗДҮАХ ХАХТ-3.1.2.6)	-	Хэлэлцүүлэгт хамруулах иргэдийн тоо	147	150	Дүүргийн 2026 оны төсвийн талаар нээлттэй хэлэлцүүлгийг 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	-
Зорилт 1.4.Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, өсвөр насны нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ. (АХ-2050-2.2.31, ЗГҮАХ-2.1.1.9, НХТЖҮЧ-2.9.1, НЗДҮАХ- 2.1.1, МАН- 2.3.6, ДЗДҮАХ ХАХТ- 2.1.1)							
12	1.4.1.“Эрүүл мэндийн боловсрол олгох-Эрүүл хүүхэд” төслийг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.1.1)	ДТ 20.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	60%	100%	Нэгдүгээр зорилтын хүрээнд 0-3 настай хүүхдийн Эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа хамгааллын чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчийг чадавхжуулах 15 удаагийн сургалтад 55 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулж, 0-3 настай хүүхдийн өсөлт ба хөгжлийн үнэлгээг давхардсан тоогоор 959 хүүхдийг үнэлгээнд хамруулж үр дүнг эцэг эхэд нь танилцуулах, хүүхдийн суурь өвчлөлийг эрт эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. 9-36 сартай хүүхдийн эрт илрүүлгийн үзлэгт 991 хүүхэд хамрагдахаас 857	94.7%

					хүүхэд хамрагдаж хамрагдалт 87% байна. Хоёрдугаар зорилтын хүрээнд 4-12 насны хүүхдийг шүд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 1800 орчим хүүхэд хамруулж, шүдний эрүүлжилтийн байдлаас шалтгаалж шүдний өвчлөлтэй хүүхдэд хар түрхлэг, өвчлөлгүй хүүхдүүдэд цагаан түрхлэг түрхэж нийт 2000 орчим хүүхдүүдийг урьчдилан сэргийлэх үзлэгт хамруулж ажилласан. Гуравдугаар зорилтын хүрээнд 6-12 насны хүүхдийн амны хөндийн үзлэгт нийт 2670 хүүхэд хамруулж ажилласан. Дүүргийн “Шүд угаалтын аварга шалгаруулах 2025” тэмцээнийг 2025 оны 06 сард зохион байгуулж 4-7 дугаар анги буюу 8-12 насны 700 гаруй хүүхэд хамрагдаж шилдгүүдээ шалгаруулсан. Өсвөр үеийн кабинетаар тайлант хугацаанд 2557 (эрэгтэй-1060, эмэгтэй-1497) хүүхдэд үзлэг хийж, нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх асуудалтай хүүхдүүдийн судалгааг гаргаж ажилласан.. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдгээрийн эцэг эх, иргэдэд хөгжлийн бэрхшээлийн талаархи ойлголт, Аутизм ба эмгэг донтолын сургалт, хөгжлийн	
--	--	--	--	--	--	--

						бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, тэдгээрийг ажлын байранд бэлтгэх нь сэдэвт сургалтуудад иргэд, хүүхэд, тэдгээрийн эцэг эхчүүдийг хамруулан ажилласан. Эх хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох “Эрүүл хүүхэд” төслийн 4 зорилтын хүрээнд 19 ажил төлөвлөн ажилласнаас 18 ажил хийж гүйцэтгэн төслийн хэрэгжилт 94,7 хувьтай хэрэгжсэн.	
13	1.4.2.Өсвөр үеийнхний дунд дүүргийн Засаг даргын нэрэмжит “Эрүүл амьдрах ухаан” сэдэвт олимпиад зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.1.2)	ДТ 10.0	Хамрагдах СӨБ, ЕБС-ийн суралцагчдын тоо	-	1000 5800	“Эрүүл амьдрах ухаан” сэдэвт олимпиадыг 2 дугаар улиралд зохион байгуулж, төрийн өмчийн ерөнхий боловсролын 3 сургуулийн 1-12 дугаар ангийн 6280 суралцагч хамрагдсан. Нийлбэр дүнгээр 1-3 дугаар байранд Оюуны-Эрин сургууль, Боловсрол сургуулийн бага ангийн мэргэжлийн бүлгийн багш нар болон Боловсрол сургуулийн эрүүл мэндийн багш, суралцагч, анги удирдсан багш нар тус тус шалгарсан. Сургуулийн өмнөх боловсролын 6 цэцэрлэгийн ахлах, бэлтгэл нийт 22 бүлгийн 572 суралцагч хамрагдаж, нийлбэр дүнгээр “Ахлах” бүлгийн 1-3 дугаар байранд 193, 132, 241, “Бэлтгэл” бүлгийн 1-3 дугаар байранд 194, 193 дугаар	100%

						цэцэрлэгийн багш, хүүхдүүд тус тус шалгарсан.	
14	1.4.3.Өсвөр үе залуусын дунд хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хор уршгаас сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.1.4)	ДТ 2.0	Зохион байгуулах нөлөөллийн үйл ажиллагаа, хамрагдах хүүхэд	4 420	4 400	Өсвөр үе, залуусын дунд хорт зуршил, сэтгэц нөлөөт бодисын хор уршгаас сэргийлэх талаар 5 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаанд 1813 суралцагч, “Электрон болон утаат тамхины хэрэглээ, эрсдлээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад ахлах ангийн 630 сурагч, “Эрүүл мэндийн өдөрлөг”-т 150 сурагч, “Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хор уршгаас сэргийлэх нь” сургалтад 980 сурагчид тус тус хамрагдаад байна. Мөн “Дэлхийн тамхигүй өдөр”-ийн хүрээнд 05 дугаар сарын 31, 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд тамхи худалдахгүй, тамхи татахгүй байх уриалга гаргаж, түүний хор уршгийн талаарх мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулж, ахлах ангийн суралцагчдын дунд эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж, шилдэгүүдийг шалгаруулсан. Үе тэнгийн нөлөөлөгч бэлтгэх 2 өдрийн сургалтыг 10 дугаар сард зохион байгуулж, ЕБС, МСҮТ-ийн 15-16 насны 40 суралцагч хамрагдаад байна.	100%

Зорилт 1.5.Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг бэлтгэнэ. (АХ-2050-3.5.12, МУХТЖҮЧ-3.5.3, НХТЖҮЧ-3.5.4, НЗДҮАХ-2.1.8, ДЗДҮАХ ХАХТ- 2.2.1)

15	1.5.1.Засаг даргын нэрэмжит “Хөдөлгөөн-эрүүл мэнд” биеийн тамир, спортын IX их наадмыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.1.1)	ДТ 35.0	Зохион байгуулах үйл ажиллагааны төрөл, хамрагдах хүний тоо	12 2291	12 2300	“Хөдөлгөөн-Эрүүл мэнд” сэдэвт дүүргийн Засаг даргын нэрэмжит биеийн тамир спортын IX их наадмыг спортын 12 төрлөөр 4,5 дугаар сард зохион байгуулж, 85 аж ахуйн нэгж, байгууллагаас бүрдсэн 16 багийн 2306 тамирчин оролцож шилдгүүдийг шалгаруулан шагнаж урамшуулаад байна.	100%
16	1.5.2.Монголын хүүхдийн спортын VIII наадмын шигшээ тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.1.2)	ДТ 14.5	Дүүргийн шатны тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо	10 512	11 600	Монголын хүүхдийн спортын VIII наадмын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 04 дүгээр сард спортын 12 төрлөөр зохион байгуулж, 609 тамирчин оролцож, шилдгүүдийг шалгаруулсан. Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ тэмцээний өвлийн спортын төрөлд шайбтай хоккейн 2 насны ангиллалд 2 баг тэргүүн байр эзэлж алтан медаль, зуны спортын 16 төрөлд 137 тамирчин, 12 дасгалжуулагч оролцож, нийт 2 алтан медаль, 5 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн	100%
		ДТ 42.9	Шигшээ тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо	12 127	12 130		
17	1.5.3.Монголын Бүх ард түмний спортын зуны наадмын бүсийн болон шигшээ	ДТ 39.8	Зуны шигшээ тэмцээний	13 86	27 286	Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 12 төрлөөр	96.2%

	тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.1.3)		төрөл, хамрагдах хүний тоо			16 багийн давхардсан тоогоор 1872 тамирчин, шигшээ тэмцээнд 13 төрлөөр 78 тамирчин, 5 дасгалжуулагч оролцож, сагсан бөмбөгийн төрөлд эмэгтэй баг хүрэл, таеквондогийн төрөлд 67 кг жинд хүрэл, Бочи спортын төрөлд мөнгө, хүрэл, Пауэрлифтингийн 57 кг жинд түлхэлтээр алтан медаль, дэд мастерын болзолыг 2 хүн хангасан амжилтыг үзүүлсэн.	
18	1.5.4.Нийслэлийн Иргэдийн спортын наадмыг зохион байгуулж, шигшээ тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.1.4)	ДТ 6.0	Дүүргийн шатны тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо	7 364	9 524	Төрийн хэмнэлтйн тухай хуулийн дагуу НБТСГ-аас тус тэмцээн зохион байгуулагдаагүй болно.	-
		ДТ 8.0	Шигшээ тэмцээний төрөл, хамрагдах хүний тоо	8 114	9 136		
19	1.5.5."Улаанбаатар лиг" өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.1.5)	ДТ 10.0	Төрөл, хамрагдах хүний тоо	2 468	2 660	Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг сагсан бөмбөг, волейболын төрлөөр зохион байгуулж, нийт 62 багийн 744 тамирчид оролцсон бөгөөд "Улаанбаатар лиг" нийслэлийн аварга шалгаруулах шигшээ тэмцээний сагсан бөмбөгийн	100%

						тэмцээнд 2 насны ангиллаар 4 баг, волейболын тэмцээнд 3 насны ангиллаар 6 багийн нийт 122 тамирчин тус тус оролцож, мөнгөн 1, хүрэл 2 медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.	
20	1.5.6."Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг нэмэгдүүлж, баг тамирчдад дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.1.6)	ДТ 15.0	Шигшээ багийн хичээллэх төрөл, тамирчдын тоо	7 136	8 155	Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ баг спортын 7 төрлөөр 199 тамирчин хичээллэж байна. Шигшээ багийн тамирчид болон шинээр хөгжүүлж буй тийбол спортын хоёр багийн 30 тамирчинд бие халаалт болон тоглолтын хувцасны дэмжлэг үзүүлээд байна.	96.8%
		ДТ 20.0	Шигшээ тэмцээнд оролцох баг, тэмцээний тоо	7 35	8 40	Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн 7 шигшээ багийн тамирчид улс, олон улс, тив дэлхийн чанартай нийт 43 тэмцээнд оролцож, алт 27, мөнгө 28, хүрэл 26 медаль тус тус хүртсэн амжилтыг үзүүлээд байна.	
21	1.5.7."U15 улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.1.7)	ДТ 10.0	Тэмцээнд оролцох баг, тамирчдын тоо	24 360	25 375	Өсвөрийн сагсан бөмбөгийн U15 насны улсын аварга шалгаруулах тэмцээнийг дүүрэгт зохион байгуулж, тэмцээнд эрэгтэй 48, эмэгтэй 24, нийт 72 багийн 1100 гаруй өсвөрийн тамирчид оролцож, шилдгүүдийг шалгаруулсан.	100%
22	1.5.8."U18 насны болон +40 насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах	ДТ 8.0	Зохион байгуулах тэмцээний	-	2 10 200	Монголын хоккейн холбоотой хамтран U18 насны болон +40 насанд хүрэгчдийн улсын	100%

	хоккейн тэмцээн зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.1.8)		насны ангилал, баг, тамирчдын тоо			аварга шалгаруулах хоккейн тэмцээнийг дүүрэгт зохион байгуулж 10 багийн 207 тамирчин оролцож, шилдгүүдийг шалгаруулсан.	
Зорилт 1.6.Иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлэн, бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдалтыг нэмэгдүүлж, спортын холбоод, төрийн бус байгууллагуудыг дэмжиж, хамтын ажиллагааг сайжруулан, биеийн тамирын байгууллагын орчин нөхцөлийг сайжруулна. (АХ-2050--3.5.3, НЗДҮАХ-2.1.7, ДЗДҮАХ ХАХТ- 2.2.2, 2.2.3)							
23	1.6.1.Олон улс, УАШТэмцээнд оролцож амжилт гаргасан баг, тамирчдыг шагнаж урамшуулах журмыг боловсруулан хэрэгжилтийг хангана. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.2.1)	ДТ 300.0	Журмын боловсруулалт, хэрэгжилт, дэжлэг үзүүлэх тамирчдын тоо	431	1 450	Дүүргийн Засаг даргын А/313 захирамжаар Дэлхий, Тив, Олон улс, Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцогчдод дэмжлэг үзүүлж, шагнаж урамшуулах журмыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсэг 4 удаа хуралдаж, журмын төслийг боловсруулан хэлэлцүүлэг зохион байгуулж, дүүргийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна. Энэ жил Азийн аварга шалгаруулах тэмцээнд спортын 1 төрлөөр 5 тамирчинд, Олон улсын тэмцээнд спортын 9 төрлөөр 180 тамирчинд, улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 35 төрлөөр 468 тамирчинд тус тус дэмжлэг үзүүлсэн.	100%

24	1.6.2.Бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилын хамрагдалтыг нэмэгдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.2.2)	БТ 1.2	Сорилд хамрагдах хүний тоо	6700	7000	Бие бялдрын түвшин тогтоох сорилын онол, практикийн болон спортын бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтыг 04 дүгээр сард зохион байгуулж, 40 байгууллагын спорт хамтлагийн 50 гишүүн хамрагдаж, 7327 ажилтнаас сорил авч А, В, С үнэлгээ авсан хүний эзлэх хувь 77.1% байна.	100%
25	1.6.3.Спортын салбарын зөвлөгөөн зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.2.5)	ДТ 1.0	Зохион байгуулах зөвлөгөөний тоо	-	1	Спортын салбарын ажилтнуудын зөвлөлдөх уулзалтад байгууллагуудын биеийн тамирын арга зүйч, спорт хамтлагийн гишүүд, клуб, холбоод, ТББ-уудын төлөөлөл, нийт 38 хүн оролцож тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцож, тэмцээнд оролцогчдод дэмжлэг үзүүлж, шагнаж урамшуулах журмын төсөлд санлаа оруулсан.	100%
26	1.6.4.Дөрөвдүгээр хороонд спорт, урлагийн заалны цогцолбор барих ажлыг эхлүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.3.3)	ДТ 1,940.2	Дөрөвдүгээр хорооны спорт, урлагийн заалны цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл	5%	60%	Тус барилгын зураг төсвийн ажлыг гүйцэтгэх явцад газрын хэмжээ байршил нь холбогдох стандартад нийцээгүй улмаас газрын байршлыг өөрчилсөн.Засгийн газрын хуралдаанаар тус газар нь 4 дүгээр сард баталгаажиж ирснээс хугацаа алдаж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийг буцаан татсан.	-

Зорилт 1.7.Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ. (АХ-2050-3.3.14, МУХТЖҮЧ-3.3.1, ЗГҮАХ-2.1.1.30, НЗДҮАХ-2.3.4, МАН-2.3.8, АН-4.5, Хүн нам-1.5, ДЗДҮАХ ХАХТ- 2.5.1)

27	1.7.1.Шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санал санаачлага гаргасан бизнес эрхлэх хүсэлтэй залуучуудад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.5.1.1)	ДТ 20.0 ХЭДС 10.0	Гарааны бизнес эрхлэлтийн сургалтад хамрагдах баг болон залуучуудын тоо	7 16	7 16	Шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санал санаачлага гаргагч бизнес эрхлэх хүсэлтэй 15-34 залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний бүртгэлийг 09 дүгээр сарын 04-20-ны өдрийн хооронд google form цахим системээр бүртгэж, Вест Метод ХХК-тай хамтран бизнесийн санааг хөгжүүлэх сургалтыг 10 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулж, 2 дугаар шатны хурдасгуур хөтөлбөрт 11 багийн 21 залуус хамрагдсан. Start up сүүлийн шатны шалгаруулалтад 7 багийн 12 залуу оролцож, 2 багт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 50% эргэн төлөгдөх нөхцөлтэй тус бүр 15.0 сая төг, 3 багт дүүргийн төсвөөс, тус бүр 5.0 сая төгрөг, нийт 5 багт санхүүжилт олгосон. 1 баг шалгуур хангаагүй тул хасагдаж, 1 баг дараа жилийн шалгаруулалтад дахин оролцохоор татгалзсан.	100%
			Санхүүгийн дэмжлэг өгөх багийн тоо	1	3		

Зорилт 1.8.Хүний нөөцийн судалгаанд тулгуурлан зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.(ЗГҮАХ-2.1.2.1, НХТЖҮЧ-2.15.3, АН-4.4, ДЗДҮАХ ХАХТ- 2.5.2)

28	1.8.1.Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.5.2.1)	ДТ 44.5	Сургалтад хамрагдах хүний тоо	670	680	Сонор эдүкейшн центр ХХК-тай хамтран ажил хайгч 200 иргэнийг Суурь ур чадварын сургалтад, Нэгдмэл үйлс нэг сэтгэл ТББ-тай хамтран жижиг зээл санхүүгийн дэмжлэгийн	73.6%
----	--	------------	-------------------------------	-----	-----	--	-------

						өмнөх бизнес санаа хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх сургалтад 60, Санхүүгийн дэмжлэгийн дараах бизнес эрхлэх ур чадварын сургалтад 50, Мал маллах ашиг шим боловсруулах сургалтад 100, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институттэй хамтран чадамжид суурилсан мэргэжил олгох сургалтад 91, нийт 501 иргэнийг хамруулсан. Чадамжид суурилсан мэргэжлийн сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт зохион байгуулахаар журамд өөрчлөлт орсон. (ХБГ)	
Зорилт 1.9.Ажлын байрыг нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулна. (НХТЖҮЧ-2.15.1, НЗДҮАХ-2.3.7, Хүн нам-1.5, ДЗДҮАХ ХАХТ-2.5.3)							
29	1.9.1.Шинээр бий болсон ажлын байрыг бүртгэх, мэдээлэх ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.5.3.1)	-	Бүртгэж мэдээлэх шинэ ажлын байрны тоо	327	Шинээр бий болсон ажлын байрыг бүртгэж, мэдээлсэн байна.	Дүүргийн хэмжээнд 195 ААНБ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлийн хүрээнд 5, Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрийн хүрээнд 90, нийт 290 шинэ ажлын байр бий болсныг хөдөлмөрийн зах зээлийн E-job цахим системд оруулан мэдээллээд байна.	100%
30	1.9.2.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хэрэгжилтийг хангана. (ДЗДҮАХ ХАХТ-2.5.3.3)	ХЭДС 30.0	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд	2920	2925	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд 690 (бүлгээр–450, ганцаарчилсан-240),	61.2%

			хамрагдах хүний тоо			ажилд зуучлах үйлчилгээнд 1100 (хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ 200, хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө 90, ажлын байрны захиалга 68 ААНБ-ын 260, ажил хайгч 250, ажилд зуучлагдсан иргэн 310, ажлын байраар хангагдсан 250), нийт 1790 иргэн тус тус хамрагдаад байна.	
31	1.9.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.5.3.4)	ХЭДС 720.0	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдах хүний тоо	90	90	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 37, залуучуудын гарааны бизнес эрхлэлтийг дэмжих 2, Нөхөрлөл, хоршоонд олгох санхүүгийн дэмжлэгт 1, Малжуулах санхүүгийн дэмжлэгт 8, Ахмадын санхүүгийн дэмжлэгт 30, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэгт 27, нийт 5 үйл ажиллагаанд 105 иргэнийг хамруулж, байнгын ажлын байраар 123, түр ажлын байраар 96 иргэн тус тус хангагдаад байна. (ХБГ)	100%
32	1.9.4.Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.5.3.5)	ХЭДС 38.0	Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээнд хамрагдах хүний тоо	387	390	Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээний хүрээнд Нарангийн ухаа хэсэг төгсөгчдийн төгөлд 30,000 м/кв талбайд 1300 ширхэг мод ургуулах, арчлах арга хэмжээнд 71, Ахмадын зөвлөх үйлчилгээнд 30 ахмад, Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 4 ахмад, нийт 105 иргэн хамрагдаад байна. Нийтийг	100%

						хамарсан ажлын зардал төсөвт батлагдаагүй тул хэрэгжээгүй болно. (ХБГ)	
Зорилт 1.10. “Халамжаас-хөдөлмөрт” бодлогыг хэрэгжүүлэн зорилтот бүлгийн өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ. (АХ-2050-3.1.14, 3.1.15, НХТЖҮЧ-3.1.1, 3.2.1, АН-5.2, 5.3, ДЗДҮАХ ХАХТ- 2.6.1)							
33	1.10.1.Архины хамааралтай иргэдийг нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.9.3.6)	ДТ 5.0	Хамрагдах хүний тоо	11	10	Монголын АА нийгэмлэгийн Багануур дүүргийн “Нөхөрлөл бүлэг”-тэй хамтран “ХАЙР БА ГЭР БҮЛ” сэдэвт үйл ажиллагааг 03 дугаар сард зохион байгуулж, зүүн бүсийн 50 орчим бүлгийн 220 гаруй гишүүд хамрагдсан. Архины хамааралтай иргэдийг нийгэмшүүлэх эмчилгээнд хамруулах зорилгоор хороо, ӨЭМТ, хамтарсан багийн судалгаанд үндэслэн 16 иргэнийг, өөрийн хүсэлтээр 2 иргэн, гэр бүлийн 2 гишүүний хамт нийт 20 хүнийг 10 дугаар сарын 07-15-ны өдрүүдэд Эрүүл мэндийн төвд хэвтүүлэн эмчилж, энэ хугацаанд Миннисота сэтгэл засал, хөдөлмөр засал, бясалгал зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, “Өөртөө туслах бүлэг” байгуулагдаж тогтмол уулзалтад ирдэг 3 гишүүнтэй болсон.	100%
34	1.10.2.Зорилтот бүлгийн өрх, иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан, хамт олны бүлэгт дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.6.1.1)	ХЭДС 30.0	Төсөл хэрэгжүүлэгч бүлэг, хүний тоо	21 42	20 42	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төслийг хэрэгжүүлэх тендерт “Ай эй пи инсайт” ХХК шалгарч, нийгмийн	88%

						халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах төслийн сургалтад 18 бүлгийн 36 иргэнийг хамруулаад байна.	
Зорилт 1.11.Ахмад насны нийтлэг эрхийг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулна. (АХ-2050-3.1.13, МУХТЖҮЧ-3.1.4, ЗГҮАХ-2.1.1.18, НЗДҮАХ-2.3.3, МАН-2.3.11, 2.3.12, 2.3.13, АН-5.5, Хүн нам-2.3, ДЗДҮАХ ХАХТ- 2.6.3)							
35	1.11.1.Дүүргийн ахмадын чуулганыг зохион байгуулж, дунд хугацааны төлөвлөгөө батлаж хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.6.3.1)	ДТ 15.0	Ахмад настyg дэмжих төвөөр үйлчлүүлэх ахмад настны тоо	1700	1700	Дүүргийн Ахмадын хорооноос ахмад настны хөгжлийг дэмжих чиглэлээр 4 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 91%-тай байна. Ахмадын хорооны тэргүүлэгчдийн хурлыг 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан бөгөөд ахмадын бага хурлыг 12 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Ахмад настныг дэмжих төвөөр сэргээн засах үйлчилгээ болон сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 897 ахмад настан үйлчлүүлээд байна.	52.7%
36	1.11.2.Ахмад настуудыг өдрийн үйлчилгээнд хамруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.6.3.4)	ХЭДС 9.6	Өдрийн үйлчилгээнд хамрагдах ахмад настны тоо	92	92	Ахмадын цогц үйлчилгээ үзүүлэх тендерт “Эвт эрхэс ган” ХХК шалгарч лавлагаа мэдээлэл, ахмад настны хөгжлийг дэмжих, ахмад настны зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг	100%

						дэмжих, зөвлөгөө өгөх үйлчилгээ, сайн дурын үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээ гэсэн 6 төрлийн үйлчилгээнд нийт 250 ахмад настанг хамруулаад байна.	
Зорилт 1.12.Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох замаар, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлж, хөгжих орчин нөхцлийг бүрдүүлнэ. (АХ-2050-2.3.1, ЗГҮАХ-2.1.1.4, НЗДҮАХ-2.5.1, НХТЖҮЧ-2.12.1, ДЗДҮАХ ХАХТ- 2.7.1)							
37	1.12.1.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.7.1.1)	1.5	Зохион байгуулах нөлөөллийн ажлын тоо	4	4	Төрийн байгууллага, аж ахуй нэгж байгууллага, Соёл, спорт, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 29 дугуйлан, секц, клубын багш, дасгалжуулагч зэрэг 36 байгууллагын 521 хүнд хүүхэд хүмүүжлийн эерэг арга, хүүхэд хамгаалал, эцэг, эхийн үүрэг оролцоо, сэдвүүдээр 8 удаа танхимын сургалт зохион байгуулсан. Мөн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн “Гэр бүл үнэ цэнэ”, “Эрүүл гэр бүл-бидний аз жаргал”, “Жаргалтай ээж”, “Аавуудын өдөр” зэрэг 4 удаагийн нөлөөллийн ажилд 2182 иргэн хамрагдсан.	100%
38	1.12.2.Гэр бүлийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.7.1.3)	1.0	Сургалт нөлөөллийн ажилд хамруулах хүний тоо	1400	1400	Гэр бүлийн боловсрол олгох 6 модуль сургалтыг 8 удаа зохион байгуулж 10 байгууллагын 570 албан хаагчийг хамруулсан. “Гэр бүл төлөвлөлт” сэдэвт сургалтыг 10 удаа зохион байгуулж, ерөнхий	100%

						боловсролын 9-12 дугаар ангийн 742 сурагчдийг хамруулсан. “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдэвт цахим хичээлийг bnd.gob.mn вэб сайтад байршуулж 626 хүнд хүргэж ажилласан. Мөн “Жаргалтай ээж” үйл ажиллагаанд 50 иргэн, “Гэр бүл үнэ цэн хариуцлага” үйл ажиллагаанд 150 иргэн, “Эрүүл гэр бүл бидний аж жаргал “Хүүхэд хамгаалалд эцэг эхийн орлцоо”-300 иргэн зэрэг 4 нөлөөллийн үйл ажиллагаанд 500 иргэнийг хамруулсан. Танхимын 18 сургалт, 1 цахим хичээл, 4 удаагийн нөлөөллийн ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж нийт 2438 иргэнд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулсан.	
39	1.12.3.Гэр бүлд зөвлөгөө өгөх өрөөгөөр дамжуулан сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.7.1.4)	1.0	Зөвөлгөө авах иргэдийн тоо	293	300	Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллийн хэлтсээс 2025 оны жилийн эцсийн байдлаар “Гэр бүлд зөвлөгөө өгөх өрөө”-гөөр насанд хүрэгч 175, хүүхэд 73 нийт 300 иргэнд нийгэм, сэтгэлзүй, хууль эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж ажилласан. Төрлөөр нь авч үзвэл: Хууль эрх зүйн зөвлөгөө-188, сэтгэл зүйн зөвлөгөө-47,	100%

42	1.14.1.Тэмүүлэл хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд хяналт тавьж стандартыг хангуулж ажиллана. (ДЗДҮАХ ХАХТ-2.7.5.1)	0.5	Хяналт тавих давтамж	2	2	Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага “MNS 5633:2023” стандартын хэрэгжилтийг хангуулахаар Тэмүүлэл хүүхдийн зуслан дээр 1 удаагийн шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтаар ариун цэврийн байгууламжийн засварын ажил хийгдэж дуусаагүй байхад хүүхдүүд хүлээж авах нь эрүүл ахуй, аюулгүй байдал хангагдаагүй, стандартад нийцээгүй гэж дүгнэж, үйл ажиллагааг эхлүүлэхийг хориглосон.	50%
43	1.14.2.Тэмүүлэл хүүхдийн зусланд эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг барина. (ДЗДҮАХ ХАХТ-2.7.5.2)	ДТ 250.0	Тэмүүлэл хүүхдийн зусланд ариун цэврийн байгууламж барих ажлын гүйцэтгэлийн хувь	10%	100%	Тэмүүлэл хүүхдийн зусланд эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг барих ажлын гүйцэтгэгчээр “Сэцфлорис” ХХК шалгарч, 2025 оны 05 дугаар сард ажил эхэлж, ариун цэврийн байгууламжийн ажил хийгдэж, хүлээлгэн өгсөн.	100%
Зорилт 1.15.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн оролцоог хангах, хөгжүүлэх чиглэлээр олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ- 2.7.6)							
44	1.15.1.Төгсөлтийн аргачлал” төслийг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.7.6.1)	54.1	Төгсөлтийн аргачлал төсөлд хамрагддаг өрхийн тоо	130	150	Төгсөлтийн аргачлал хөтөлбөрт 150 өрх хамрагдаж байгаа бөгөөд 2025 онд шинээр 20 өрхийг сонгож 57.2 сая төгрөгний тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлснээс гадна “Мөрөөдөл, амьжиргаа сайжруулах төлөвлөгөө”, “Дундын	100%

						хадгаламжийн бүлэг үүсгэх” зэрэг сургалтуудыг тус тус зохион байгуулаад байна. Мөн 2023 онд төгсөлтийн аргачлал хөтөлбөрт хамрагдсан 100 өрхийн үр дүнг тооцон төгсөлийн ажиллагааг 10 дугаар сард зохион байгуулж ажилласан.	
45	1.15.2.Улаан загалмайн хороотой хамтран хүмүүнлэгийн болон гамшгийн бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.7.6.4)	6.0	Зохион байгуулах үйл ажиллагаа	4	4	Дүүргийн Улаан загалмайн хороо Багануур ХК-ийн 300 ажилтанд “Анхны тусламж амь нас аварна” сэдэвт 3 өдрийн сургалт, Онцгой байдлын хэлтэс, Дэлхийн зөн Багануур салбар ОНХ хамтран өсвөрийн аврагч клубын 20 сурагчдад “Бэлэн бай” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 320 хүнийг хамруулсан. Гурван сургууль, нэг цэцэрлэгийн 200 багш, сурагчдад “Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах нь” зэрэг 4 багц үйл ажиллагааг 22 удаа сургалт орж 1272 хүүхэд, байгууллагын албан хаагч, иргэдийг хамруулж ажилласан.	100%
46	1.15.3.Донорын өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, хүндэт доноруудыг олон нийтэд сурталчилж, донорын талаар сургалт зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.7.6.5)	8.0	Зохион байгуулах үйл ажиллагаа	5	5	Дэлхийн донорын өдрөөр донор түүний ач холбогдлыг сурталчилан танилцуулах, авлагагүй цусны донорын эгнээг өргөтгөх, цусны нөөцийг нэмэгдүүлэх, донорыг алдаршуулах зорилгоор Засаг даргын Тамгын газар, Улаан	62.5%

			Зохион байгуулах сургалт	2	3	загалмайн хороо, цусны салбар төвтэй хамтран өдөрлөг зохион байгуулж, 240 гаруй албан хаагчид хамрагдсан. Өдөрлөгийн үеэр явуулаар 9 хүнээс цус авснаас гадна БЗӨБЦТС ТӨХК, Шүүхийн Тамгын газрын 104 ажилтанд донорын сургалтыг 2 удаа зохион байгуулж, явуулаар 45 ажилтнаас цус авсан. Жилийн эцсийн байдлаар 3 удаагийн сургалтаар 344 хүнд донорын сургалт сурталчилгааг зохион байгуулж, 53 хүнээс явуулаар цус аваад байна.	
Зорилт 1.16.Залуучуудын сурч боловсрох, хөдөлмөрлөх таатай орчинг бүрдүүлж, манлайллыг нэмэгдүүлэн, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог хангаж, бизнес эрхлэлтийг дэмжиж ажиллана. (АХ-2050-3.3.1, ЗГҮАХ-2.1.1.31, НЗДҮАХ-2.5.5, АН-10.5, ДЗДҮАХ ХАХТ- 2.8.1)							
47	1.16.1.Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн соёл, урлаг, биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.8.1.1)	20.0	Зохион байгуулах арга хэмжээ	2	3	Хоёр удаагийн урлагийн үйл ажиллагаа зохион байгуулж 500 гаруй иргэд залуучуудыг, 2 удаагийн соёлын арга хэмжээнд 400 гаруй залуучуудыг хамруулсан. Нийт соёл, урлаг, биеийн тамирын 9 удаагийн үйл ажиллагаагаар 900 гаруй залуучуудыг хамруулж ажилласан.	100%
48	1.16.2.Залуучуудыг хөгжүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.8.1.2)	2.0	Зохион байгуулах сургалт, нөлөөллийн ажил	2 1100	2 1400	Дүүргийн 15 байгууллагын залуучуудын зөвлөлтэй хамтран нийт 14 удаагийн сургалтаар 1100 гаран албан хаагчдад Залуучуудын хөгжлийн чиглэлээр сургалт зохион байгуулсан. Нэг удаагийн нөлөөллийн ажил зохион байгуулж 400 гаран	100%

						залуучуудыг хамруулж ажилласан.	
Зорилт 1.17.Залуучуудын орлогод тулгуурласан бүхий л талын арга хэмжээ үе шаттай зохион байгуулна. (АХ-2050-3.2.2, ЗГҮАХ-2.1.1.30, НЗДҮАХ-2.5.5, МАН-2.3.8, ДЗДҮАХ ХАХТ- 2.8.2)							
49	1.17.1.Цалинтай оюутан” үйл ажиллагааг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.8.2.1)	10.0	Ажлын байраар хангагдах оюутны тоо	-	4	Монголын залуучуудын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Нэмэх давлагаа” залуучуудын өдөрлөгт гадна болон дотор үйл ажиллааны зохион байгуулалтад ажиллах, бүртгэл судалгаа гаргах, арын албанд ажиллуулах зорилгоор 1-4 дүгээр курсын 20 оюутныг нэг өдрийн цалинтай ажиллуулсан.	100%
Зорилт 1.18.Гэр бүл нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулна. (АХ-2050-4.1.1.4, ЗГҮАХ-2.1.33, ДЗДҮАХ ХАХТ- 2.9.1)							
50	1.18.1.Залуучуудад гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.9.2.1)	0.5	Зохион байгуулах сургалтын тоо	1	2	Боловсролын хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын хэлтэстэй хамтран эцэг эхийн зөвлөлийг чадавхжуулах зорилгоор 01 дүгээр сард Лектор Мягмардорж “Толины хууль ба Эцэг, эх, хүүхдийн харилцаа сэдвээр сургалт орсон. Засаг даргын Тамгын газар, Олон улсын Арслан клуб, Дэлхийн зөн ОУБ-ын Багануур орон нутгийн хөтөлбөр хамтран “Эрүүл гэр бүл-Эрүүл Багануур” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Дээрх 2 сургалтад төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн нийт 520 хүн хамрагдснаас гадна 55 гэр	100%

						бүлийн төлөөлөл 110 хүн оролцсон. Эцэг эхийн үүрэг хариуцлагыг тэгш хувиарлах зорилгоор Нийгмийн даатгалын газар болон Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэстэй хамтран цахим хуудсаар дамжуулан хүүхэд асрах чөлөөг эцэг эх хуваалцах тухай хуулийн заалтыг олон нийтэд сурталчилж, байгууллага, аж ахуй нэгжүүдэд мэдээлэл өгч ажилласан.	
51	1.18.2.Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.9.2.2)	0	Бодлогын хэрэгжилтийн хувь	-	5%	Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын баримт бичиг болон жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны шалгуур үзүүлэлтийг боловсруулан дүүргийн Засаг даргын 01/99, 01/472 тоот албан бичгээр 72 байгууллагад хүргүүлж хийсэн ажлын талаарх тайлангийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. 12 сарын байдлаар төлөвлөгөө боловсруулж тайлан, гүйцэтгэлийн тайлан ирүүлэх 45 байгууллагаас 28 нь тайлан илүүлээд байна. Бодлогын хэрэгжилт 5 хувьд хүрсэн.	100%
Зорилт 1.19.Эрэгтэй, эмэгтэй хүн болон зорилтот бүлгийхэнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоог нэмэгдүүлэх замаар хүний хөгжлийг дэмжинэ.(АХ-2050-4.1.1.5, ЗГҮАХ-2.1.33, ДЗДҮАХ ХАХТ- 2.9.3)							
52	1.19.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангасан талаар сайн туршлагыг судалж, түгээн дэлгэрүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.9.3.4)	4.0	Зохион байгуулах сургалтын тоо	0	2	Иргэдийг архины хамаарал болон бусад хорт зуршлаас ангижруулах эрүүл идэвхтэй	100%

						амьдралын хэмнэлд сургах, уриалах бусдад эерэг нөлөө үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хүрээнд Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн, Эрүүл мэндийн төвийн удирдлага, эмч, сувилагч, хороодын нийгмийн ажилтан, Цагдаагийн хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн албан хаагч нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй баг Улаанбаатар хотод Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн Наркологийн тасгийн өдрийн эмчилгээ, Хан-Уул дүүргийн Сэтгэц нийгмийн сэргээн засах төвийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөгөө мэдээлэл авч цаашид хэрхэн хамтран ажиллах талаар уулзалт, сургалтыг зохион байгуулсан. Энэхүү уулзалтын үр дүнд Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн Наркологийн тасгийн сэтгэл засалч, Сэргээн засах төвийн хөдөлмөр засалч нар Нийгмийн эрүүл мэндийн төвөөс зохион байгуулах архины хамааралтай иргэдийг хэвтүүлэн эмчлэх үед дүүрэгт ирж ажилласан.	
53	1.19.2.Эрэгтэйчүүдэд эрүүл амьдралын хэв маягийг сурталчилах ажлыг үе шаттайгаар	5.0	Зохион байгуулах	-	2 2	Нийгмийн эрүүл мэндийн төвөөс эрэгтэй, эмэгтэй хүний	100%

	зохион байгуулж, дадал эзэмшүүлнэ. (ДЗДУАХ ХАХТ-2.9.3.3)		сургалт, нөлөөллийн ажлын тоо			дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрт илрүүлгийн ач холбогдол, халдварт бус өвчний талаарх ойлголт болон эрүүл зөв амьдралын хэв маягийг эрхэмлэх зэрэг эрүүл мэндийн боловсрол олгох 162 удаагийн, сургалт зохион байгуулж, 3,856 хүн хамрагдсан. Нийгмийн эрүүл мэндийн төвийн эрэгтэйчүүдийн кабинет нь хөвгүүдийн шилжилтийн нас, бэлгийн бойжилт, эрүүл зөв дадалд суралцах чиглэлээр мэдлэг олгох 4 удаагийн сургалтаар ерөнхий боловсролын 3 сургууль, МСҮТ-ийн нийт 164 сурагчдыг хамруулснаас гадна сургуулийн нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллаж байна. Эрэгтэйчүүдийн кабинетаар 601 хүн үзлэгт хамрагдсанаас 285 үйлчлүүлэгчид лабораторийн болон багажийн шинжилгээ хийж онош тодруулан эмчилгээ үйлчилгээ үзүүлж аилласан. Нийгмийн эрүүл мэндийн төвийг контент бүтээх зориулалттай тоног төхөөрөмжөөр хангаж, цаашид иргэд олон нийтэд чиглэсэн	
--	---	--	--	--	--	---	--

						мэдээлэл, сургалт, нөлөөллийн ажлуудыг тогтвортой зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд Эрчүүдийн сэтгэл зүйн эрүүл мэнд сэдвээр подкаст хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	
Зорилт 1.20.Бичил, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зээлийн бүтээгдэхүүнийг боломжит түвшинд нэмэгдүүлж, зорилтод салбаруудад чиглүүлнэ. (НЗДҮАХ 3.3.8, ДЗДҮАХ ХАХТ- 3.3.1)							
54	1.20.1.Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг зээлийн сургалтад хамруулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.3.1.1.)	-	Сургалтад хамрагдах ААНБ, иргэний тоо	40	10	Төрийн банкнаас олгогддог өрхийн болон гарааны бизнесийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн сургалтыг 01 дүгээр сарын 20, 04 дүгээр сарын 14-ний өдрүүдэд зохион байгуулж, сургалтад нийт 47 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг хамруулснаас 2 үйлдвэр эрхлэгч хөнгөлөлттэй зээлд хамрагдаж 143,000,000 сая төгрөгийн дэмжлэг авсан.	100%
55	1.20.2.Ахуйн үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж нэг цэгийн үйлчилгээ бий болгоно. (ДЗДҮАХ ХАХТ-3.3.1.2.)	-	Шинээр бий болгох ахуй үйлчилгээний нэгдсэн цэг	-	1	Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн цэгийг байгуулах ажил нь энэ онд бүрэн хэрэгжээгүй. Учир нь байршлын сонголтын эцсийн шийдвэр гараагүй, оролцох аж ахуй нэгжүүдийн тооцоо, судалгаа дуусаагүй. Иймд уг ажлыг дараагийн жилд дахин төлөвлөж, шаардлагатай бэлтгэл ажлыг ханган ажиллах шаардлагатай байна.	-
Зорилт 1.21.Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах ажлуудыг зохион байгуулж, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. (НЗДҮАХ 3.3.8, ДЗДҮАХ ХАХТ- 3.3.2)							

56	1.21.1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулах, шууд борлуулалтыг дэмжих зорилгоор үзэсгэлэн худалдаа зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.3.2.1)	ДТ 8.0	Зохион байгуулах үзэсгэлэн худалдаа	10	2	Шууд борлуулалтыг дэмжих чиглэлээр 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 02 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл Улаанбаатар хотын “Их наяд плаза”, “Соёолж молл” худалдааны төвүүдэд зохион байгуулагдсан “Амар байна уу”-2025 мөн “Их хотын бүсгүйчүүд-2025” үзэсгэлэн худалдаанд 12 үйлвэрлэл эрхлэгч цагаан идээ, хэвийн боов, үндэсний хувцас зэргээр оролцож 161,600,000 төгрөгийн борлуулалт хийсэн. Мөн Багануур дүүрэгт зохион байгуулагдсан “Амар байна уу” үзэсгэлэн худалдааг 02 дугаар сарын 05-28-ны өдрүүдэд Хэрлэн худалдааны төвд зохион байгуулж, 25 иргэн, аж ахуй нэгж, байгууллага үндэсний хувцас, Цагаан идээ, Хэвийн боов, бэлэг дурсгал зэргээр оролцсон. Хишиг уул ХХК-д нийт 6,250,000 төгрөгийн түрээсийг төвлөрүүлсэн. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн нээлттэй өдөрлөг, “Даншиг наадам цам хүрээ-2025”, “Монгол наадам” үзэсгэлэн худалдаа, “Дээлтэй монгол”, “Нүүдэлчин-2025”, “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулганд хамрагдаж, Монгол улсын	100%
----	--	-----------	--	----	---	---	------

						үндэсний худалдаа, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн зөвхөн монголд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг технологийн шийдлээр тэгш хүртээмжтэй өрсөлдөх боломжийг бий болгон зах зээлд таниулах, борлуулах, борлуулалтын өргөн сүлжээг бий болгох зорилготой Гэрэгэ шоп худалдааны нэгдсэн платформтой хамтран сошиал маркетингийн сургалтуудыг 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж, 23 үйлдвэр эрхлэгч хамрагдснаас 4 үйлдвэр эрхлэгч Гэрэгэ шоп платформд бүтээгдэхүүнээ байршуулан шууд худалдаа хийж байна. Мөн БНХАУ-ын Хөх хотод 08 дугаар сарын 25-31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Монгол хятадын V экспо” үзэсгэлэн худалдаануудад амжилттай оролцож нийт 25 үйлдвэр эрхлэгч 190,020,000 төгрөгийн борлуулалт хийсэн.	
57	1.21.2.Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн гадна фасад, дээвэр, барилгын дотор их засвар хийнэ. (ДЗДҮАХ ХАХТ-3.3.2.2)	ДТ 50.0	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн гадна фасад, дээвэр, барилгын дотор их засварын	-	100%	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга ашиглалтын төлөв байдлын тухай Нийслэлийн хяналт шалгалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 02-12-01/035/211 дугаартай улсын хяналтын байцаагчийн дүгнэлт	90%

			зураг төсвийн гүйцэтгэлийн хувь			болон Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гамшгаас хамгаалах Улсын хяналтын байцаагчийн дүгнэлт гарч тус төвийн барилгын суурийн хаяавчийн засварын ажилд шаардлагатай төсвийг урсгал засварын төсөвт тусган холбогдох материалуудыг хүргүүлж төсвийн тооцоог гаргуулсан. Барилгын засварын зураг төсөв гаргуулахад 48,000,000 сая, ус зайлуулах хаяавчийн нийт төсөвт өртөг нь 14,014,219 сая төгрөг болсон. Тендерийн сонгон шалгаруулалтад Улаанбаатар хотын “А И Архитектс” ХХК шалгарч, уулзалт зохион байгуулж барилга хөгжлийн төвд холбогдох материал зураг төслийг батлуулахаар хүлээлгэн өгсөн.	
Зорилт 1.22.Худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээний үйл ажиллагааг дэмжиж, төр хувийн хэвшлийн уялдаа холбоог сайжруулна. (ДЗДҮАХ ХАХТ- 3.5.2)							
58	1.22.1.Бизнес эрхлэгчдийг гадаад болон дотоодод туршлага судлахад дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-3.5.2.1)	ДТ 40.0	Туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах давтамж	8	Туршлага судлах арга хэмжээг зохион байгуулсан байна.	Тайвань улсын Тапэй хотод Ази, Номхон далайн орнуудын Үсчин, гоо сайхан, хумс урлалын 29 дэх удаагийн Олимп 10 дугаар сарын 21-28-ний өдрүүдэд болж өндөрлөсөн. Монгол улсаа төлөөлөн Багануур дүүргээс хумсны төрөлд 42-р байранд үйл ажиллагаа явуулдаг “Nomi`s салон”-ийн маникюр А.Номин-эрдэнэ оролцохоор болж Дүүргээс 1.630.000	-

						төгрөгийн дэмжлэг авсан. Тус тэмцээнд Nail art matched freely-төрөлд 3-р байр эзэлж цомын эзэн" болсон байна.	
59	1.22.2.Хүнс худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай зөвлөгөөн, уулзалт зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.5.2.2)	ДТ 10.0	Зохион байгуулах зөвлөгөөний тоо	-	1	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 64 худалдаа, нийтийн хоол, хүнсний үйлдвэрийн салбарын албан хаагчдад 01 дүгээр сарын 17-ны өдөр Цагдаагийн хэлтэс, Багануур тохижилт ААТҮГ, Татварын хэлтэстэй хамтран Онлайн бизнес төвийн үйлчилгээ эрхлэх бүртгэл, Тамхины хяналтын тухай хууль, Сogтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, хог хаягдлын тухай танилцуулга, мэдээлэл өгч уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, санал хүсэлтийг сонссон.	100%
60	1.22.3.Монголын тогооч нарын холбооны дэргэдэх Багануур салбар зөвлөлтэй хамтран тогооч нарын ур чадварын уралдаан зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.5.2.3)	ДТ 5.0	Зохион байгуулах ур чадварын тэмцээний тоо	1	1	Монголын тогооч нарын холбоо, Багануур дүүргийн тогооч нарын холбоотой хамтран дүүргийн тогооч нарын ур чадварын уралдааныг 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Уралдаанд 10 аж ахуйн нэгж, байгууллагын 20 гаруй тогооч нар оролцож, хүүхдийн хоолны төрөл, эмнэл зүйн хоолны төрөл, орчин үеийн монгол хоолны төрөл, ресторан зоогийн газар, европ хоолны төрөл нийт 4 төрлөөр	100%

						ур чадвар, хоолны амт чанараараа өрсөлдлөө. Шүүгчээр Монгол улсын мастер тогооч, Монголын тогооч нарын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, МУ-ын үйлчилгээний гавъяат ажилтан Б.Дэлгэр, Мико Суши ХХК Захирал, олон улсын аварга тогооч, олон улсын шүүгч М.Мөнгөншагай, Нийтийн хоолны технологич инженер, Худалдаа нийтийн хоолны яамны дэргэдэх мэргэшсэн дэргэдэх мэргэшсэн үнэлгээ баталгаажуулалтын ажилтан, хоол үйлдвэрлэлийн сургагч багш, Хүнс судлалын ухааны магистр Х.Долгор, Монгол улсын мастер тогооч, хүүхдийн хоолны зөвлөх тогооч Г.Энхцэцэг нар ажилласан.	
61	1.22.4.Дүүргийн худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.5.2.4)	ДТ 10.0	Зохион байгуулах зөвлөгөөн хэлэлцүүлгийн тоо	-	1	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй хувиараа бизнес эрхлэгчдийн дунд 4 төрөлт спортын өдөрлөгийг 09 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 9 багийн 108 тамирчид оролцсон.	100%
Зорилт 1.23.Жимс, жимсгэний үйлдвэрлэлийг дэмжиж, хүн амыг эрүүл чанартай бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ. (АХ-2050-8.3, ЗГҮАХ-3.3.4.30, МУХТЖҮЧ-8.3.6, НЗДҮАХ -3.5.3, МАН-3.1.3, ДЗДҮАХ ХАХТ- 3.6.2)							
62	1.23.1.Жимс, жимсгэний тариалалт, таримлын төрлийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин ажиллана. (ДЗДҮАХ ХАХТ-3.6.2.1)	ДТ 2.0	Сургалтад хамрагдах иргэн, аж ахуй нэгжийн тоо	400 4	50 4	“Мод үржүүлэг болон жимс жимсгэний модны арчилгаа хамгаалал хийх” талаарх сургалтыг дүүргийн 4 аж ахуйн нэгж, байгууллага, жимс,	100%

						жимсгэнэ тариалагч 50 иргэдэд зохион байгуулсан. Сургалтаар хөрсөө хэрхэн бэлтгэх, модны тайралт, хэлбэржүүлэлт болон таналт, тайралтын ач холбогдол, арчилгааг хэрхэн хийх талаар МУ-ын зөвлөх агрономич С.Гочоосүрэн зөвлөмж, арга зүйг өгсөн. Хөх дөрвөлжин” ХХК-тай хамтран тус компанийн мод үржүүлгийн талбайд зохион байгуулж, сургалтын үр дүнг бататгах, боломжоор хангах үүднээс дүүргийн Засаг даргын Тамгын газраас оролцогчдод үхрийн нүдний суулгацыг өгч бодит нөхцөлд суралцах, практик дадлага хийх боломжийг бүрдүүлж ажилласан.	
Зорилт 1.24.Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг хадгалах, газар тариалан, өвлийн хүлэмжийн аж ахуйн төсөл хэрэгжүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ. (ЗГҮАХ-3.3.4.6, 3.3.4.30, МУХТЖҮЧ-8.3.11, МАН-3.1.6, АН-2.11, ДЗДҮАХ ХАХТ- 3.6.3)							
63	1.24.1.Хүнсний ногоо тариалагчдийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-3.6.3.1)	ДТ 1.0	Хамрагдах хүний тоо	350	300	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолын хүрээнд 80%-ийн хөнгөлөлттэй хүнсний ногооны үр олголт 2025 онд олгогдоогүй болно. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн урд талбайд өрхийн тариалан эрхлэгч 5 иргэний хүсэлтийн дагуу 07 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд хүнсний ногооны худалдааг гаргасан.	-

						Өргөтгөсөн худалдаагаар тариаланч 6 иргэн өөрийн тариалсан болон шинэ ургацын 20 гаруй төрлийн 42 тн төмс хүнсний ногоо, жимсийг худалдан борлуулсан.	
64	1.24.2.Хүнсний ногоо тариалах өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-3.6.3.2)	НТ 250.0	Хүлэмжийн барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	30%	100%	Дүүрэгт 2024 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр Мянганы зам дагуу байршилд өвлийн хүлэмж барих ажлын тендерт “Богд сэрүүн хайрхан” ХХК шалгарсан. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас зургийг шаардлага хангахгүй байна барилгын иж бүрэн ажлын зураг байх, магадлалаар оруулах гэсэн шаардлагын дагуу иж бүрэн зураг, төсөв магадлан дүгнэлтээр орж эцэслэгдсэн. Барилгын норм, дүрмийн дагуу нэмэлт ажлууд хийлгэх төсөв нэмэгдэж Багануур дүүрэг 671,5 сая төг, Налайх дүүрэг 710,0 сая төг болсон. Налайх дүүргийн магадлалын дүгнэлт эцэслэж гараагүй байна. Иймээс батлагдсан байсан 500,0 сая төгрөгт дүүргийн хүлэмжийн ажлыг эхлүүлж өгөх хүсэлтийг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ - т албан бичгээр хүргүүлсэн.	30%
Зорилт 1.25.Дүүргийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг ашиг шимийн чиглэлээр төрөлжүүлэн кластер хэлбэрээр хөгжүүлэхэд дэмжиж ажиллана. (ЗГҮАХ-1.4.2.1, МУХТЖҮЧ-8.3.4, 8.3.8, 8.3.11, НЗДҮАХ-3.5.4, АН-2.9, ДЗДҮАХ ХАХТ- 3.6.4)							
65	1.25.1.Малчин, фермер, мал аж ахуй эрхлэгч өрхүүдэд мал сүргийн зохистой харьцааны	ДТ 1.0	Хамрагдах хүний тоо	45	15	Дүүргийн малчин болон фермийн аж ахуй эрхлэгч нарын аж ахуйн үйл	100%

	талаар мэдээлэл хүргэж, үржүүлгийн арга технологийг сурталчлах ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.6.4.1)					ажиллагааг өргөжүүлэх, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор e-mongolia.mn цахим үйлчилгээг хэрхэн ашиглах талаарх танхимын сургалтад 5 хорооны 30 гаруй малчин иргэн хамрагдаж, төрийн цахим үйлчилгээнээс өөрсдийн хэрэгцээт хэдэн төрлийн лавлагаа, мэдээллийг авч болох талаар цахим ур чадвараа нэмэгдүүлсэн. Мөн сургалтын дараа Төв аймгийн Баяндэлгэр сум дахь “Энхсүү наф” ХХК-ийн сүүний кластер фермийн аж ахуйн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан.	
66	1.25.2.Дүүрэгт “Малчдын зөвлөгөөн” зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.6.4.2)	ДТ 5.0	Зохион байгуулах зөвлөгөөн болон хамрагдах иргэдийн тоо	2 700	1 350	“Малчдын зөвлөгөөн”-ийг 2025 оны 11 дүгээр сард хийхээр төлөвлөсөн бөгөөд хорооны Засаг дарга нар болон малчдын саналыг харгалзан үзэж 2026 оны 1 дүгээр улиралд зохион байгуулахаар болсон.	-
67	1.25.3.Дүүргийн өвс,тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-3.6.4.4)	ДТ 50.0	Бүрдүүлэх өвс тэжээлийн нөөц тн	30	30	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024-2025 оны өвс тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх ажлын тендерт “Ганган нүүр” ХХК шалгарч захиалгын дагуу 42,5 тн хивэг тэжээлийг хүлээлгэн өгсөн. 2025-2026 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг хангахаар тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх тенхикийн тодорхойлолтыг 2025 оны 11 дүгээр сарын 17-ний өдрийн	100%

						04/1307 дугаар албан бичгээр ХААА-нд хүргүүлсэн.	
Зорилт 1.26.Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийн мөшгөлт, хадгалалт, борлуулалтын сүлжээнд эрүүл ахуйн шаардлагыг хангуулж, чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. (ЗГҮАХ- 3.3.4.18, МУХТЖҮЧ-8.3.7, НЗДҮАХ-3.5.7, ДЗДҮАХ ХАХТ- 3.6.5)							
68	1.26.1. https://livestock.mofa.gov.mn/ малын үндэсний бүртгэлийн мэдээллийн цахим систем, https://plant.mofa.gov.mn газар тариалан эрхлэлтийн цахим системд гарал үүслийн мөшгөлт борлуулалтын сүлжээнд хяналт тавьж бүртгэлжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-3.6.5.1)	-	Системд бүртгэх малчид, тариаланчдын тоо	896 45	896 45	Малын үндэсний бүртгэл мэдээллийн /https://livestock.mofa.gov.mn/ санд малчин болон мал бүхий 958 өрхийн мэдээллийг статистикийн малын тоотой тулгаж баталгаажуулсан. Төл болон том малын хорогдлын мэдээллийг малчин тус бүрээр системд оруулж ажилласан. Газар тариалан эрхлэлтийн https://plant.mofa.gov.mn цахим системд 53 иргэний хүсэлтэд хяналт тавьж, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.	100%
Зорилт 1.27.Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт шинжилгээ хийх, оношлох, эмчлэхэд хяналт тавина. (ЗГҮАХ-3.3.4.10, МУХТЖҮЧ-8.3.5, НЗДҮАХ-3.5.11, ДЗДҮАХ ХАХТ- 3.6.7)							
69	1.27.1.Халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-3.6.7.1)	УТ 20.0	Үйл ажиллагааны хэрэгжилт	Давхардсан тоогоор 425974 мал, амьтан хамруулсан.	Тухайн жилийн тоогоор	Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 515,656 мал, амьтанг хамруулан вакцины хадгалалт, тээвэрлэлт, зарцуулалтад хяналт тавьж дүгнэлт өгч ажилласан. Төлөвлөгөөт дархлаажуулалтын арга хэмжээнд дотрын халдварт хордлого, колибактериоз иж балнад, адууны сахуу, богийн шөвөг яр зэрэг өвчнөөс сэргийлж 52,700 малд дархлаажуулалт, эмчилгээ,	100%

						эрүүлжүүлэх ажил зохион байгуулсан. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлж, малын ашиг шимийг нэмэгдүүлэх арга хэмжээнд давхардсан тоогоор угаалгад 59576 бог, бод, туулгалт 31014 мал амьтан, боловсруулалт 27371 мал, амьтан буюу нийт 117961 мал, амьтныг хамруулж, гадна болон дотор шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.	
70	1.27.2.Гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчний тандалт, шинжилгээ, оношлох, эмчлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-3.6.7.2)	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	1.5 мян.тол мал хамруулсан.	Тухайн жилийн тоогоор	Гоц халдварт шүлхий өвчний байгалийн голомт илрүүлэх шинжилгээнд 7 өрхийн 112 толгой мал, адууны 4 төрлийн халдварт өвчний тандалтад 3 өрхийн 45 толгой мал, бруцеллёз өвчний тандалтад 745 толгой мал, бог малын мялзан, шүлхий өвчний дархлаажуулалтын дараах тандалт шинжилгээнд 66 толгой мал, шимэгчтэх өвчний эсрэг эмчилгээнд 560 толгой мал буюу нийт 1528 толгой малыг хамруулсан. Тандалт шинжилгээгээр 1 хээлтүүлэгч (ухна) бруцеллёз өвчтэй гарсныг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/47 дугаар тушаалын хавсралтаар заасан зааврын дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан. Дотрын	100%

						халдварт хордлого өвчнөөр дүүргийн 5 хорооны нутагт 14 хонь өвчилж лабораторийн шинжилгээгээр баталгаажсан. Өвчлөлийн голомт гарсан нутагт дүүргийн Засаг даргын захирамж гарган хязгаарлалтын дэглэм тогтоон ажилласнаар халдварыг таслан зогсоосон.	
Зорилт 1.28.Байгалийн нөөц, баялаг, даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, илэрсэн зөрчлийг арилгуулах хяналтыг сайжруулна. (НЗДҮАХ-4.1.1, ДЗДҮАХ ХАХТ- 4.1.1)							
71	1.28.1.Уул уурхай, үйлдвэрийн газруудын нөхөн сэргээлт, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтад хяналт тавина. (ДЗДҮАХ ХАХТ-4.1.1.1)	-	Зохион байгуулах хяналт шалгалтын тоо	4	4	Нийслэлийн Агаар орчны, бохирдолтой тэмцэх газарт “Дөл түшиг” ХХК-ийн үйл ажиллагаа болон орчны агаарын бохирдлын шинжилгээ хийлгэх хүсэлтийг хүргүүлж 05 дугаар сарын 15-28-ны өдрийн хооронд, Месес ХХК-ийн үйл ажиллагаа, орчны бохирдлын шинжилгээ хийлгэх хүсэлтийн дагуу 10 дугаар сарын 03-ны өдөр хяналт шалгалтыг хийсэн. Мөн дүүргийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/149 дугаартай захирамжаар ажлын хэсэг байгуулагдан “Месес” ХХК, “Дөл түшиг” ХХК, “Си эй и майнинг” ХХК, “Лиан мэн жоу зан” ХХК-ийн үйлдвэрийн газруудад 06 дугаар сарын 12-ны өдөр хяналт шалгалтыг 3 дугаар хорооны ажлын алба, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Онцгой	75%

73	1.30.1.Хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулж, эко ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-4.2.1.1)	ДТ 3.0	Зохион байгуулах сургалтын тоо	-	1	Хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 05 дугаар сарын 19-ний өдөр Д.Нацагдоржийн талбайд “Эко жорлон” ХХК өдөрлөг зохион байгуулж, иргэдэд Эко ариун цэврийн байгууламжийн танилцуулга болон зээлийн мэдээлэл хүргэж ажилласан. Мөн нүхэн жорлонгийн үнэр, лагийг арилгаж хөрсний бохирдлыг бууруулах шийдлийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд 08 дугаар сарын 01-ний өдөр иргэдэд сургалт мэдээллийг зохион байгуулсан. 5 хорооны 90 гаруй иргэн хамрагдаж 4 иргэн тухайн бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэж байна. Багануурын мэдээ пэйж хуудсаар стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн талаар 2, нүхэн жорлонгийн үнэр, лагийг арилгах бодисын талаар 2 удаагийн мэдээлэл оруулж, иргэдэд сурталчилж ажиллалаа. 10 айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон. Залуус хэсгийн инженерийн дэд бүтцийн шинэчлэлт бүрэн хийгдэж дуусвал 351 өрх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болно.	83.9%
			Нэмэгдүүлэх эко ариун цэврийн байгууламжийн тоо	200	300		

						Дэд бүтцийн ажил 70 хувьтай явагдаж байна.	
Зорилт 1.31.Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. (ЗГҮАХ-2.4.3.4, НЗДҮАХ-1.2.20, МАН-1.3.1, ХҮН-3.7, ДЗДҮАХ ХАХТ- 1.2.5)							
74	1.31.1.Уурхайн нийтийн байрны гадна дулаан, ус хангамжийн шугам сүлжээг шинэчилнэ. (ДЗДҮАХ ХАХТ-1.2.5.4)	ДТ 114.7	Уурхайн нийтийн байрны гадна дулаан, ус хангамжийн шугам сүлжээний шинэчлэлийн ажлын гүйцэтгэлийн хувь	10%	100%	Уурхайн нийтийн байрны шугам сүлжээний ажлын зураг төсвийг “Ньюфосс инженеринг” ХХК боловсруулж, Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэн 15 удаа тендер сонгон шалгаруулалтыг зарлаж, оролцогч байхгүйн улмаас амжилтгүй болсон.	-
Зорилт 1.32.Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцээр бүрэн хангагдсан орон сууцны хорооллыг барих ажлыг эхлүүлнэ. (АХ-2050-9.3.2, ЗГҮАХ-1.1.3, 2.4.1.6, МУХТЖҮЧ-9.3.3, НЗДҮАХ-1.2.12, МАН-1.1.3, АН-1.8, ХҮН-3.1, 3.4, 3.6, ДЗДҮАХ ХАХТ-1.2.3)							
75	1.32.1.Залуус хэсгийн инженерийн дэд бүтцийн ажлыг үргэлжлүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-1.2.2.2)	УТ 2,480.2	Залуус хэсгийн ИШС-ний ажлын гүйцэтгэлийн хувь	29%	57%	Залуус хэсгийн инженерийн дэд бүтцийн 2025 онд хийгдэх ажлыг ХББОСЯ, дүүрэгтэй гүйцэтгэгч “Бумбод” ХХК зөвшилцөж 06 дугаар сарын 10-ны өдрөөс ажлыг эхлүүлсэн. 12 дугаар сарын байдлаар дулааны 971м шугам, бохирын 1034,5м шугамыг бүрэн шинээр суурилуулан газар шорооны нөхөн сэргээлт, гудамжны засварын ажлыг хийж гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 70%-тай.	100%
Зорилт 1.33.Ус хангамжийн шугам сүлжээг нэмэгдүүлэх, зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн сүлжээнд холбох замаар хүртээмжийг нэмэгдүүлнэ. (АХ-2050-6.3, МУХТЖҮЧ - 6.3, НЗДҮАХ-1.3.15, МАН-1.3.2, АН-4.3, ХҮН-3.8, ДЗДҮАХ ХАХТ- 1.4.1)							
76	1.33.1.Ус хангамжийн магистрал шугамын өргөтгөл, автоматжуулалтын ажлыг дуусгана. (ДЗДҮАХ ХАХТ-1.4.1.1)	ДТ 1,687.5	Ус хангамжийн шугамын өргөтгөл,	54%	100%	Багануур хотын ус хангамжийн шугам сүлжээний өргөтгөл автоматжуулалтын ажлын	100%

			автоматжуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь			даалгаврыг боловсруулж, ХААА-нд хүргүүлэн, тендер зарлаж гүйцэтгэгчээр “Калдератубо” ХХК шалгарч гэрээ байгуулсан бөгөөд 06 дугаар сарын 02-ны өдрөөс ажил эхэлж, холбооны урд талын ВК-4 худгаас УДДТ-1, 2 хүртэлх 310 метр ф150 мм-ийн цэвэр усны хуучин шугамыг ф250 мм-ийн шугамаар сольж шинэчлэх ажил, Наран станцын А, В насос станцын худгийн шинэчлэх ажил, үйлдвэрийн бүсийн насос станцын шинэчлэх ажлуудыг хийж гүйцэтгэж дууссан бөгөөд хүлээлгэн өгөх хүсэлтийг ирүүлээд байна.	
Зорилт 1.34.Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чиглэл, сүлжээг оновчтой төлөвлөн эрэлтэд нийцсэн нийтийн тээвэр, зорчих зогсоолыг хөгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ. (АХ-2050-9.3.1, ЗГҮАХ-1.1.4.2, НЗДҮАХ-1.5.11,АН-3.10, ДЗДҮАХ ХАХТ- 1.5.2)							
77	1.34.1.Нийтийн тээврийн хэрэгслийн гараашийн барилгын ажлыг эхлүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-1.5.2.1)	НТ 1,000.0	Нийтийн тээврийн авто гараашийн барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	10%	30%	Нийслэлийн худалдан авах ажиллагааны албанд НХААГ/20250101027 дугаартай тендерийг зарлан 02 дугаар сарын 26-ны өдөр нээж “Наранбосголт” ХХК шалгарч, энэ онд хийгдэх суурийн ажил, карказ угсралт, шал цутгалт, дээврийн ажлууд хийгдэж дууссан. Ажлын гүйцэтгэл 35%-тай.	100%
78	1.34.2.Нийтийн тээврийн битүү автобусны буудлыг нэмэгдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-1.5.2.2)	ДТ 240,0	Шинээр нэмэгдүүлэх автобусны буудлын тоо	2	2	Нийтийн тээврийн битүү автобусны буудлыг нэмэгдүүлэх чиглэлээр 2 байршилд буюу 3 дугаар хорооны нутаг дэвсгэр Төмөр	70%

[illegible]

83	1.37.1.ЗДТГ-ын баруун талын соёл амралтын хүрээлэнгийн зураг төсвийг боловсруулна. (ДЗДҮАХ ХАХТ-4.4.1.1)	ДТ 50.8	Зураг төсвийн гүйцэтгэлийн хувь	10%	100%	ЗДТГ-ын баруун талын соёл амралтын хүрээлэнгийн зургийн даалгаврыг боловсруулан дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэн “Тирекс” ХХК тендерт шалгаран 07 дугаар сарын 22-ны өдрөөс гэрээ байгуулан зураг төсвийг боловсруулж байна. Ажлын явц 80%	80%
84	1.37.2.Дөрөв, тавдугаар хороонд цэцэрлэгт хүрээлэн, бичил тохижилт, явган хүний зам, дугуйн замын зураг төсвийг боловсруулна. (ДЗДҮАХ ХАХТ-4.4.1.2)	ДТ 85.0	Зураг төсвийн гүйцэтгэлийн хувь	10%	100%	4, 5 дугаар хорооны цэцэрлэгт хүрээлэнгийн ажлын зургийн даалгаврыг боловсруулан дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэн 3 удаа тендер сонгон шалгаруулалтыг зарлан “Натплан консалтинг” ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. 4-р хорооны зургийн ажил 80% 5-р хорооны зургийн ажил 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Дүүргийн 4, 5 дугаар хорооны явган зам засварын ажлын зураг төсөв боловсруулах тендерт “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК шалгарсан боловч тус хорооны газрын өндөржилтийн мэдээллийн сан байхгүй учир гэрээг цуцалсан. Тус тендерийг дахин зарлаж “Хос ерөөл” ХХК шалгаран 11 дүгээр сарын 05-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 29-	75%

						ний өдрийн хооронд гэрээг байгуулан зургийн ажлыг гүйцэтгэж байна.	
85	1.37.3.Хоёрдугаар хорооны цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг үргэлжлүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-4.4.1.3)	ДТ 1,009.5	Тохижилтын ажлын гүйцэтгэлийн хувь	20%	100%	Дүүргийн 2 дугаар хорооны цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг “Өндөр говь мэргэн констракшн” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 600 м2 явган замын ажил 100%, 1705 м2 дугуйн замын ажил 100%, бетон цутгалтын ажил 100%, гадна хашааны ажил 100%, сагсан бөмбөгийн талбай 100%, тоглоомын талбайн ажил 50%, гүйцэтгэлтэй хийгдэж байгаа бөгөөд нийт тохижилтын ажлын гүйцэтгэл 60%-тай байна.	60%
Зорилт 1.38.Иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх, дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, бэлэн байдлыг сайжруулна. (АХ-2050-7.1, МУХТЖҮЧ-7.1.2, ЗГҮАХ-4.3.3.3, НЗДҮАХ-5.3.1, ДЗДҮАХ ХАХТ-5.3.1)							
86	1.38.1.Дайчилгааны бэлтгэл нөөцийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.1.1)	3.5	Зохион байгуулах сургалтын тоо	1	1	Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Дүүргийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн мн/08, дүүргийн Засаг даргын 04 дүгээр сарын 30-ны өдрийн мн/25 дугаар захирамжийг тус тус үндэслэн Цэргийн штабын 2025 оны цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн	100%

						нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний давтан сургалтыг Зэвсэгт хүчний 353 дугаар ангитай хамтран 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 10-ны өдрийн хооронд зохион байгуулсан.	
87	1.38.2.Дүүргийн батлан хамгаалах товчооны сургалтыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.1.2)	3.0	Зохион байгуулах сургалтын тоо	1	1	Батлан хамгаалах товчооны сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан.	100%
88	1.38.3.Хорооны Засаг даргын “Цэргийн албаны бэлтгэл сургалт”-ыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.1.3)	2.5	Зохион байгуулах сургалтын тоо	1	1	Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 28.5 дахь заалт, Цэргийн штабын 2025 оны цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө, Дүүргийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Цэргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай” А/118 дугаар захирамжаар Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийн Хороодын Засаг дарга нартай “Цэргийн бэлтгэл” сургалтыг Хилийн цэргийн 0252 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн 2025 оны 04 дүгээр сарын 30-наас 05 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсан.	100%
89	1.38.4.Цэргийн бүртгэлийг зохион байгуулна.(ДЗДҮАХ ХАХТ-5.3.1.4)	5.0	Цэргийн бүртгэлийн хувь	91%	95%	Цэргийн штабын 2025 оны цэргийн бүртгэл нэгдсэн	100%

						төлөвлөгөөний дагуу 100%-тай явагдсан.	
90	1.38.5.Цэрэг татах, халах ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.1.5)	14.0	Зохион байгуулах цэрэг татах халах ажлын давтамж	1	1	Дүүргээс 2024 оны Хоёрдугаар ээлжээр цэргийн жинхэнэ албанд татагдаж алба хаасан дайчдыг хүлээн авах ажлыг 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, ажлын байранд зуучилсан 17 иргэнийг зуучилж, үүнээс 3 иргэнийг Зэвсэгт хүчинд ахлагч болгосон. 2025 оны Хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 10 дугаар сарын 17, 18 өдрүүдэд “Гүн галуутай” сургуулийн байранд зохион байгуулж, хяналтын тоог 100 хувь биелүүлсэн.	100%
91	1.38.6.Дүйцүүлэх албаны “Бэлтгэл шатны сургалт”-ыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.1.6)	8.0	Зохион байгуулах сургалтын тоо	1	1	Дүйцүүлэх албаны “Бэлтгэл шатны сургалт”-ыг 2025.05.22-2025.06.04-ний хугацаанд Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан.	100%
92	1.38.7.Дүйцүүлэх албаны “Тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт”-ыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.1.7)	4.0	Зохион байгуулах сургалтын тоо	1	1	Дүйцүүлэх албаны “Тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт”-ыг 2025.09.22-2025.10.04-ний хугацаанд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан.	100%
93	1.38.8.Дайчилгааны бэлтгэл нөөцийн тодотгол явуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.1.8)	2.0	Дайчилгааны бэлтгэл нөөцийн	2	2	Дайчилгааны бэлтгэл нөөцийн тодотголыг 2 удаа хийж, акт үйлдэн холбогдох хувийг Батлан хамгаалах яам, Зэвсэгт	100%

			тодотгол хийх давтамж			хүчний жанжин штаб-д хүргүүлсэн.	
Зорилт 1.39.Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг иргэдийн оролцоотой сурталчилж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлнэ. (АХ-2050-7.1, МУХТЖҮЧ-7.1.2, ЗГҮАХ-4.3.3.7, НЗДҮАХ-5.3.2, ДЗДҮАХ ХАХТ-5.3.2)							
94	1.39.1.Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг иргэдийн оролцоотой сурталчилна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.2.1)	6.0	Зохион байгуулах арга хэмжээний тоо	4	4	Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг иргэдэд нээлттэй хэлбэрээр сурталчлан мөн хороодоор дамжуулан иргэдийн оролцоог ханган цэргийн албыг сурталчилах, танин мэдүүлэх арга хэмжээнүүдийг авч ажилласан. Эх оронч Монгол-Их сэргэлтийн жилийн хүрээнд 18 нас хүрсэн залууст цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулах үйл ажиллагааг 01 дүгээр сарын 30-нд зохион байгуулсан. Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойн арга хэмжээг ёслол төгөлдөр зохион байгуулсан. Батлан хамгаалахын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/352 дугаар тушаалаар дүүрэг орон нутагт Батлан хамгаалах бодлого үйл ажиллагааг сурталчлах ажиллагааг 10 дугаар сарын 06-11-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж, дүүргийн 3000 гаруй иргэд хамрагдсан. Мөн Батлан хамгаалах яам, Боловсрол шинжлэх ухааны яам хамтран зохион байгуулж буй “ЭХ ОРОНЧ-10000” зорилтот төслийг дүүргийн Ерөнхий боловсролын ахлах	100%

						ангийн сурагчдын дунд амжилттай зохион байгуулсан.	
95	1.39.2.Төрийн цэргийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, хугацаат цэргийн алба хаагчдыг эргэнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.2.2)	9.0	Хугацаат цэргийн алба хаагчдыг эргэх үйл ажиллагааны тоо	1	1	2025 оны II ээлжээр татагдсан хугацаат цэргийн алба хаагчдыг 2025 оны 11 дүгээр сарын 4, 5-ны өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын дарга, Цэргийн штабын дарга нар эргэсэн.	100%
96	1.39.3.Аж ахуйн нэгж, байгууллагад “Батлан хамгаалах хууль тогтоомжийн сургалт”-ыг явуулж, иргэний цэргийн үүргийн биелэлтийн хяналт шалгалт явуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.2.3)	-	Хяналт шалгалт явуулах байгууллагын тоо	4	4	Батлан хамгаалах хууль тогтоомжийн сургалтыг явуулж, иргэний цэргийн үүргийн биелэлтийн шалгалтыг 4 байгууллага (Багануур ХК-ны 2 хэсэг, БЗӨБЦҮС ТӨХК, Арилжааны банкууд)-д явуулж, 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 14,820,891 төгрөгийг Нийслэлийн Төрийн санд төвлөрүүлсэн.	100%
Зорилт 1.40.Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлнэ. (НЗДҮАХ-5.3.4, ДЗДҮАХ ХАХТ-5.3.3)							
97	1.40.1.Орон нутгийн цэргийн отряд болон томилгоот бүрэлдэхүүний сургалт, дадлага зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.3.1)	7.5	Зохион байгуулах арга хэмжээний тоо	1	1	Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2025 оны мн/06 дугаар тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн мн/34 дүгээр тушаалуудаар явагдсан дайчилгаатай болон орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуульд 120 нэгдүгээр	100%

						зэргийн бэлтгэл үүрэгтнийг хамруулсан.	
98	1.40.2.Орон нутгийн цэргийн томилгоот нэгжийн материал хэрэгслийн нөөц бүрдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.3.2)	18.0	Бүрдүүлэх нөөц	-	Удирдлага холбооны техник хэрэгслээр хангагдсан байна.	Орон нутгийн цэргийн томилгоот нэгжийн материал хэрэгслийн нөөц бүрдүүлэх ажлын төсөв батлагдаж “Орон нутгийн хамгаалалт”-ын томилгоот нэгжийн бүрэлдэхүүн, дайчилгаа удирдах бүлэг, Цугларах, Шилжүүлэх байрын үүрэг гүйцэтгэх боломжыг нэмэгдүүлж, холбооны суурин станц 3 иж, хөдөлгөөнт гар станц 15 ширхэгийг нийт 11,000,000 төгрөгөөр худалдан авч, холбооны бэлэн байдлыг дээшлүүлсэн.	100%
Зорилт 1.41.Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл хүмүүжил олгох, олон талт арга хэмжээг зохион байгуулна. (ЗГҮАХ-4.3.3.7, НЗДҮАХ-5.3.3, ДЗДҮАХ ХАХТ-5.3.4)							
99	1.41.1.Цэрэг спортын дөл тэмцээнийг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.4.1)	15.0	Зохион байгуулах арга хэмжээний тоо	1	1	Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл-2025” цогцолбор тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Монгол улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2025” цогцолбор тэмцээнд 2025 оны 06 дугаар сарын 5-наас 7-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, дүүргийн	100%

						“Соёмбо” тасаг амжилттай оролцсон.	
100	1.41.2.Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.3.4.2)	5.4	Зохион байгуулах арга хэмжээний тоо	3	2	02 дугаар сарын 27-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 150 сурагчыг Налайх дүүрэг дэх Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцуулж, эх оронч сурагч өдөрлөгийг зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Ой тэмдэглэх тухай” 189 дүгээр тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/225 дугаар тушаалаар 1945 оны Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад 2025 оны 09 дүгээр сарын 03, 04-ний өдрүүдэд “Эх оронч Монгол”-чууд нээлттэй хичээлийг төлөвлөгөөний дагуу орж, сургалтад нийт дүүргийн	100%

						Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн 1527 сурагчаас 1425 сурагч хамрагдаж, ирцийн хувь 93.2 хувьтай өмнөө тавьсан зорилго, зорилтоо бүрэн биелүүлсэн үр дүнтэй сургалт болж өндөрлөсөн.	
Зорилт 1.42.Лавлагаа үйлчилгээг иргэнд хурдан шуурхай, чирэгдэлгүй олгоно. (АХ-2050-9.4.7, ШСБ-6.1, ЗГҮАХ-4.2.2.2, МУХТЖҮЧ-5.3.4, ДЗДҮАХ ХАХТ-5.2.2)							
101	1.42.1.Архивын лавлагаа үйлчилгээг цахимаар хүлээн авч, шилжүүлж, түргэн шуурхай иргэний хүсэлтийг шийдвэрлэж, ажиллана. (ДЗДҮАХ ХАХТ-5.2.2.1)	15.0	Лавлагааны шийдвэрлэлт	Нийслэлийн Архивын газар, Архивын ерөнхий газарт цахимаар захиалга өгч эхэлсэн.	Онлайн лавлагааны системийг Үндэсний төв архивын сервертэй холбоно.	Архивын ерөнхий газарт хамтран ажиллах тухай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 04/267 дугаартай албан бичгийг хүргүүлж, 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Онлайн лавлагааны системийг Үндэсний төв архивын сервертэй холбуулж нэвтрэх эрхийг авсан. Онлайн лавлагааны системээр 82 иргэний 149 лавлагааг олгосон байна.	100%
Зорилт 1.43.Стандарт хангасан Архивын барилгатай болно. (АХ-2050-7.4.18, ЗГҮАХ-4.4.2.7, ДЗДҮАХ ХАХТ-5.2.3)							
102	1.43.1.Төрийн архивын барилгын зураг төслийг хийлгэнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.2.3.1)	100.0	Төрийн архивын барилгын зураг төсвийн гүйцэтгэлийн хувь	0%	75%	Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Эзэмшил газрын байршил өөрчлөх тухай” А/138 дугаар захирамжаар архивын газрын байршлыг өөрчлөн тогтоож, 10 дугаар сарын 08-ны өдрийн А/282 дугаар тогтоолоор газар эзэмших 0003993335 дугаар гэрчилгээг олгосон. Төрийн архив, Улсын бүртгэлийн	80%

						хэлтсийн барилгын зураг төсөв боловсруулах даалгаврыг ХААА-нд хүргүүлснээр тендер зарлагдаж, “Очир Огтлогч” ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн БНДХАА/20250203029/04 дугаартай гэрээг байгуулсан. Барилгын зураг төсөв 80%-тай хийгдэж байна.	
Зорилт 1.44.Дүүргийн архив болон хөмрөг үүсгэгч байгууллагуудад хадгалагдаж буй цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ. (МУХТЖҮЧ-5.3.4, НЗДҮАХ-5.2.9, ДЗДҮАХ ХАХТ-5.2.4)							
103	1.44.1.Дүүргийн хөмрөг үүсгэгч байгууллагууд болон ЗДТГ-ын цалингийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ- 5.2.4.1)	-	.Үйл ажиллагааны хэрэгжилт	-	2023-2024 оны цалингийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.	Засаг даргын Тамгын газрын 2023-2024 оны цалингийн картны 2 хадгаламжийн нэгжийн 361 хуудас, цалингийн тооцооны хүснэгтийн 2 хадгаламжийн нэгжийн 156 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн. Дүүргийн хөмрөг үүсгэгч 34 байгууллагад “Цалингийн тооцооны хүснэгтийг цахим хэлбэрт шилжүүлэх тухай” 10/562 дугаар албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр хүргүүлж, 29 байгууллагын 58 хадгаламжийн нэгжийн 1,819 хуудас цалингийн баримтын цахим хувийг бүрдүүлсэн. Багануур дүүргийн газар зохион байгуулалтын алба, Статистикийн хэлтэс, дээд шатны байгууллагаас цалинждаг тул цалингийн баримтын цахим хувь өгөх	95.3%

						боломжгүй тухай албан бичиг ирүүлсэн.	
Зорилт 1.45.Дүүргийн байгууллагуудын архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулна. (АХ-2050-7.4.18, ДЗДҮАХ ХАХТ-5.2.5)							
104	1.45.1.Дүүргийн архивын өрөөг MNS 6929-2021 стандартын дагуу тохижуулна. (ДЗДҮАХ ХАХТ-5.2.5.1)	15.0	Дүүргийн архивын өрөөний тохижилтын ажлын гүйцэтгэл	ЗДТГ 104 м/кв архивын өрөөтэй. 2 ширхэг нягтаршуулсан шүүгээ авсан.	Цонхны хаалт, салхивч, галын дохиоллын систем суурьлуулсан байна.	Дүүргийн хадгаламжийн сангийн цонхны хаалт, салхивч, галын дохиоллын системийн нийт 155,000 төгрөгийн үнийн судалгааг гарган 2025 оны 05 дугаар сард төсвийн тодотголд тусгаж батлуулсан. Архивын өрөөний салхивчийг хаасан байсан хаалтыг авч агаар сэлгэлтийг сайжруулсан, архивын өрөөнд шаардлагатай галын анхан шатны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, 4 ширхэг хяналтын камерийг суурьлуулсан.	100%
105	1.45.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг хугацаанд нь чанартай зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангана. (ДЗДҮАХ ХАХТ-5.2.5.2)	8.0	Архивын улсын үзлэгийн дүнгийн хувь	92%	92%	Засаг даргын Тамгын газар нь улсын үзлэгт хамрагдаж 3 үзүүлэлтийн дунджаар 95.5%-тай дүгнэгдсэн. Дүүргийн архивд хөмрөг үүсгэгч 30 байгууллагад урьдчилсан үзлэгийг зохион байгуулж, тайланг Нийслэлийн Архивын газарт хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоолын дагуу дүүргийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/262 дугаар захирамжаар дүүргийн дэд салбар комисс, 3 ажлын хэсгийг байгуулсан. Батлагдсан хуваарийн дагуу дүүргийн 40 байгууллагад 2025 оны 10	98%

						дугаар сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд улсын үзлэгийг зохион байгуулж, 3 үзүүлэлтийн дунджаар 90.2%-тай дүгнэгдсэн.	
106	1.45.3.Хөмрөг үүсгэгч байгууллагуудын архивын баримтыг тогтоосон журам стандартын дагуу хадгалж хамгаалахад арга зүйгээр ханган ажиллана. (ДЗДҮАХ ХАХТ-5.2.5.3)	-	Байгууллагын тоо	15	10	Дүүргийн архивд хөмрөг үүсгэгч 30 байгууллагыг арга зүйгээр ханган ажилласан. Дүүргийн хөмрөг үүсгэгч байгууллагуудад архивын өрөөнд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10/376 дугаар албан бичгээр хүргүүлж, судалгааг нэгтгэсэн. Дүүргийн 1-5 дугаар хорооны архивын өрөөнд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг авч дүүргийн тодотголд тусгуулан нийт 5,034,460 төгрөгийн галын анхан шатны багаж хэрэгсэл, архивд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. Дүүргийн хэмжээнд 11 байгууллага архивын өрөөнд шаардлагатай галын анхан шатны багаж хэрэгсэл, утаа мэдрэгч, чийг дулаан хэмжигч, нягтруулсан шүүгээгээр хангагдсан байна.	100%
Зорилт 1.46.Багануур дүүргийн түүхэнд холбогдох архивын баримтад эрдэм шинжилгээ, судалгаа хийх, үзэсгэлэн гаргана. (АХ-2050-5.3, НЗДҮАХ-5.2.11, ДЗДҮАХ ХАХТ-5.2.6)							
107	1.46.1.Дүүрэг үүсгэн байгуулагдсан түүхэн ач холбогдол бүхий тусгай төрлийн баримт бүрдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.2.6.1)	6.0	Ажлын гүйцэтгэлийн хувь	0%	100%	Архивын ерөнхий газар, Нийслэлийн архивын газрын онлайн лавлагааны системд хүсэлт хүргүүлсний дагуу Дүүрэг үүсгэн байгуулагдсан Ардын их хурлын	100%

						тэргүүлэгчдийн 1978 оны Зарлиг 1 ширхэг, түүхэн ач холбогдол бүхий тусгай төрлийн 11 ширхэг гэрэл зургийн баримтыг бүрдүүлсэн. Мөн Багануур дүүргийн 1978-2012 онд ажиллаж байсан үе үеийн Засаг дарга нарын гэрэл зургийн 12 ширхэг баримт бүрдүүлсэн.	
2 ДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 2.1.Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавина.							
108	2.1.1.Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, ЗГ, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэр, нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг тооцож, хүргүүлнэ.	-	Хүргүүлэх давтамж	4	4	Засгийн газрын 1 тогтоолын 1 заалт болон Нийслэлийн Засаг даргын 2 захирамжийн хэрэгжилтийг нэгтгэн 03 дугаар сарын 15-ны өдөр, Нийслэлийн Засаг даргын 9 захирамжийн 9 заалтын хэрэгжилтийг 05 дугаар сарын 02-ны өдөр, 1 хуулийн 2 заалт, Засгийн газрын 2 тогтоолын 5 заалтын биелэлтийг 09 дүгээр сарын 12-ны өдөр тус тус тооцон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Хэрэгжилтийн дундаж 62.5%-тай. Жилийн эцсийн тогтоол шийдвэрийн болон Нийслэлийн Засаг даргын захирамжийн түүвэр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлээгүй байна.	75%

109	2.1.2.Дүүргийн Засаг даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тусгах санал, шийдвэрийн төсөл боловсруулж, хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	-	Батлуулах УЗХ-аар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний тоо	1	1	Дүүргийн Засаг даргын дэргэдэх удирдлагын зөвлөл энэ оны 11 дүгээр сарын байдлаар 7 удаа хуралдсан бөгөөд хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, батлууллаа.	100%
			ИТХ-аар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгахаар хүргүүлэх саналын тоо	1	1	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлаар 2025 онд хэлэлцүүлэх 15 асуудлын саналыг холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэн 01 дүгээр сарын 30-ны өдрийн 05/94 дугаартай албан бичгээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд хүргүүлээ.	
			Бэлтгэл хангах зөвлөлийн хурлын тоо	Дүүргийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурал 6 удаа хуралдсан.	Тухай бүрд хурлыг зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангасан байна.	Мөн дүүргийн Засаг даргын 01/253 дугаартай албан бичгээр 5, 01/591 дугаартай албан бичгээр 6, 02/1020 дугаартай албан бичгээр 3 , 01/1294 дугаартай албан бичгээр 1, нийт 15 асуудлыг хэлэлцүүлэхээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын төсөл, төслийн хяналтын дагалдах хуудас, тогтоолын төслийн хавсралт болон танилцуулга, Засаг даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, тухайн асуудлын танилцуулга /PPT/ зэргийн хамт ДИТХ-д өргөн барьсан.	
			Иргэдэд мэдээлэх тоймын давтамж	2	4	“Дүүргийн оны шилдэг аж ахуйн нэгж, байгууллага, бүтээгдэхүүн, иргэдийг шалгаруулах журам батлах тухай” 03 дугаар тогтоол, “Аж	
			Хэрэгжилт хангах шийдвэрийн тоо	5	Тухай бүрд шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.		

						ахуйн тооцоот үйлдвэрийн газрын цалингийн нийтлэг жишгийг шинэчлэн тогтоох тухай” 04 дүгээр тогтоол, “Төрийн дээд шагналд уламжлах тухай” 05 тогтоол, “Дүүргийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай” 06 дугаар тогтоол, “Багануур теле камерын хяналтын дэд төв” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрыг шинээр байгуулах тухай” 07 дугаар тогтоол, “2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 08 дугаар тогтоол, “Дүүргийн 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” 09 дүгээр тогтоол, “Дүүргийн 2025 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 10 дугаар тогтоол, Төрийн шагналд тодорхойлж уламжлах тухай 2025 оны 11 дүгээр тогтоол, Дүүргийн үндэсний аюулгүй байдлыг хангах орон тооны бус байнгын ажлын хэсгийг шинэчлэн батлах тухай 12 дугаар тогтоол, Дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 13 дугаар тогтоолыг тус тус холбогдох байгууллага, албан тушаалтанд тухай бүр хүргүүлж, тогтоолуудын хэрэгжилтийг жилийн эцсийн	
--	--	--	--	--	--	--	--

						байдлаар тооцохоор төлөвлөн ажиллаж байна.	
110	2.1.3.Дүүргийн удирдах ажилтны шуурхай хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, нийслэлийн болон дүүргийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн тайлагнаж, холбогдох албан тушаалтанд хянуулж, дараагийн шуурхай хуралдаанд танилцуулах ажлыг зохион байгуулна.	-	Үүрэг даалгаврын биелэлтийн хувь	92.3%	95%	Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хуралдаан тайлангийн хугацаанд 23 удаа хуралдаж, дүүрэгт хамааралтай 161 үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд биелэлтийг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн Ulaanbaatar ERP дотоод удирдлагын нэгдсэн системийн Хяналт шинжилгээ үнэлгээ цэсэнд болон mandakh@ulaanbaatar.mn цахим хаягаар тухай бүр хүргүүлээ. Үүрэг даалгаврын биелэлтийн дундаж 81.4%-тай байна. Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай хуралдаан энэ оны эхний 11 сарын байдлаар 17 удаа хуралдаж, 197 үүрэг даалгавар өгснөөс биелэлт 88.4 хувьтай байна.	94.3%
				82.4%	85%		
			Бэлтгэл хангах дүүргийн шуурхай хуралдааны тоо	23	Тухай бүр хуралдааны бэлтгэл хангаж, зохион байгуулсан байна.		
111	2.1.4.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийг хангуулан, хянаж, тайлагнана.	-	Гэрээний биелэлт хүргүүлэх давтамж	2	2	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дүүрэгт хамааралтай 2 заалтын биелэлтийг тооцон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 04/671 дүгээр албан бичгээр хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт 90%-тай. Жилийн эцсийн биелэлтийг 12 дугаар сарын 10-	100%
			Гэрээний хэрэгжилтийн хувь	90%	90%		

						ны дотор хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	
112	2.1.5.Төрийн албан хаагчдын тангараг өргүүлэх, зэрэг дэв шинээр олгуулах, зэрэг дэвийг ахиулах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулна.	-	Тангараг өргөх албан хаагчдын тоо	3	Тусгай шалгалт өгч тэнцсэн албан хаагчийг тангараг өргүүлнэ.	Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв шинээр болон ахиулан олгох шаардлага хангасан 16 албан хаагчийн материалыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд уламжилж, нийслэлийн Засаг даргын 2025 оны А/578 дугаартай захирамж, ЗДТГ-ын даргын 2025 оны Б/61 дүгээр тушаалаар зэрэг дэвийн нэмэгдлийг олгоод байна. Энэ онд тангараг өргөх 1 албан хаагчийн мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн бөгөөд ёслолын арга хэмжээ 12 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулагдана.	100%
			Зэрэг дэв шинээр олгох болон ахиулах албан хаагчдын тоо	19	Шаардлага хангасан албан хаагчдын зэрэг дэвийг шинээр олгож, ахиулсан байна.		
113	2.1.6.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавина.	-	Батлуулах төлөвлөгөөний тоо	1	1	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг албан хаагчдын санал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Багануур дүүргийн Засаг даргатай байгуулсан Хариуцлагын гэрээ, байгууллагын стратеги төлөвлөгөө, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025	100%
			Албажуулах тайлангийн тоо	4	4		
			Хэрэгжилтийн хувь	95.3%	96%		

						онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон бусад хууль, дүрэм, журамд заасан чиг үүрэгтэй уялдуулан боловсруулж, 01 дүгээр сарын 05-ны өдөр батлуулсан. Гүйцэтгэлийн тайлангийн дундаж 1-р улиралд 87.2%, эхний хагас жилийн байдлаар 85%-тай гарсан бөгөөд тайланг 06 дугаар сарын 18-ны өдрийн 04/693 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүллээ. 03 дугаар улирлын тайлангийн дундаж 86.7%-тай хэрэгжсэн бол жилийн эцсийн тайланг нэгтгэн гаргахаар ажиллаж байна.	
114	2.1.7.Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.	-	Гаргах шийдвэрийн тоо	Байгууллагын дотоод журамд нийцүүлэн 15 албан хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлсэн.	Тухай бүрд хөдөлмөрийн харилцааны асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэсэн байна.	Засаг даргын Тамгын газрын хүний нөөцтэй холбоотой буюу албан хаагчдын ээлжийн амралтын захирамж 1, тушаал 1, төрийн албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг олгох 1 захирамж, 1 тушаал, төрийн захиргааны албанд томилсон 1, түр томилсон 4, чөлөөлөгдсөн 4, улс төрийн албан тушаалд томилсон 3, чөлөөлсөн 3, төрийн үйлчилгээний албан тушаалд шинээр томилсон 15, ажлаас чөлөөлсөн 5, ажилд эгүүлэн томилох 2, шилжүүлэн	100%

						ажиллуулах 3, сэлгэн ажиллуулах хугацааг дуусгавар болгох 3, гэрээт ажилтан авах 2, гэрээний хугацаа дуусгавар болсон 3, ажил хүлээлцүүлэх 5, жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах чөлөө олгох 5, буцалтгүй тусламж, дэмжлэг олгох 23, ээлжийн амралттай албан хаагчийг түр орлон гүйцэтгэх 2, ажил хавсран гүйцэтгэх 2, ахлах мэргэжилтэнгээр томилсон 2, 5 жилийн мөнгөн урамшуулал олгосон 3, ур чадвар болон ёс зүйн хорооны гишүүдийн нэмэгдэл олгох 2, зэрэг дэв мэргэшлийн зэргийн нэмэгдэл 2, чөлөө олгосон 8, ахмад настанд дэмжлэг үзүүлэх тухай 2, албан тушаалын зэрэглэлд өөрчлөлт оруулсан 3, хүүхдийн баяр, шагнах 1, нөхөх төлбөр олгох 3, нийт 115 захирамж, тушаалын төслийг боловсрууллаа.	
115	2.1.8.Төрийн дээд, эхийн алдар одонгоор шагнуулахаар ирүүлсэн иргэдийн материалыг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, уламжлах, Засгийн газар нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шагналыг уламжлах, гардуулах ажлыг зохион байгуулна.	-	Уламжлах материалын тоо	548	Шаардлага хангасан иргэдийн материалыг тухай бүрд дээд шатны байгууллага д уламжилна.	Алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одонгоор шагнуулахаар уламжилж ирүүлсэн 125 иргэний материалыг хянаж, бүрдлийг ханган, 04 дүгээр сарын 01-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт уламжилсанаар I зэргийн одонгоор 15 , II зэргийн одонгоор 90 иргэн шагнагдлаа.	91.6%

			Зохион байгуулах арга хэмжээний тоо	5	4	Төрийн дээд цол, одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлж ирүүлсэн 148 иргэний материалыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн уламжилсанаар ХГУТО- 28, ЦГУТО-3, АГО-73, ЦГО-1, ХХМ-34, Засгийн газрын болон нийслэл дүүргийн шагналаар 83 иргэн шагнуулсан бөгөөд шагнал гардуулах үйл ажиллагааг 02, 05, 07 дугаар саруудад тус тус зохион байгууллаа.	
			Засаг даргын шагналаар шагнагдах иргэдийн тоо	305	Шаардлага хангасан иргэдийг тухай бүрд шагнаж урамшуулса н байна.		
116	2.1.9.Хэсгийн ахлагчдыг чадавхжуулах, хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтыг тогтмол зохион байгуулж, төр-иргэний хамтын ажиллагааг сайжруулна. (ДЗДҮАХ ХАХТ-)	-	Зохион байгуулах сургалтын тоо	16	20	Хэсгийн ахлагчдыг чадавхжуулах, эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр 01 дүгээр сард Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн талаар, 03 дугаар сард “Хүн ам болон статистик мэдээ гаргахад анхаарах зүйлс”, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлт болон Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар, 04 дүгээр сард Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, “Зөв дадал- Архигүй орчин”, 05 дугаар сард “Нийгмийн халамжийн тухай хууль, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний шинэчлэгдсэн журам, Ахмад настны тухай хуульд орсон	70%

						нэмэлт өөрчлөлт, дагалдах журмын талаар, 06 дугаар сард Хүүхэд хохирсон, холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, шалтгаан нөхцөл, Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн нэр төрөл, тодорхойлолт стандарт, Дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө, egazar.gov.mn цахим системийн ашиглалтын талаар, 07 дугаар сард Архи, тамхины тусгай зөвшөөрөл олгох тухай, Улаанбурхан өвчин, вакцинжуулалтын ач холбогдол, 11 сард Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, 2025 оны гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаарх сургалтуудад тус тус хамрууллаа.	
117	2.1.10.Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, чөлөөлөгдсөн албан хаагчийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгоно.	-	Төрийн албан хаагчийн бүртгэлийн тоо	20	Бүртгэлийг тухай бүр ил тод, нээлттэй мэдээлсэн байна.	Засаг даргын Тамгын газраас өөрийн хүсэлтээр төрийн захиргааны 4, төрийн үйлчилгээний 5, улс төрийн 3 албан хаагч чөлөөлөгдсөн бол гэрээний хугацаа дуусгавар болж чөлөөлөгдсөн 3, түр чөлөөлөгдсөн төрийн захиргааны 3, төрийн үйлчилгээний 2 албан хаагч тус тус байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын энэ оны 04/45	100%

			Bnd.gov.mn цахим сайтад улирал тутам оруулсан мэдээллийн тоо	4	4	дугаар албан бичгээр төрийн захиргааны удирдах албан тушаалын-1, гүйцэтгэх албан тушаалын-5, 04/492 дугаар албан бичгээр төрийн захиргааны удирдах-1, гүйцэтгэх-7 албан тушаалын сул орон тооны захиалгыг тус тус Төрийн албаны зөвлөлийн Нийслэлийн салбар зөвлөлд хүргүүллээ. Bnd.ub.gov.mn цахим хуудсанд энэ оны гуравдугаар улирлын байдлаар төрийн албанаас чөлөөлөгдсөн, томилогдсон албан хаагчдын мэдээллийг 1 удаа , Багануурын мэдээ пэйж хуудсанд Төрийн жинхэнэ албан хаагчийн удирдах болон гүйцэтгэх 6 сул орон тооны зарыг 2 удаа байршуулж ажиллалаа.	
118	2.1.11.Нутгийн захиргааны байгууллагаас гаргах нийтэд хамааралтай шийдвэрийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог тогтмол хангана.	-	Иргэдийн оролцоог хангасан байдал	Нийтэд хамааралтай 1 төсөлд иргэдийн оролцоог хангаж ажилласан.	Нийтэд хамааралтай шийдвэр боловсруулах тухай бүрд хамтрана.	2025 оны байдлаар нийтэд хамааралтай шийдвэрийн төсөл боловсруулагдаагүй байна.	-
Зорилт 2.2.Хэлтэс, алба, хорооны ажлын уялдааг хангана.							
119	2.2.1.Хороодын ажлыг сайжруулах чиглэлээр зөвлөн туслах арга хэмжээнүүдийг зохион байгуулна.	-	Зохион байгуулах арга хэмжээний тоо	8	8	Захирамжлалын баримт бичгийн эрх зүйн үндэслэл, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангуулах зорилгоор зөвлөн туслах ажлыг 1, 2, 3, 4 дүгээр хороонд зохион байгуулсан.	75%

						Архивын улсын үзлэг болохтой холбогдуулан дүүргийн Архивын хэлтэстэй хамтран 2, 4 дүгээр хороонд 2019 оноос өмнө үүссэн баримтуудыг нягтлан шалгаж, байнга, түр, 70 жил хадгалах болон устгах баримтыг ялган, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. 3 дугаар хорооны бичиг хэргийн ажилтан, нийгмийн ажилтнуудад гүйцэтгэлийн тайлан гаргахтай холбоотой арга зүйн тусламж, зөвлөгөө өгч ажилласан. Дүүргийн 3, 4 дүгээр хороонд Өргөдөл, гомдлын дэд системийн ашиглалтын талаар арга зүйн зөвлөгөө өгсөн. Хороодын архив, бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч нарт Төрийн архивын нэгдсэн систем болон Архивын Ерөнхий газар, Нийслэлийн Архивын газарт онлайн лавлагааны захиалга өгөх арга зүйн зөвлөгөөг Архивын хэлтэстэй хамтран өгсөн. 1, 3, 4 дүгээр хорооны зохион байгуулагч нарт хүн амын шилжилт хөдөлгөөний ДТМ судалгааг гаргах, хяналт тавих талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.	
120	2.2.2.Хороодын албан хаагчдын дунд спортын тэмцээн зохион байгуулна.	-	Зохион байгуулах тэмцээний тоо	1	1	Хороодын албан хаагчдын дунд 04 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд спортын арга хэмжээг дартс, гар бөмбөг 2 төрлөөр зохион байгуулсан бөгөөд нийлбэр оноогоор 5	100%

						дугаар хороо Тэргүүн байр эзэлж, шилжин явах цомын эзэн боллоо.	
121	2.2.3.Засаг даргын Тамгын газрын дотоод хяналт шалгалтын зөвлөлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	-	Боловсруулах төлөвлөгөө ний тоо	1	1	Засаг даргын Тамгын газрын даргын 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар “Байгууллагын дотоод хяналт шалгалтын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж 06 дугаар сарын 10-ны өдөр хуралдаж 2025 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Төлөвлөгөөний дагуу гишүүд удирдамж гарган хяналт шалгалтын ажлуудаа эхлүүлсэн бөгөөд төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн дундаж 97%-тай, жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор нэгтгэн гаргахаар ажиллаж байна.	100%
			Гаргах тайлангийн тоо	2	2		
			Хэрэгжилтийн хувь	63.3%	80%		
122	2.2.4.Хороодын Засаг дарга нартай Батламжийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулна.	-	Байгуулагдах батламжийн гэрээний тоо	5	5	Хороодын Засаг дарга нартай 01 дүгээр сарын 02-ны өдөр Батламжийн гэрээ байгуулсан бол хорооны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 01 дүгээр сарын 13-ны өдөр дүүргийн Засаг даргаар батлууллаа.	100%
			Батлуулах төлөвлөгөөний тоо	5	5		
123	2.2.5.Хороодын гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулна.	-	Тайлангийн тоо	20	16	Хороодын гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жилээр гаргуулан хяналт тавин ажиллаж байна. Энэ оны 3 дугаар улирлын байдлаар 1 дүгээр хорооны гүйцэтгэлийн тайлан 95,42%, 2 дугаар	100%

						хорооны гүйцэтгэлийн тайлан 96,15% 3 дугаар хорооны гүйцэтгэлийн тайлан 94%, 4 дүгээр хорооны гүйцэтгэлийн тайлан 99,1%, 5 дугаар хорооны гүйцэтгэлийн тайлан 96,6%-тай хэрэгжсэн байна. Хороодын гүйцэтгэлийн тайлан жилийн эцсийн байдлаар 12 дугаар сарын 03-ны дотор гаргуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
124	2.2.6.Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулна	-	Зохион байгуулах өдөрлөгийн тоо	-	Иргэдэд төрийн үйлчилгээг сурталчилах өдөрлөгийг зохион байгуулна.	Хууль, зүй дотоод хэргийн яам, Цагдаагийн Ерөнхий газар, Монгол Улсын болон Нийслэл, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтран Багануур, Бага-Хангай Налайх дүүргийн нутаг дэвсгэрт согтуугаар үйлдэгдэж буй Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, урьдчилан сэргийлэх ажлын оновчтой арга, хэлбэрийг эрэлхийлж, байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “ХАМТДАА ШИЙДЬЕ” уулзалт, хэлэлцүүлгийг 05 дугаар сарын 05-ны өдөр Багануур дүүрэгт зохион байгуулсан. “ХАМТДАА ШИЙДЬЕ” уулзалт, хэлэлцүүлгийн оролцогчид 3 танхимд хуваагдан хуралдаж, хуралдаанаас гарсан санал хүсэлтийг танилцуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг	100%

						тодорхойлсон үр дүнтэй хэлэлцүүлэг болсон. Мөн өдөр дүүрэгт хууль, хүчний байгууллага болон Хилийн цэргийн 0252 дугаар анги хамтран “Нээлттэй өдөрлөг”-ийг зохионбайгуулсан. Өдөрлөгийн үеэр Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, Шүүхийн Тамгын газар, Монголын өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч нар давхардсан тоогоор 516 иргэнд бүртгэлийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.	
125	2.2.7.Ижил төстэй хотуудтай Санамж бичиг байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	-	Санамж бичгийн тоо	-	2	АНУ-ын Потамакийн их сургуулийн захиралтай дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Хамтын ажиллагааны санамж бичиг, БНСУ-ын Солонгосын нээлттэй кибер их сургуулийн захиралтай дүүргийн Засаг даргын орлогч Харилцан ойлголцлын санамж бичиг тус тус байгуулсан. БНХАУ-ын Өвөр Монголын Бугат хоттой хамтын ажиллагааг тогтоох зорилгоор Бугат хотын Ардын Засгийн газрын Гадаад харилцааны албаны дэд захирал ЮэХайронгтой 03 дугаар сарын 31-ний өдөр уулзалт зохион байгуулж,	90%

						хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар хоёр хотын удирдлагуудын эхний уулзалтыг Бугат хотод зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж, айлчлалаар очих албан хаагчдын мэдээлэл болон санамж бичгийн төслийг Бугат хот болон нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлээд байна.	
Зорилт 2.3.Холбогдох байгууллага, иргэдийг мэдээллээр хангаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.(БГТ-58)							
126	2.3.1.Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавина.	-	Байршуулах мэдээ, мэдээллийн тоо	Багануурын мэдээ-1206 bnd.gov.mn-273	Тухай бүрд мэдээлсэн байна.	Багануурын мэдээ фэйсбүүк хуудас өнөөдрийн байдлаар 33.4 мянган дагагчтай. Энэ онд шинээр 3,3 мянган дагагч нэмэгдсэн бол 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 21.1 сая үзэлт, үзэлтийн хугацаа 812 өдөр, 9 цаг, 27.3 хувийн өсөлттэй. Хамгийн өндөр хандалт авсан мэдээ 2.6 мянган лайк авч 136046 хүн үзсэн байна. Тайлант хугацаанд 1736 мэдээллийг зурган болон рийл, постер хэлбэрээр байршууллаа. Энэ онд “Багануурт үйлдвэрлэв”, “Таны үйлчилгээг бид сурталчилъя” нэртэй 2 контентыг санаачлан эхлүүлж, 24 удаагийн контентыг иргэдэд хүргэснээр хандалт болон иргэдийн сэтгэгдэл өндөр байна. Мөн 14 байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчиллаа. Засаг	100%
			Багануурын мэдээ пэйж хуудасны дагагчдын тоо	29600	Дагагчийн тоог нэмэгдүүлсэн байна.		

						даргын нэрэмжит спортын их наадмын нээлт, хаалт, Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон Дүүргийн баяр наадмыг шууд дамжуулсан бол хөрөнгө оруулалтын ажлын талаар газар дээрээс нь сурвалжлага бэлтгэн иргэдэд хүргэлээ. СӨХ-ын цуврал контентыг эхлүүлж эхний дугаарыг иргэдэд хүргээд байгаа бөгөөд нийт 8 цуврал нэвтрүүлгийг иргэдэд хүргэхээр төлөвлөн ажиллаж байна.	
127	2.3.2.Багануур дүүргийн талаарх судалгааны ажлыг холбогдох байгууллагатай хамтран хийнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.2.1.2)	20.0	Судалгаа хийх тоо	-	1	Дүүргийн нэвтэрхий толийг зохиох ажлын хүрээнд ШУТИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн сургуультай хамтран ажиллах Санамж бичиг байгуулж, судалгааны агуулга, бүтцийг боловсруулсан. Ирэх онд төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	40%
128	2.3.3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%	85%	Төрийн цахим үйлчилгээний зохицуулах газраас Shillen.gov.mn сайтад мэдээлэл байршуулах талаар зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 52 мэргэжилтнүүд болон холбогдох албан тушаалтнууд хамрагдсан. Shillen.gov.mn цахим хуудсанд шаардлагатай мэдээллүүдийг байршуулж байгаа бөгөөд энэ оны 2-р улирлын байдлаар 70 хувьтай үнэлэгдсэн бол 3-р улирлын байдлаар 81,0 хувьтай үнэлэгдлээ. Дүүргийн	95.3%

						Засаг даргын харьяа байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангуулахад хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд Тухайлбал ХААА, БТСХ, Усан спорт боулингийн төв, Багануурын Залуус төв ААТҮГ, ШШГХ, ХХҮХ, Нийгмийн даатгалын газар, Эрүүл мэндийн төв, ҮТП, ХГБХХХ зэрэг байгууллагуудын shilen.ub.gov.mn цахим хуудсыг хариуцдаг мэргэжилтнүүдэд мэдээлэл байршуулах эрх нээж, зөвлөмж чиглэл өгч ажиллаж байна. Засаг даргын Тамгын газрын харьяа 8 байгууллага буюу Худалдан авах ажиллагааны алба, Дотоод аудитын алба, Усан спорт боулингийн төв, Багануур тохижилт ААТҮГ, Багануур-Ус ААТҮГ, Багануурын залуус төв ААТҮГ, Соёлын ордон, Теле камерын хяналтын дэд төв ОНТҮГ бүгд сайт байхгүй ба сайттай болох талаар чиглэл хүргүүлээд байна.	
129	2.3.4.Байгууллагын компьютер, программ хангамж, дотоод сүлжээний төхөөрөмж, техник хэрэгсэл, цахим хуудасны хэвийн ажиллагааг хангаж, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	-	Хороонд ажиллах тоо	43	45	Мэргэжилтнүүдийн компьютерийн хэвийн, тасралтгүй ажиллагааг хангах үүднээс HDD хадгалах төхөөрөмжүүдийг сайжруулж SSD болгосон. Жилийн эцсийн	100%

			Техник тоног төхөөрөмжийн бэлэн байдал	Хэвийн үйл ажиллагаа хангагдсан.	Хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	байдлаар 23 компьютерт SSD нэмж байршуулсан бөгөөд SSD байршуулснаар компьютер асах, программ нээх, интернет хөтөч дээр ажиллах үед гацалт хоцрогдол буурсан үзүүлэлттэй байна. Мөн 14 ш 19 инч дэлгэцийг 24 инч болгон томруулж зэрэг олон цонх нээн ажиллах боломжтой болсон. Тухайлбал: HDD-тэй үеийн асах хурд 8-10 мин байсан бол SSD тавьснаар 50 секунд дотор компьютер бүрэн асдаг болсон. Мөн үйлдлийн системүүдийг Windows 11 Pro 24H2 болгон шинэчилсэн. Мэргэжилтнүүд болон хороодын хэсгийн ахлагч, зохион байгуулагч, бичиг хэргийн ажилтнуудтай 46 удаа биечлэн уулзаж, 23 удаа цахимаар холбогдон тулгамдсан асуудлыг дор бүр нь шийдвэрлэж ажиллалаа. Засаг даргын Тамгын газрын веб хуудасны цэснүүд, ковер зураг, өмнөх онуудын мэдээллийг шинэчлэн байршуулсан.	
--	--	--	--	--	---	--	--

130	2.3.5.Засаг даргын Тамгын газраас боловсруулсан баримт бичгийг стандартын дагуу хөтлөх, хэвлэмэл хуудсанд буулгах, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем (Edoc)-ийн ашиглалтыг ханган ажиллаж, хяналт тавина.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Захирамжлалын баримт бичгээс А захирамж-319, Б захирамж-36, ДЗДТГ-ын даргын А тушаал-48, Б тушаал-127, нийт 530; Зохион байгуулалтын баримт бичгээс ААТ-41, НХХ-156, СТСХ-156, ТЗУХ-318, ТНААХ-403, ХХҮХ-155, АХ-92, ЦШ-6, Удирдлага-6 нийт 1333 албан бичиг, Мэдээлэл лавлагааны баримт бичгээс тодорхойлолт 26, нийт 1889 баримт бичгийг стандартын дагуу хэвлэмэл хуудсанд буулгаж, 1333 албан бичгийг программаар стандартыг хангуулж ажилласан. Төрийн албан хэргийг 2025 оноос хос бичгээр хөтлөхтэй холбогдуулан Засаг даргын Тамгын газрын захирамж, тушаал, албан бичиг нийт 1863 баримт бичгийг Монгол бичигт хөрвүүлж мөн программд оруулж ажилласан.	100%
131	2.3.6.Засаг даргын Тамгын газрын албан бичгийн шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, edoc системийн зөрчлийг бууруулна.	-	Системийн зөрчлийн тоо	121	60	Дээд байгууллагаас ирүүлсэн 16 тогтоол, шийдвэрийг бүртгэл хяналтын карт хөтөлж, бүртгэн удирдлагад танилцуулж, цохолт хийлгүүлж Эрх зүйн асуудал, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. Засаг даргын Тамгын газарт байгууллага, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн нийт 3141 албан бичгийг хүлээн авч, удирдлагууд руу шилжүүлсэн.	76.6%

						Нийт 3141 бичиг ирснээс 319 хариутай, 2822 хариугүй бичиг байна. Бичгийн шийдвэрлэлт 98 хувь, шийдвэрлэлтийн дундаж хоног 4,48 байна. Үүнээс СТСХ нийт 610 бичгээс хугацаа хэтрүүлсэн бичиг 2, НХХ нийт 439 бичгээс хугацаа хэтрүүлсэн бичиг 1, ТНААХ нийт 733 бичгээс хугацаа хэтрүүлсэн бичиг 1, ХХҮХ нийт 218 бичгээс хугацаа хэтрүүлсэн бичиг 12, ТКХДТ нийт 40 бичгээс хугацаа хэтрүүлсэн бичиг 1, ТЗУХ нийт 809 бичгээс хугацаа хэтрүүлсэн бичиг 2, ААТ нийт 38 бичгээс хугацаа хэтрүүлсэн бичиг 1, Удирдлагууд нийт 82, ЦШ нийт 8, АХ нийт 164 бичгээс хугацаа хэтрүүлсэн бичиг байхгүй байна. Нийт хугацаа хэтрүүлсэн бичиг 20 байна. Шийдвэрлэх хугацааны зөрчил 2, Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил буюу явцын тэмдэглэл хөтлөөгүй 69 зөрчил, Систем ашиглалтын 2 зөрчил, Стандартын 1 зөрчил нийт 74 зөрчилтэй байна. Хугацаа хэтэрсэн албан бичиг өмнөх онд 27 байсан бол энэ онд 20 болж 26 хувиар буурсан, зөрчил өмнөх онд 136 байсан бол энэ онд 74 болж 46 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
132	2.3.7.Төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд сурталчилж, шаарлагатай эх бэлтгэл хийнэ.	-	Бэлтгэх эхийн тоо	150	160	Тэмдэглэлт өдөр болон байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай сошиал постер,	100%

						баннер 290 ширхэг, хэвлэлийн эх 80 ширхэг, үйл ажиллагааны цахим урилга 20 ширхэг, видео мэдээг 110 удаа бэлтгэн ажиллалаа.	
Зорилт 2.4.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, ил тод байдлыг хангаж хэрэгжилтэд хяналт тавина.							
133	2.4.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хагас бүтэн жилээр нэгтгэн гаргаж Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн Төрийн аудитын газарт хүргүүлнэ.	-	Тайлангийн тоо	2	2	2024 оны жилийн эцэс, 2025 оны хагас жилийн санхүүгийн тайлан балансыг шалган хүлээн авч Е тайлангаар нэгтгэн, Нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн.	100%
134	2.4.2.2024 оны жилийн эцсийн санхүүгийн төсвийн гүйцэтгэлийг Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулж батлуулна.	-	ИТХ-өргөн барих тоо	1	1	2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийг 2025 оны 06 дугаар сарын 06 ны өдрийн ИТХ-ын тогтоолоор орлогыг 34,119,347,200.92 мөнгөөр, зарлагыг 31,025,124,157.35 мөнгөөр батлав.	100%
135	2.4.3.Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг И-Баланс системээр цахим хэлбэрээр хүлээн авч, хянан баталгаажуулна.	-	Тайлангийн ирцийн хувь	90%	80%	Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн И-баланс цахим системээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нийт 768 байгууллагаас 702 байгууллага ирүүлж тайлангийн ирц 91.4 хувьтай байна. Цахимаар ирүүлсэн тайланг 100 хувь баталгаажуулсан.	100%
136	2.4.4.Дүүргийн орлого, зарлагын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг боловсруулан фискал базад	-	Хүргүүлэх нэгтгэлийн тоо	1	1	Орон нутгийн төсвийн орлогын 2026 оны төсөл, 2027-2028 оны төсөөллийн саналыг боловсруулж, 2025 оны 07	100%

	байгууллага бүрээр шивж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ.					дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Зарлагын төсвийн төсөөллийг боловсруулан 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 01/856 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.	
137	2.4.5.Засаг даргын захирамжаар батлагдсан дүүргийн 2025 оны төсвийн сар, улирлын хуваарийг төсвийн төлөвлөлтийн фискал программд байгууллага, эдийн засгийн ангилал бүрээр шивж нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Батлагдсан төсвийн хуваарийг төсвийн төлөвлөлтийн Фискал программд байгууллага тус бүрээр эдийн засгийн ангиллаар бүрэн шивж нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлж, зарцуулалтын эрхийг нээлгүүлсэн.	100%
138	2.4.6.Төсвийн тухай хуулийн болон бусад холбогдох хууль, журам, тогтоолын дагуу шаардлага үүссэн тохиолдолд төсвийн тодотголын төслийг боловсруулан дүүргийн ИТХ-р хэлэлцүүлэх, батлуулах, батлагдсан төсвийн дагуу төсвийн сар улирлын хуваарийг боловсруулан Засаг даргаар батлуулах, программд шивж оруулна.	-	Төсвийн нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэрэгжилтийн хувь	100%	100%	Нийслэлийн төсөвт тодотгол хийсэнтэй холбоотойгоор орон нутгийн төсөвт байгууллагуудаас саналыг авч холбогдох хууль журам засгийн газрын тогтоолууд болон суурь судалгаанд үндэслэн дүүргийн 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулан дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 06-ны №10 дугаар тогтоолоор, 11дүгээр сарын 24-ний өдрийн №14 дугаар тогтоолоор тус тус батлуулсан.	100%

139	2.4.7.Дүүргийн 2026 оны төсвийн төлөвлөгөөний төслийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж батлуулна.	-	Хэрэгжих ажлын тоо		1	Дүүргийн 2026 оны төсвийн талаар нээлттэй хэлэлцүүлгийг 2025 оны 12 сарын 4-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	-
Зорилт 2.5.Цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулж, бэлтгэлжилтийг хангана.							
140	2.5.1."Цугларах, Шилжүүлэх" байрын томилгоот бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулна.	Үйл ажиллаг ааны зардал	Зохион байгуулах сургалтын тоо	2	4	"Цугларах, Шилжүүлэх" байрын томилгоот бүрэлдэхүүний тодотголыг хагас бүтэн жилээр 2 удаа хийж, сургалтыг улирал бүр хийж үр дүнг тооцон ажилласан.	100%
141	2.5.2."Монгол цэргийн өдөр", Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.	5.5	Зохион байгуулах арга хэмжээний тоо	4	5	Цэргийн штабаас "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 104 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхээр дүүргийн Засаг даргын захирамж, зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын "Нэгдсэн тооллого" болон алба хаагчдын хамтарсан "Мөрдөстэй аялгуу" нэгдсэн тоглолтыг тус тус зохион байгуулсан. Ерөнхий боловсролын дунд ангийн сурагчдын дунд "Зэвсэгт хүчин миний төсөөлөл"-өөр гар зургийн уралдаан ахлах ангийн сурагчдын дунд "Бид эх орны ирээдүй" сэдэвт эссэ бичлэгийн	100%

						уралдаан, Багануур дүүрэг дэх Бага дарга нарын холбооны салбар зөвлөлийн гишүүдийн дунд буудлагын бооцоот тэмцээнийг тус тус зохион байгуулсан.	
Зорилт 2.6.Дүүргийн архивын сан хөмрөгийг түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой баримтаар нөхөн баяжуулна.							
142	2.6.1.Дүүргийн архивын сан хөмрөгийг нөхөн баяжуулна.	-	Нөхөн баяжилт хийх байгууллагын тоо	9	13	Дүүргийн архивд нөхөн баяжилт хийх төлөвлөгөөний дагуу 1 дүгээр улиралд нөхөн баяжилт хийх 5 байгууллагын 37 хадгаламжийн нэгжийн баримтыг дүүргийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр хуралдаанаар хэлэлцэж баталсан. 2025 онд дүүргийн архивд нөхөн баяжилт хийх Багануур дүүргийн Татварын хэлтэс, Боловсролын хэлтэс, 3 дугаар хороо, Улаан загалмай хороо, Энэрэл-Өлзий өрхийн эрүүл мэндийн төв, Ач Элбэрэл өрхийн эрүүл мэндийн төв, Энх-Өрх өрхийн эрүүл мэндийн төв, Нийслэлийн ерөнхий боловсролын Оюун-Эрин сургууль, Багануур дүүргийн 241 дүгээр цэцэрлэг, нийт 9 байгууллагын 1984-2023 оны баримтыг дүүргийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2025 оны 12 дугаар сарын 02 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан.	100%

143	2.6.2.Дүүргийн 1-5 дугаар хорооны мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн 2024 оны тооллогын баримтаар дүүргийн архивд цаасан нөхөн баяжилт хийнэ.	-	Нөхөн баяжилт хийх баримтын тоо	35	Дүүргийн 5 хорооны 2024 онд үүссэн баримтаар нөхөн баяжилт хийсэн байна.	Дүүргийн 5 хорооны Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2024 оны тооллогын 37 хадгаламжийн нэгжээр дүүргийн архивд нөхөн баяжилт хийсэн.	100%
144	2.6.3.Дүүргийн Архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулах хурлын тоо	1	2	2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр дүүргийн Архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг зохион байгуулсан. 2025 оны 12 дугаар сард дүүргийн архивд нөхөн баяжилт хийх 9 байгууллагын цаасан суурьт баримтыг хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан.	100%
145	2.6.4.Захирамжлалын баримтаар цахим нөхөн баяжилт хийнэ.	-	Захирамжлалын баримтаар цахим нөхөн баяжилт хийх байгууллагын тоо	38	39	Төлөвлөгөөт 39 байгууллагаас 1 байгууллагад захирамжлалын баримт үүсээгүй. Хөмрөг үүсгэгч 38 байгууллагын 85 хадгаламжийн нэгжийн 4,446 захирамжлалын баримтын 7,901 хуудсыг батлан шалгасан.	100%
146	2.6.5.Архивын цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.	-	Төрийн архивын системд батлан шалгах баримтын тоо	6 хөмрөгийн 89 хадгаламжийн нэгжийн 14,445 хуудас баримтыг	Засаг даргын Тамгын газрын 1995-2005 оны 11 хадгаламжи	1.Засаг даргын Тамгын газрын 1995-2005 оны 11 хадгаламжийн нэгжийн 1175 баримтын 1,863 хуудас, 2006-2010 оны 20 хадгаламжийн нэгжийн 3,818	100%

				цахим хэлбэрт шилжүүлж ашиглалтын хуулбар хувь үйлдсэн	йн нэгж, 2006-2010 оны 26 хадгаламжийн нэгжийн баримтад батлан шалгалт хийж цахимжаагүй баримтуудад ашиглалтын цахим хувь үйлдэнэ.	хуудас баримтыг батлан шалгасан. 2.2009-2012 оны 1-5 дугаар хорооны Мал, тэжээвэр амьтан, хашаа худгийн тооллогын 1 дүгээр маягтын 16 хадгаламжийн нэгжийн 2,592 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн. Нийт 47 хадгаламжийн нэгжийн 8,273 хуудас баримтыг батлан шалгалт хийж, цахимжаагүй баримтуудад ашиглалтын цахим хувь үйлдсэн.	
147	2.6.6.Хэлтэс албадын гэрэл зургийн тусгай төрлийн баримтыг зохион бүрдүүлнэ.	-	Зохион бүрдүүлэх баримтын тоо	-	Гэрэл зургийн цомог үүссэн байна.	Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын бүтцээр гэрэл зургийн цомог үүсгэх ажлын хүрээнд албан хаагчдаас 30 ширхэг зураг, мэдээлэл цуглуулж гэрэл зургийн цомог үүсгэсэн.	100%
3 ДУГААР ХЭСЭГ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД							
Зорилт 3.1.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх. (Хариуцлагын гэрээний 3.1.1)							
Зорилт 3.1.1.Дүүргийн хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт хийж, ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулна. (МУ-н 33НДНТУТХуулийн 25.1.1, Хариуцлагын гэрээний 3.1.1)							
148	3.1.1.1.Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, Багануур хотыг хөгжүүлэх ТЭЗҮ, үзэл баримтлал (концепц), ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	Улсын төсөв	Төлөвлөгөө батлуулах ажлын хувь	10%	100%	Багануур, Багахангай, Налайх хотуудыг хөгжүүлэх ТЭЗҮ, үзэл баримтлал /концепц/, ерөнхий төлөвлөгөө төсөл, арга хэмжээний зөвлөх	-

						үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер 2024-2025 онд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд зарлагдаж, зөвлөхөөр СЭЗИС, UDC компанийн түншлэлийн баг шалгарсан. Зөвлөх үйлчилгээний багийн бүрэлдэхүүн 2025 оны 07 дугаар сард дүүрэгт ажиллаж, ГЗБА болон дүүргийн удирдлагуудтай уулзаж, харилцан мэдээлэл солилцсон. Мөн 2025 оны 10 дугаар сарын 15-нд зөвлөх багийн бүрэлдэхүүн дүүрэгт ажиллаж, холбогдох хэлтэс, албадаас шаардлагатай мэдээллүүдийг авч, хамтран ажиллаж байна.	
Зорилт 3.1.2. Дүүргийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд хяналт тавина. (МУ-н 33НДНТУТХуулийн 25.1.2, Хариуцлагын гэрээний 3.1.1)							
149	3.1.2.1.-СТСХ Нийслэлийн өмчийн харилцааны газартай хамтран өмч эзэмшүүлэх гэрээ сунгах, гэрээ байгуулах, гэрээ дүгнэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах, дүүргийн хэмжээний нийслэлийн өмчит байгууллагуудын Umch.sgov.mn программд өмчийн тайлан тайлагнасан байдалд хяналт тавих.	-	Зохион байгуулах ажлын тоо	2	2	1.Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын тушаалаар орон нутгийн болон төсөвт 36 байгууллагад өмч эзэмшүүлэх гэрээг байгуулсан ба нийслэлийн өмчийн гэрээ дүгнэх ажлыг Нийслэлийн өмчийн харилцааны газраас 12 дугаар сарын эхэнд төлөвлөсөн байсан боловч санхүүгийн эх үүсвэргүй болсон тул хийгдээгүй байна. 2.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Нийслэлийн өмчийн харилцааны газраас өмчийн	90%

						программ шинэчлэгдэж байгаатай холбогдуулан “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем”-ийг нэвтрүүлэхээр дүүргийн 50 байгууллагад сургалт зохион байгуулсан ба улсын хэмжээнд хуучин системээс шинэ системрүү дата бааз хөрвүүлэх ажил хийгдэж байна.	
Зорилт 3.1.3.Дүүргийн төсвийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, төсвийн сахилга батыг сайжруулна. (МУ-н 3ЗНДНТУТХуулийн 25.1.3, Хариуцлагын гэрээний 3.1.1, ДЗДҮАХ ХАХТ-3.1)							
150	3.1.3.1.Татвар төлөгч хуулийн хугацаанд татвараа төлөх зан хандлага, соёлыг хэвшүүлэх, сайжруулах үйл ажиллагаа (мэдээллээр хангах, зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, хариуцлага тооцох)-г татвар төлөгчийн хууль тогтоомж мөрдөлтийн түвшинд хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-3.1.1.1)	-	Масс мэйл, мессеж хүргэх ажлын гүйцэтгэлийн хувь	15%	25%	Татвар төлөгч татварыг хуулийн хугацаанд төлөх зан хандлага, соёлыг хэвшүүлэх зорилгоор нийт 11250 татвар төлөгчийн гар утсанд 12800 удаагийн масс мессежээр мэдээлэл хүргэсэн ба нийт бүртгэлтэй татвар төлөгчийн 31 хувьд хүрсэн. Үүнд: -Хуульд заасан хугацаанд тайлангаа гаргах ирүүлэхийг сануулсан - 4920 -Татварын хуулийн хэлэлцүүлэгт оролцохыг уриалсан - 1488 -Хугацаа хэтэрсэн татварын өр төлүүлэхээр анхааруулсан - 5192 -Төлбөрийн баримт олгохыг сануулсан, талархсан, анхааруулсан - 1200 -Татварын хууль тогтоомжийн зөвлөгөөг ажлын байраар 3096, утсаар 1800 нийт 4896 татвар төлөгчид өгч ажилласан.	100%
151	3.1.3.2.Татвар төлөгчдийн татварын хууль тогтоомжийн талаарх сургалт, сурталчилгаа	-	Сургалтад хамрагдах	1200 250	1250 260	Тайлант хугацаанд татварын хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд 39 удаагийн	100%

	мэдээллийг сегментийн ангиллын дагуу зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.1.1.2)		иргэн, ААНБ-н тоо			сургалтаар 1664 татвар төлөгчийг хамруулсан. Үүнд: Жижиг сегментийн 138 татвар төлөгчид 6 удаа, бичил сегментийн 166 татвар төлөгчид 7 удаа, бичил иргэн сегментийн 1360 татвар төлөгчид 26 удаа сургалт зохион байгуулсан. Татварын шинэчлэл-2025” хэлэлцүүлэг арга хэмжээг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, бичил сегментийн 606 иргэн, жижиг, бичил сегментийн 175 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулсан. “Багануур дүүргийн Татварын хэлтэс” фэйсбүүк пэйж хуудсаар цахим видео хичээл, мэдээ мэдээлэл, цахим сургалт, постер зэрэг нийт 192 мэдээллийг түгээснээр 34200 хүнд хүрч, 5307 хүн лайк дарж сонирхон үзэж, 802 удаа түгээж ажилласан. АТБӨЯТХ-ийн албан татвар төлөх заавар бичлэгийг 7 хоног бүр тогтмол давтамжтай 25 удаа нийтэлж ажилласан.	
152	3.1.3.3.Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг сар, улирлаар жигд биелүүлэх ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.1.1.3)	-	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого сая төгрөг	4,718.3	4,918.3	Тайлант онд улс, нийслэл, орон нутгийн төсөвт 32,559.7 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 11 сарын 27-ны өдрийн байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр 32,158.5 сая төгрөгийн орлого	98.8%

			Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого сая төгрөг	1,494.3	1,615.3	төвлөрч, 98.8 хувийн биелэлттэй байна. Үүнд: Улсын төсөвт 4,356.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 4,222.4 сая төгрөг төвлөрүүлж 96.9 хувь; Нийслэлийн төсөвт 2,208.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,344.7 сая төгрөг төвлөрүүлж 106.1 хувь; - Дүүргийн төсөвт 25,994.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 25,591.4 сая төгрөгийг төвлөрүүлж 98.4 хувийн биелэлттэй байна.	
			Дүүргийн төсөвт төвлөрүүлэх орлого сая төгрөг	23,142.4	24,564.6		
153	3.1.3.4.Татварын хууль тогтоомжоор татвар төлөгчид эдлүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд татвар төлөгчийг хамруулж ажиллана. (ДЗДҮАХ ХАХТ-3.1.1.4)	-	Хамруулах аж ахуйн нэгж байгууллагын тоо	7	15	2024 оны жилийн эцсийн тайлангаар 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн татварын тайланд гаргаж буцаан олгох хүсэлт гаргасан 10 татвар төлөгч ААНБ-ын тайланг хянаж үзээд 72.3 сая төгрөгийг буцаан олгохоор Татварын хэлтсийн даргын 2025 оны А/06 дугаар тушаалаар баталсан. Татварын ерөнхий газрын Татварын орлогын бүртгэл, буцаан олголтын хэлтсээс татвар төлөгчид буцаан олголтыг бүрэн олгоод байна. Мөн хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу хөнгөлөлт эдлэх хүсэлт гарган ирүүлсэн 822 иргэний тайланг хянаж үзээд 789 иргэний тайланг хөнгөлөлт үзүүлэхээр хүлээн авсан. Татварын хэлтсийн даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/07 дугаар	83.3%
			Хамруулах хувь хүний тоо	692	710		

						тушаалаар 789 татвар төлөгчид 1,483.3 сая төгрөгийн хөнгөлөлт эдлүүлэхээр баталж 4 дүгээр сард багтаан татвар төлөгчдөд буцаан олгосон.	
Зорилт 3.1.4.Хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал. (МУ-н 33НДНТУТХуулийн 25.1.4, Хариуцлагын гэрээний 3.1.1)							
154	3.1.4.1.Хууль тогтоомжид заасан хүрээнд төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтооно.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	Шаардлагат ай тохиолдолд хувь хэмжээг тогтоосон байна	Монгол Улсын Засгийн газрын 132 дугаар тогтоолын дагуу төлбөр хураамжийн хувь хэмжээг тогтоох нөхцөл үүсээгүй.	-
Зорилт 3.1.5.Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт. (МУ-н 33НДНТУТХуулийн 25.1.5, Хариуцлагын гэрээний 3.1.1)							
155	3.1.5.1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлтийг иргэдийн саналд тулгуурлан эрэмбэлэх, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барина.(ДЗДҮАХ ХАХТ-3.1.5.1)	3.0	Иргэдийн саналын тоо	21841	25000	2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд иргэдийн саналыг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд цахим болон цаасан хэлбэрээр авч нэгтгэж эрэмбэлэн хороодын ИНХ-аар хэлэлцэн баталгаажуулан ЗДТГ-т ирүүлсэн. 2026 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт 30 төсөл арга хэмжээнд 34,487 санал ирүүлсэн байна.	90%

156	3.1.5.2.Улс, нийслэл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжигдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөн саналыг дээд байгууллагад хүргүүлнэ.	-	Хүргүүлэх саналын тоо	2	2	Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Сангийн яамны https://pimis.publicinvestment.gov.mn/ цахим системээр болон ЗДТГ-ын даргын 04-р сарын 30-ны өдрийн 04/446 дугаартай албан бичгээр, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг иргэд, ААН байгууллагуудаас авч байна. Холбогдох дээд шатны байгууллагад 07-р сарын 04-ний өдрийн 04/788 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.	100%
157	3.1.5.3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг иргэдийн саналд тулгуурлан эрэмбэлнэ.	-	Хэрэгжүүлэх ажлын тоо	18	18	ОНХС-ийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд иргэдийн саналыг 2025 оны 04 дүгээр сарын 15-аас 06 дугаар сарын 15-ны хүртэл хугацаанд цахим болон цаасан хэлбэрээр авч нэгтгэж эрэмбэлэн хороод ИНХ-аар хэлэлцүүлэн баталгаажуулж ЗДТГ-т ирүүлсэн. Хороодоос ирүүлсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхэд нийт 30 төсөл арга хэмжээнд 34,092 санал ирүүлсэн байна. 12 дугаар сарын 02-ны өдөр ажлын хэсгийн хурал хуралдаж Засаг	90%

						даргын зөвлөлийн хурлаар оруулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.	
158	3.1.5.4.Дүүргийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тус тус хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу санхүүжүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	Журмын дагуу санхүүжүүлсэн	Журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	12-р сарын 01-ний өдрийн байдлаар дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 20 төсөл арга хэмжээний 3,617.2 сая төгрөгийн, ОНХС-ийн хөрөнгөөр 12 төсөл арга хэмжээний 3,802.2 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг журмын дагуу тус тус нээсэн.	100%
159	3.1.5.5.Орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээр санхүүжих хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулна.	-	Төсөл, арга хэмжээний тоо	111	144	Дүүрэгт улс, нийслэл, дүүргийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 93 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ба үүнээс он дамжин хийгдэж байгаа 44 ажлаас 20 ажил хийгдэж дууссан. 5-85%-н гүйцэтгэлтэй, 24 ажил хийгдэж дууссан. Нийслэлээс худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн болон ОНХС, ДТХО-аар хэрэгжүүлэх 49 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна. Улсын төсвөөр шинээр 6 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ба 12-р сарын 01-ний өдрийн байдлаар 6 төсөл арга хэмжээ 2025-2026 он дамжин санхүүжигдэх Багануур тойрог авто зам (14.4 км), Багануур дүүрэг дэх Шүүхийн барилга ШЕЗ/20250101033/01/01, Ахуйн	100%

						бохир ус цэвэрлэх байгууламж /Улаанбаатар Багануур дүүрэг/ ХББОСЯ/20250101026/01/01, Нарийн нуур, Булагтай хэсгийн цахилгаан хангамжийн ажлууд энэ оны ажлууд хийгдсэн. Багануур хотын гэр хорооллын инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах ажил, Багануур хотын Дулааны станцын өргөтгөлийн зураг төсөв боловсруулах 2 ажил хийгдэж байна. Нийслэлийн төсөв, ОНХС-аар шинээр 7 төсөл арга хэмжээ хэрэгжүүлж байгаагаас Нийтийн тээврийн гарааш барих, БҮТП-ын дэд станцын 110/35/10 кВ ажлууд 2025-2026 он дамжин хийгдэнэ. БЦС-ийн хичээлийн 2-р байрны гадна тохижилтын ажил, БНД 3 дугаар хороо, Эрчим хотхоны ус, дулаан дамжуулах төвийн тоног төхөөрөмж худалдан авах ажлууд 50% гүйцэтгэлтэй, Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил, Авто замын байгууламжийн засвар арчлалт шинэчлэлт, БНД 3 дугаар хороо, 81 дүгээр байрны гадна инженерийн шугам сүлжээг шинэчлэх ажлууд хийгдэж дууссан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон МТТАТ-ын орлогоор санхүүжих шинээр 10 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс 20-80%-ийн	
--	--	--	--	--	--	---	--

						гүйцэтгэлтэй 4 ажил, 100%-ийн гүйцэтгэлтэй 4 ажил байна. МТТАТ-ын орлогоор хийгдэх 3 ажил буюу Инженерийн хийцтэй гүний худаг гаргах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдад зориулсан сургалт зохион байгуулах ажлууд бэлтгэл ажил хийгдэж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 25 төсөл арга хэмжээнээс ажил хийгдэж дууссан-6, 10-56%-н гүйцэтгэлтэй хийгдэж байгаа-15, тендер дахин зарлаж байгаа- 4 ажил байна.	
Зорилт 3.1.6.Худалдаа, үйлчилгээний зөвшөөрөл өгч, хяналт тавина. (МУ-н 33НДНТУТХуулийн 25.1.6, Хариуцлагын гэрээний 3.1.1)							
160	3.1.6.1.Онлайн бизнес төвийн Үйлчилгээ эрхлэх бүртгэлд дүүргийн худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, зочлох үйлчилгээний салбаруудыг бүртгүүлж, хяналт тавьж ажиллана.	-	Бүртгүүлэх бүртгэлийн тоо	40	40	Худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэлтийг бүртгэх “Онлайн бизнес төв”-д нийт 41 үйлчилгээ эрхлэх бүртгэлийн хүсэлтийг бүртгэж, хяналт тавьж ажилласан. Үүнд: Хоол үйлдвэрлэл-8, Худалдааны-12, Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл 5, Үйлдвэрлэлийн чиглэлээр-10. Ахуйн үйлчилгээний чиглэлээр-3, Тоглоомын төв-3	100%
Зорилт 3.1.7.Нийслэлийн үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. (МУ-н 33НДНТУТХуулийн 25.1.7, Хариуцлагын гэрээний 3.1.1)							

161	3.1.7.1.Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд иргэдэд зөвлөн туслах, чадавхжуулах үйлчилгээ үзүүлж хоршоодын тоог нэмэгдүүлнэ.	ДТ 2.5	Хамрагдах хүний тоо	100	60	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд дүүргийн хэмжээнд шинээр 4 хоршоо байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 3 хоршооны 10 гаруй гишүүд нийт 450,0 сая төгрөгийн зээлд хамрагдсан. Хоршоо байгуулах хүсэлтэй малчдад шинэ хоршоо хөдөлгөөний талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, гарын авлага, мэдээ мэдээллийг өгч ажиллаж байна. Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ, Дани-Монголын нийгэмлэгтэй хамтран Данийн Вант Улсын “CISU-Иргэний нийгмийн хөгжлийн нэгдсэн байгууллага” хариуцлагатай, тогтвортой хоршоо орон нутгийн төсөл хэрэгжүүлэгч “Сод боломж” бизнес хөгжлийг дэмжих төвийн захирал Х.Тодцэцэгтэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд хоршоог хэрхэн хөгжүүлэх, төсөл хэрхэн бичих талаарх сургалтыг зохион байгуулж 20 гаруй иргэдийг хамруулсан.	100%
			Нэмэгдүүлэх хоршооны тоо	-	1		
Зорилт 3.1.8.Дүүргийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг хийнэ. (МУ-н ЗЗНДНТУТХуулийн 25.1.8, Хариуцлагын гэрээний 3.1.1, ДЗДҮАХ ХАХТ- 2.1.6)							
162	3.1.8.1.Эрүүл мэндийн төвийн дотор их засварын ажлыг үе шаттай хийнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.6.1)	ДТ 379.3	Их засварын ажлын гүйцэтгэлийн хувь	10%	100%	Эрчимт эмчилгээний тасгийн дотор засварыг хийхээр төсвийг салгуулж, ажлын даалгаврыг боловсруулж ХААА-нд хүргүүлэн 8 удаа тендер зарлан амжилтгүй болж, дахин зарлаж 08 дугаар сарын	80%

						21-ний өдөр нээж, гүйцэтгэгчээр “Стар нест” ХХК шалгарч хана нураалт, өрлөг, шал цутгалт, цэвэр бохир ус, агааржуулалт, хаалга, цонхны ажлууд хийгдсэн. Одоогоор дотор заслын ажлууд хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 80%	
163	3.1.8.2.Энх-Өрх ӨЭМТ-ийн барилгыг ажлыг үргэлжлүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.6.2)	Ут 539.5	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	40%	70%	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг “Преспектив шийдэл” ХХК он дамжин гүйцэтгэж байна. Энэ онд гадна дотор шавар, чулуун замаск, цонх, гадна хаалга, шилэн фасад, дээвэр, дотор шал, агааржуулалт, цахилгаан холбооны монтаж, гадна, дотор цэвэр, бохирын шугамын ажил хийгдэж дууссан. Одоогоор гадна дулаан, цэвэр усны ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 70%-тай.	100%
164	3.1.8.3.Нэг, гуравдугаар хорооны ӨЭМТ-үүдийг нэгтгэх ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.6.3)	-	Хэрэгжилт	-	1 ӨЭМТ-тэй болсон байна.	Нэг, гуравдугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нэгтгэх асуудлаар нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлыг хуралдуулж, хурлаас гарсан шийдвэрийг 09 дүгээр сарын 26-ны өдрийн дотор ирүүлэх тухай дүүргийн Засаг даргын 09 дүгээр сарын 17-ны өдрийн 01/996 дугаартай албан бичиг хүргүүлсэн бөгөөд бүх гишүүдийн хурлын 100%-ийн саналаар нэгдэх боломжгүй тухай албан бичиг ирүүлсэн.	-

165	3.1.8.4.Нэг, гуравдугаар дугаар хорооны ӨЭМТ-ийн барилгын зураг төсвийг боловсруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.6.4)	ДТ 82.5	Барилгын зураг төсвийн гүйцэтгэлийн хувь	0%	100%	Нэг, гуравдугаар хорооны ӨЭМТ-ийн барилгын холболтын зураг төсөв боловсруулах хөрөнгийг төсвийн тодотголд тусган шийдвэрлэж, зургийн даалгаврыг боловсруулж ХААА-нд хүргүүлэн тендер зарлаж “А И Си архитектс” ХХК шалгарч гэрээ байгуулан, газрын гэрчилгээг гаргуулан архитектур төлөвлөлтийн даалгаврыг гаргуулж, эскиз зураг хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 50%	50%
166	3.1.8.5.Биеийн тамир, спортын хорооны гадна засвар, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.2.3.1)	ДТ 619.8	Засвар, тохижилтын ажлын гүйцэтгэлийн хувь	10%	100%	Биеийн тамир, спортын хорооны гадна засвар, тохижилтын ажлын гүйцэтгэгчээр “Шайнинг хаус” ХХК шалгарч, бараа материалын татан авалт хийгдэж, ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 80%-тай.	80%
167	3.1.8.6.Хоёрдугаар хорооны 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.1)	УТ 154.4	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	90%	100%	Хоёрдугаар хорооны 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга 01 дүгээр сард комиссын дүгнэлт баталгаажиж, 03 дугаар сарын 10-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхлүүлж, 24 цагийн 3 бүлэг, 1 ердийн бүлэгт 73 хүүхэд хичээллэж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	100%

168	3.1.8.7.132 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн зураг төсвийг боловсруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.2)	ДТ 50.0	Зураг төсвийн гүйцэтгэлийн хувь	10%	100%	132 дугаар цэцэрлэгийн өргөтгөл буюу 100 ортой барилгын холболтын зураг төсвийг боловсруулах ажлын тендер дүүргийн ХААА-нд зарлаж, зохиогчоор “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК шалгаран гэрээ байгуулж, эскиз зургийг ХБХСГ-аар батлуулж, хангагч байгууллагуудаас холбогдох техникийн нөхцөлийг гаргуулан ажлын зураг төсвийг боловсруулж байна. Гүйцэтгэл 80%-тай.	80%
169	3.1.8.8.Гуравдугаар хорооны бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгыг ашиглалтад оруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.3)	УТ 3,230.8	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	65%	100%	Замчин хэсэгт бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын ажлыг “Буйлд мастер” ХХК он дамжин гүйцэтгэж байгаа бөгөөд гадна фасад, дотор өрлөг, засал, гадна шугам сүлжээний ажил хийгдэж дууссан. Ажлын явц 80%-тай	80%
170	3.1.8.9.193 дугаар цэцэрлэгийн гадна тохижилтын ажлыг хийнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.4)	ДТ 261.8	Тохижилтын ажлын гүйцэтгэлийн хувь	0%	100%	193 дугаар цэцэрлэгийн гадна тохижилтын ажлын төсөв 2021 оны төсөвтэй байсан тул тендер тухайн ажлын төсвийг шинэчлэх ажлыг “Бета энерги” ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа бөгөөд 11 дүгээр сарын 25-ны өдөр магадлалын дүгнэлтийг гаргуулан хүлээлгэн өгөөд байна.	30%

171	3.1.8.10.Суралцагчдын дотуур байрны зураг төсвийг боловсруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.5)	ДТ 150.0	Зураг төсвийн гүйцэтгэлийн хувь	0%	100%	Зураг төсөв боловсруулах хөрөнгийг төсвийн тодотголын саналд тусган шийдвэрлэж, тендер зарлан “Скайлайн дизайн” ХХК шалгарч, геологи хийлгэх, эскиз батлуулах шатанд байна. Гүйцэтгэл 30%-тай.	30%
172	3.1.8.11.131 дүгээр цэцэрлэгийн их засварын зураг төсвийг боловсруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.6)	ДТ 90.0	Зураг төсвийн гүйцэтгэлийн хувь	0%	100%	Зураг төсөв боловсруулах хөрөнгийг төсвийн тодотголын саналд тусган шийдвэрлэж, тендер зарлан “Очир огтлогч” ХХК шалгарч, засварын зураг төсвийг боловсруулж байна. Гүйцэтгэл 30%-тай.	30%
173	3.1.8.12.241 дүгээр цэцэрлэгийн хөрсний ус зайлуулах ажлыг хийнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.7)	ДТ 94.5	Ажлын гүйцэтгэлийн хувь	0%	100%	241 дүгээр цэцэрлэгийн хөрсний ус зайлуулах ажлын техникийн тодорхойлолт боловсруулж, ХААА-нд хүргүүлэн 7 удаа тендер зарлаж амжилтгүй болж, Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хөрөнгө татагдсан.	-
174	3.1.8.13.Боловсрол сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны гадна талбайн тохижилтыг хийнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.8)	НТ 3,232.6	Тохижилтын ажлын гүйцэтгэлийн хувь	10%	100%	Боловсрол сургуулийн хичээлийн 01 дүгээр байрны гадна талбайн тохижилтын ажлын тендер сонгон шалгаруулалтыг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар зохион байгуулж, “МГБИ” ХХК шалгарч гэрээ байгуулагдсан. 05 дугаар сарын 15-ны өдрөөс ажлыг эхлүүлж, явган зам, спорт талбай, бетон талбай, сандал,	100%

						хогийн сав, сүүдрэвч, торон хашаа, гэрэлтүүлэг, авто зам, зогсоолын ажлыг бүрэн хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	
175	3.1.8.14.Боловсрол сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны гадна фасад, засварын ажлыг дуусгана. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.9)	НТ 150.9	Фасад засварын ажлын гүйцэтгэлийн хувь	90%	100%	Боловсрол сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны гадна фасад, засварын ажил 2024 онд дууссан бөгөөд зураг төсөлд өөрчлөлт оруулж, магадлалаар хянагдаж баталгаажсанаар дахин комисс ажиллаж хүлээн авсан.	100%
176	3.1.8.15.Боловсрол сургуулийн хичээлийн 2 дугаар байрны өргөтгөлийн зураг төсвийг боловсруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.10)	ДТ 127.0	Өргөтгөлийн зураг төсвийн гүйцэтгэлийн хувь	80%	100%	Боловсрол сургуулийн хичээлийн 02 дугаар байрны өргөтгөлийн зураг төсвийг боловсруулахаар “Гидродизайн инноваци” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Өргөтгөлийн барилгын холбогдох техникийн нөхцөлүүдийг гаргуулж, боловсруулж, төгрөгийн төсөвт өртөг бүхий зураг төсвийг хүлээлгэн өгөөд байна.	100%
177	3.1.8.16.Оюуны-Эрин сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны гадна шугам сүлжээг шинэчилнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.11)	ДТ 197.6	Шугам сүлжээг шинэчлэх ажлын гүйцэтгэлийн хувь	10%	100%	Оюуны эрин сургуулийн хичээлийн 01 дүгээр байрны гадна шугам сүлжээг шинэчлэх ажлыг Багануур-Ус ААТҮГ гүйцэтгэж, 08 дугаар сард хүлээлгэн өгсөн.	100%
178	3.1.8.17.Гүн галуутай сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны ариун цэврийн өрөөнүүдийн засварыг хийнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.12)	ДТ 385.3	Засварын ажлын гүйцэтгэлийн хувь	10%	100%	Гүн галуутай сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны ариун цэврийн өрөөнүүдийн засварын ажлын тендерт “Повер Фрикүэнси” ХХК	100%

						шалгарч, гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж 08 дугаар сарын 29-ний өдөр комисс ажиллаж хүлээн авсан.	
179	3.1.8.18.Гүн галуутай сургуулийн хичээлийн 2 дугаар байрны дотор шугам сүлжээний засварыг хийнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.13)	ДТ 193.0	Шугам сүлжээг шинэчлэх ажлын гүйцэтгэлийн хувь	10%	100%	Гүн галуутай сургуулийн хичээлийн 02 дугаар байрны цэвэр бохир ус, дулааны засварыг “Калдератубо” ХХК хийж гүйцэтгэн, хүлээлгэн өгсөн.	100%
180	3.1.8.19.Ерөнхий боловсролын сургуулиудыг агаар цэвэршүүлэгчээр хангана. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.3.14)	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	100%	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүжилт хасагдсан.	-
181	3.1.8.20.850 хүний суудалтай Соёлын ордны барилгын ажлыг үргэлжлүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.4.1.3)	НТ 4,047.07	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	33%	63%	Соёлын ордны барилгын ажил он дамжин 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхэлж, 1 дүгээр давхрын цутгалтаа авч ажил зогссон. Ажлын явц 40 хувьтай.	63.5%
182	3.1.8.21.Д.Нацагдоржийн нэрэмжит номын санг засварлана. (ДЗДҮАХ ХАХТ-2.4.1.4)	ДТ 415.3	Засварын ажлын гүйцэтгэлийн хувь	10%	100%	Д.Нацагдоржийн нэрэмжит номын сангийн засварын ажлыг “Хан багана” ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгч, номын сангийн үйл ажилллагаа хэвийн явагдаж байна.	100%
Зорилт 3.1.9.Дүүрэг дэх авто зогсоолын арчилгааг хийнэ.(МУ-н ЗЗНДНТУТХуулийн 25.1.9, Хариуцлагын гэрээний 3.1.1)							
183	3.1.9.1.Дүргийн нийтийн эзэмшлийн зам, талбайн авто зогсоолын арчлалт хамгаалалтыг сайжруулна.	-	Арчлалт хийх талбайн хэмжээ м2	-	158300	Дүүргийн хог тээврийн үйлчилгээний байгууллага Багануур тохижилт ААТҮГ-ын 53 үйлчлэгч дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн 604,848м2 талбайг хариуцан ажилладаг ба 1 үйлчлэгчид 11,859м2 талбай ноогдож зун,	100%

						өвлийн график хуваарийн дагуу өдөр бүр арчлалт хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээг хийж байна. Цас орсон үед олон үйлдлийн бага оврын трактор, Автогрейдэр, Ковш, Зам талбайн цас шүүрдэгч машин-2 зэрэг нийт 6 техникээр замын цасыг цэвэрлэж ажиллаж байна.	
Зорилт 3.1.10.Нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалтыг хийнэ. (МУ-н 3ЗНДНТУТХуулийн 25.1.10, Хариуцлагын гэрээний 3.1.1, 3.7.12, ДЗДҮАХ ХАХТ- 4.4.2, 4.4.3)							
184	3.1.10.1.Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлж усалгаа, арчлалт, хамгаалалтын менежментийг сайжруулна. (ДЗДҮАХ ХАХТ-4.4.3.1)	БТ 90.0	Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ м ²	36	36.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлж усалгаа, арчлалт, хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд 645 ширхэг улиас модны хэлбэржүүлэлтийг хийж, 5600 уртааш метр ургамлан хашлаганы хэлбэржүүлэлт тайралтыг 7, 8, 9-р саруудад хийж, ногоон байгууламжийн 30,000 м ² талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, Мөн 15000 ширхэг нэг наст цэцгийг төв талбай болон авто замын тусгаарлах зурвас, авто зам дагуу тарьсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг дүүргийн хэмжээнд 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 07-ны өдрийн хооронд зохион байгуулсан бөгөөд 83 аж ахуйн нэгж	100%
			Ногоон байгууламж бүхий талбайн хэмжээ м ²	1,236.300	1,241.300		

						байгууллагад 2025.05.14-ний өдрийн 08/525 дугаартай албан бичгийг хүргүүлэн өөрийн эзэмшлийн 50 метр газар, Нарангийн ухаа 3 га талбай, хуваарьт газруудад нийт 11450, намрын бүх нийтээр мод тарих өдрийг 10 дугаар сарын 11, 12-ны өдөр зохион байгуулж 8290 ширхэг мод бутыг тарьж, цэнэг усалгаа арчилгааг хийсэн. 2025 онд нийт 19740 ширхэг мод бут тарьж, 32750 м2 ногоон байгуулажийг нэмэгдүүлж 1 хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 36,3 м2, нийт ногоон байгууламжийн талбай хэмжээ 1269050 м2 хүрсэн байна.	
185	3.1.10.2.Мод усалгааны инженерийн хийцтэй худаг гаргана. (ДЗДҮАХ ХАХТ-4.4.2.1)	ДТ 50.0	Нэмэгдүүлэх мод усалгааны худгийн тоо	-	1	Мод усалгааны инженерийн хийцтэй худаг гаргах ажлын санхүүжилт малын хөлийн татвараас бүрдэх ба тус орлого 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар бүрдээгүй байна.	-
186	3.1.10.3."Шарилжгүй Улаанбаатар" аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-4.4.2.2)	-	Шарилж, хөл газрын ургамал бүхий талбайн хэмжээ м ²	105,000 м ²	104,000 м ²	Дүүргийн хэмжээнд "Шарилжгүй Улаанбаатар" аяны 2 дугаар ээлжийг 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 09 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулахаар Төхижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн даргын 08/922 дугаар албан бичгийг дүүргийн 91 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэн	100%

						нийт 62 байгууллагаас тайлан мэдээ ирүүлэн 85,800 м2 талбайгаас 34,5 м3 шарилж хог ургамлыг устгаж, гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт буулгасан. Энэхүү ажлын хүрээнд дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн шарилж бүхий талбайг бүрэн цэвэрлэж дуусгасан.	
Зорилт 3.1.11.Оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалтыг хийнэ. (МУ-н 3ЗНДНТУТХуулийн 25.1.11, Хариуцлагын гэрээний 3.1.1, ДЗДҮАХ ХАХТ-4.4.2, 4.2.2)							
187	3.1.11.1.Нарангийн ухаа орчим 3 га газрыг ногоон төгөл болгон тохижуулах зураг төсвийг боловсруулна. (ДЗДҮАХ ХАХТ-4.2.2.1)	ДТ 35.0	Тохижилтын зураг төсвийн гүйцэтгэлийн хувь	0%	100%	Нарангийн ухаа орчим 3 га газрыг ногоон төгөл болгон тохижуулах зураг төсвийн ажлын төсвийг дүүргийн төсвийн тодотголд санал оруулсан боловч дэмжигдээгүй.	-
Зорилт 3.1.12.Дүүргийн гэрэлтүүлэг, арчлалт. (МУ-н 3ЗНДНТУТХуулийн 25.1.12, Хариуцлагын гэрээний 3.1.1, 3.7.13, ДЗДҮАХ ХАХТ-5.5.1)							
188	3.1.12.1.Гэр хорооллын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж аюулгүй орчинг бүрдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.5.1.1)	НТ 711.4	Нэмэгдүүлэх гэрэлтүүлгийн тоо	6283	7003	ОНХСангийн 260,8 сая төгрөгийн 202 ширхэг гэрэлтүүлэг, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын 749,1 сая төгрөгийн 486 ширхэг гэрэлтүүлгийн бараа материал худалдан авах ажлын тендер зарлагдаж, гүйцэтгэгч шалгарсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хөрөнгө татагдсан учир тус ажил хэрэгжих боломжгүй болсон. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хөрөнгө оруулалтаар 2-р хороонд 18, 3 дугаар хорооны	90.1%

						Хилчин хэсгийн хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын хүрээнд 12 ширхэг гэрэлтүүлгийг тус тус нэмэгдүүллээ. Нийт дүүргийн хэмжээнд 6313 гэрэлтүүлэгтэй болоод байна.	
Зорилт 3.1.13.Дүүргийн төвлөрсөн бус хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт. (МУ-н ЗЗНДНТУТХуулийн 25.1.13, Хариуцлагын гэрээний 3.1.1, ДЗДҮАХ ХАХТ-5.5.1)							
189	3.1.13.1.Мод усалгааны инженерийн хийцтэй худаг гаргана. (ДЗДҮАХ ХАХТ-4.4.2.1)	ДТ 50.0	Нэмэгдүүлэх мод усалгааны худгийн тоо	-	1	Мод усалгааны инженерийн хийцтэй худаг гаргах ажлын санхүүжилт малын хөлийн татвараас бүрдэх ба тус орлого 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар бүрдээгүй байна.	-
Зорилт 3.1.14.Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож хэрэгжүүлнэ. (МУ-н ЗЗНДНТУТХуулийн 25.1.14, Хариуцлагын гэрээний 3.1.1, (ДЗДҮАХ ХАХТ-4.3)							
190	3.1.14.1.Ахуйн хог хаягдлаас эрчим хүч гаргах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг эхлүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-4.3.1.1)	УТ 150.0	Ажлын гүйцэтгэлийн хувь	5%	30%	Ахуйн хог хаягдлаас эрчим хүч гаргах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж батлуулан Бүсчилсэн хөгжлийн төвд хүргүүлсэн.	-
191	3.1.14.2.Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах ажлыг үргэлжлүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-4.3.2.1)	БТ 75.0	Ангилан ялгах хог хаягдлын хэмжээ тонн	110	78	“Багануур тохижилт” ААТҮГ батлагдсан хуваарийн дагуу орон сууцны хорооллын дундах 13 цэг 46 аж ахуйн нэгж, байгууллагаас ангилсан хог хаягдлыг тусгай зориулалтын авто машинаар тээвэрлэн хог пресслэх үйлдвэрт хүргүүлэн	82.8%

						ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар 22 ширхэг пресс буюу 31160 кг хуванцар, 24 пресс буюу 33400кг хатуу зөөлөн гялгар цаасыг TML ХХК-д нийлүүлэн ажилласан.	
192	3.1.14.3.Хог тээврийн болон тусгай зориулалтын авто машины тоог нэмэгдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-4.3.2.5)	НТ 475.0	Шинээр нэмэгдүүлэх хог тээврийн болон тусгай зориулалтын авто машины тоо	5	2	“Багануур тохижилт” ААТҮГ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 01 сард зам шүүрдэгч тусгай тоноглолтой авто машин 1, 3 үйлдэлд бобкат 1-ийг эргэн төлөх нөхцөлтэйгээр хүлээн авч нийт тусгай зориулалтын авто машины тоо 3, Бобкат 2 болж нэмэгдсэн.	100%
193	3.1.14.4.Төв хогийн цэгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, өргөтгөнө. (ДЗДҮАХ ХАХТ-4.3.2.6)	ДТ 80.0	Өргөтгөх талбайн хэмжээ га	1	1	Төв хогийн цэгийн өргөтгөл буюу 6000м3 нүхэн талбайг нэмэгдүүлэх ажлыг “Баянзориг” ХХК-тай 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 12 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 70%тай	70%
Зорилт 3.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын хуулийн 46 дугаар зүйлд заасан байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангах. (Хариуцлагын гэрээний 3.1.3)							
194	3.2.1.Дүүргийн Засаг даргын захирамжийг ub.legal.mn цахим сайтад байршуулж, хэрэгжилтийг тооцно.	-	Байршуулах захирамжийн тоо	-	Тухай бүрд захирамжийг байршуулна.	Дүүргийн Засаг даргын 136 захирамжийг erp.ulaanbaatar.mn дэх ub.legal.mn болон bnd.gov.mn цахим сайтад тухай бүр байршуулсан. Дүүргийн Засаг даргын 2025 оны А	100%
			Хэрэгжилт тооцох давтамж	-	2		

						захирамжаас 05 дугаар сард 49 захирамжийн хэрэгжилт тооцоход хэрэгжилтийн дундаж 75.2 хувьтай гарсан бөгөөд жилийн эцсийн байдлаарх хэрэгжилтийг нэгтгэж байна.	
Зорилт 3.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлэх. (Хариуцлагын гэрээний 3.1.4)							
195	3.3.1.Согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг цэгүүдэд нэгдсэн хяналт шалгалт хийнэ. (ДЗДҮАХ ХАХТ-5.5.4.1)	-	Зохион байгуулах хяналт шалгалтын тоо	4	4	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн цахим хүсэлт ирүүлсэн 10 аж ахуйн нэгжид 3 удаа хяналт шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан.	100%
Зорилт 3.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган,тайлагнан ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.1.5)							
196	3.4.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангах, болзошгүй тохиолдлоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.5.2.2)	ХЭДС 5.0	Зохион байгуулах үйл ажиллагааны тоо	2	2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг сурталчлах хүрээнд ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажлын байран дахь осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7 удаагийн сургалтыг зохион байгуулж, 94 байгууллагын 448, “ХАБЭА-2025” сарын	100%

			Хамрагдах ААНБ-ын тоо	100	100	аяныг 5, 11 дүгээр сард зохион байгуулж, ХАБЭА хууль тогтоомж, байгууллагын ХАБЭА-н удирдлагын тогтолцоо, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагаа сэдэвт сургалтад 120 байгууллагын 480 ажилтан, 75 иргэн хамрагдаж, цахим контент 5, 5 төрлийн 350 ширхэг гарын авлагыг бэлтгэн иргэдэд хүргээд байна. Багануур Батарей хуримтлуур 110/35 кВ-ын өндөр хүчдэлийн дэд станц дээр өндөр хүчдэлийн ил хуваарилах байгууламж, хаалттай хуваарилах байгууламж, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын байртай танилцаж, ажлын байран дээрх зөрчил, аюулыг илрүүлэх 20 асуулт бүхий шалгах хуудсыг бөглөж санал солилцон ажилласан.	
			Хамрагдах ажилтны тоо	350	350		
197	3.4.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөр дамжуулан сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.6.2.1)	ДТ 5.0	Сургалтад хамрагдах хүний тоо	530	550	Энэрлийн түүчээ ТББ, Энх гэр бүл холбоо НҮТББ, 70-р сургууль, Нэмүүхэн тал ТББ, Жөндөрийн үндэсний хороо, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо,	100%

		-	Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээнд хамрагдах хүний тоо	72	90	HWPL ОУБ, Танин мэдэхүйн талст НҮТББ, Нэгдмэл үйлс, нэг сэтгэл ТББ-уудтай хамтран 8 удаагийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 846 багш, сургууль цэцэрлэгийн дэмжлэгийн баг, хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний асран хамгаалагчдыг хамруулаад байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөр дамжуулан Боловсрол, Гүн галуутай сургуулиудын сэтгэл зүйч нар хөгжлийн бэрхшээлтэй 36 хүн, 14 асран хамгаалагчид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж ажиллалаа.	
		-	Үйлчилгээнд хамрагдах хүний тоо	-	20		
		ДТ 5.2	Сургалтад хамрагдах хүний тоо	-	10		
198	3.4.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний гэр бүлийн гишүүдийг чадавхжуулах сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамруулж, ганцаарчилсан сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.6.2.1)	8.0	Зохион байгуулах сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа,	тоо	8 351	Энэрлийн түүчээ ТББ, Энх гэр бүл холбоо НҮТББ, 70-р сургууль, Нэмүүхэн тал ТББ, Жендэрийн үндэсний хороо, Монголын тэргэнцэртэй	100%

			хамрагдах хүний тоо			иргэдийн үндэсний холбоо, HWPL ОУБ, Танин мэдэхүйн талст НҮТББ, Нэгдмэл үйлс, нэг сэтгэл ТББ-уудтай хамтран 8 удаагийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 846 багш, сургууль цэцэрлэгийн дэмжлэгийн баг, хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний асран хамгаалагчдыг хамруулаад байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөр дамжуулан Боловсрол, Гүн галуутай сургуулиудын сэтгэл зүйч нар хөгжлийн бэрхшээлтэй 36 хүн, 14 асран хамгаалагчид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж ажиллалаа.	
			Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээнд хамрагдах хүний тоо	тоо	15		
			Мэргэжил олгох болон давтан сургалтад хамрагдах хүний тоо	тоо	15		
199	3.4.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчинг бүрдүүлж, шинээр баригдах байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбайн стандартыг хангуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.6.2.4)	-	Стандартыг хэрэгжүүлэх байгууллага, нийтийн эзэмшлийн зам талбайн байршлын тоо	2 16	2 10	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчны болон дэд бүтцийн стандартыг сайжруулах чиглэлээр дүүргийн Засаг даргын 06 дугаар сарын 18-ны өдрийн 01/689 дугаартай албан бичгийг 80 байгууллагад хүргүүлсэн бөгөөд Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоотой хамтран 10 дугаар сарын 24-ний өдөр стандарт норм дүрмийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биечлэн үнэлэх аргачлалыг ашиглан төрийн болон үйлчилгээний 28 байгууллага, нийтийн эзэмшлийн зам талбайд хүртээмжийн үнэлгээ хийсэн	100%

						бөгөөд Засаг даргын Тамгын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нацагдоржийн нэрэмжит нийтийн номын сан болон Гүн галуутай сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны ариун цэврийн 7 өрөөний хүртээмжийг сайжруулж, 2,4,5-р хорооны налуу шат, 6 байршилд 597,2 м2 явган замын стандартыг тус тус хангуулаад байна.	
200	3.4.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хүрээнд “Оролцоод хөгжье” зөвлөгөөн зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.6.2.5)	1.0	Оролцох хүний тоо	100	100	“Оролцоод хөгжье” зөвлөгөөнийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийн хүрээнд 12 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	-
201	3.4.6.Иргэдийн дундах жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх жендэрт суурилсан хүчирхийлэл, тэгш бус байдлыг арилгах чиглэлээр сургалт нөлөөллийн ажил зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.9.1.3)	3.5	Зохион байгуулах сургалт, нөлөөллийн ажлын тоо	1	2 1	Залуучуудын нийгмийн идэвх оролцоог сайжруулах, тэднийг хөгжүүлэх зорилгоор Хуульч профессор Лектор Ц.Азбаярыг урьж “Хувь хүний хөгжил, төлөвшил сэдэвт сургалтыг зохион байгуулж 280 гаруй залуусыг хамруулж сургалтаар залуучууд ирээдүйгээ хэрхэн төлөвлөх, мэргэжлээ сонгох, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх чиглэлээр мэдлэг олгож, асуулт асуух, зөвлөгөө авах боломжийг бүрдүүлсэн нь залуусын урам зориг, итгэл үнэмшлийг нэмэгдүүлсэн. Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран өсвөр үе,	100%

						залуучууд, иргэд олон нийтийн жөндөрийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх, жөндөрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор контент бүтээх нээлттэй уралдааныг дүүргийн хэмжээнд 05 -06 дугаар сард зохион байгуулж уралдаанд нийт 6 бүтээл ирсэн бөгөөд удирдамжийн дагуу хамтран зохион байгуулагч Насан туршийн суралцахуйн төвийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Хандалт 4,554 шэйр, 108,600 үзэлттэй байсан.	
Зорилт 3.5.Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасан дүүргийн төсвийн шууд захирагч нарын бүрэн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих. (Хариуцлагын гэрээний 3.1.6)							
202	3.5.1.Төсвийн байгууллагуудын зарлага, санхүүжилтэд хуульд заасны дагуу хяналт тавьж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100%	2025 оны 11 дугаар сарын 25- ний өдрийн байдлаар нийслэлээс дүүрэгт олгох санхүүгийн дэмжлэг 2,606.6 сая төгрөг, орон нутгийн төсөвт 22,627.4 сая төгрөгийн орлого төвлөрч, орон нутгийн 8 байгууллагад 22,592.5 сая төгрөг, улсын төсвийн 14 байгууллагуудын байр ашиглах тогтмол зардалд 3,221.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, төсвийн байгууллагын өдөр тутмын гүйлгээнд холбогдох баримтыг үндэслэж фрибаланс программын батлагдсан	100%

						төлөвлөгөө, төсвийн зарцуулалт эрхийн хүсэлт баталгааг үндэслэн нийт 42 байгууллагын 17,682 ширхэг 105,700.5 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хянан шалгаж баталгаажуулаад байна.	
Зорилт 3.6. Агаар, орчин бохирдуулагч эх үүсвэрийг бууруулж, гэр хорооллын айл өрхүүдэд байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ. (Хариуцлагын гэрээний 3.1.9, ДЗДҮАХ ХАХТ-4.2.3)							
203	3.6.1. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг хийж, сургалт зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-4.2.3.1)	-	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого, сургалт хийх давтамж	-	1 1	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг 5 хороодтой хамтран хийж 3-15 квт хүчин чадалтай 3241, 16-100 квт хүчин чадалтай 25, 100-4200 квт хүчин чадалтай 4 эх үүсвэрийн мэдээллийг ub.toollogo.mn сайтад шивж оруулан нэгтгэлийг Дүүргийн менежерийн 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 03/221 дугаартай албан бичгээр нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт хүргүүлсэн. Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс “Сар шинийн баяр”-ын арга хэмжээтэй холбогдуулан гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг удирдамж, хуваарийн дагуу 02 дугаар сарын 22-ны өдөр 1,4,5 дугаар хороо, 02 дугаар сарын 23-ны өдөр 3 дугаар хороо, 02 дугаар сарын 24-ний өдөр 2 дугаар хорооны айл өрхүүдээр нэгдсэн арга хэмжээ, “Хэрлэн”, “Соронз”, “Номин”,	100%

						“Гэрэл” худалдааны төвүүдийн гадна талбайд өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, гадна тусгай зориулалтын автомашины чанга яригчаар сэрэмжлүүлэг хүргэн, нийт 250 иргэнд 250 ширхэг гарын авлага брошур тараан ажилласан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтаар нийт 2250 айл өрхийн 5200 иргэнд урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг хийж, 1500 ширхэг гарын авлага тараан, худалдааны төвүүдийн мэдээллийн салбарт нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “4 асуудал, 1 шийдэл” аяны постерийг байршуулан ажилласан. Багануурын мэдээ, ЗДТГ-ын тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс пэйж хуудсанд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх мэдээллийг оруулж, дүүргийн Онцгой байдлыг хэлтэс хороодын ажлын албатай хамтран гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэн зуухны аюулгүй байдал, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.	
ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД							

Зорилт 3.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.2.1)

204	3.7.1.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сар бүрийн 8-ны өдрийн дотор шалгаж, сайтад байгууллагуудын мэдээлэл бүрэн байршсан эсэхэд хяналт тавина.	-	Хяналт хийх давтамжын тоо	12	12	Дүүргийн төсвийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн нийт 27 байгууллагад шилэн дансны тухай хуулийн дагуу shilendans.gov.mn сайтад мэдээ байршуулсан мэдээллийг тухайн сарын 08-ны дотор 12 удаа шалгаж ажилласан.	100%
-----	---	---	---------------------------	----	----	--	------

Зорилт 3.8.Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсөв, бусад шаардлагатай бэлтгэл ажлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 29.4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д нийцүүлж төлөвлөх. (Хариуцлагын гэрээний 3.2.2)

205	3.8.1.Улс, нийслэл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд санхүүжигдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөн саналыг дээд байгууллагад хүргүүлнэ.	-	Хүргүүлэх саналын тоо	2	2	Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Сангийн яамны https://pimis.publicinvestment.gov.mn/ цахим системээр болон ЗДТГ-ын даргын 04-р сарын 30-ны өдрийн 04/446 дугаартай албан бичгээр, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг иргэд, ААН байгууллагуудаас авч байна. Холбогдох дээд шатны байгууллагад 07-р сарын 04-ний өдрийн 04/788 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.	100%
-----	--	---	-----------------------	---	---	---	------

Зорилт 3.9.Хөрөнгө оруулалтын ажлын гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавихдаа гэрээний үүргийн хуваарь, ажлын тоо хэмжээний дагуу ажлын гүйцэтгэл, чанарт байнгын хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авах, гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан тохиолдолд уг аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг Төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнаж ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.2.3)

[illegible]

Зорилт 3.10.Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг насны бүлгээр хамруулж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг өрнүүлж хамрагдалтыг 70-аас доошгүй хувьд хүргэж ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.3.1, 3.3.8, ДЗДҮАХ ХАХТ- 2.1.2, 2.1.3)

207	3.10.1.БЗДХ-ын илрүүлэлт, эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.2.1)	-	БЗДХ өвчний оношлогоонд хамрагдах хүний тоо	1300	1400	БЗДХ-ын илрүүлэлт оношлогоо, үзлэгт 1240 хүн хамрагдснаас БЗХӨ-ний 80 тохиолдол илэрсэн. 1000 хүнд ноогдох БЗДХ-ын түвшин 2,7 промилль байна. Нийт оношлогдсон иргэдээс 96.2% нь эмчилгээнд хамрагдаад байна.	96.2%
		-	Нийт халдварт өвчний тохиолдлын түвшин 10.000 хүн амд ногдох промилль	4.8	4.6		
		-	Эмчилгээний хамрагдалтын хувь	93%	94%		
208	3.10.2.Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлж, тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.2.2)	-	Товлолын дархлаажуулалтын бүрэн тунгийн хамрагдалтын хувь	97.6%	97.7%	БЦЖ-99,8%, Халдварт саа (уудаг)-95,4%, Халдварт саа (тарьдаг)-95,5%, Тавт-94%, Гепатит А-93,7%, УГУ-94,7%, Гепатит В-99,8%, ПЭВ-94.9%, ХПВ-52,4% товлолт дархлаажуулалтын хамрагдалт 91.1%-тай байна. ӨЭМТ-үүдэд товлот дархлаажуулалтын хамрагдалтын үнэлгээг хийж хэрэгжилт 98.4%-тай байна. Улсын хэмжээнд салхинцэцэг, улаанбурхан өвчний дэгдэлт гарсантай холбоотойгоор дүүргийн хэмжээнд салхинцэцэг өвчний 134 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 94 тохиолдлоор	46.6%
		-	Нийт халдварт өвчний тохиолдлын түвшин 10.000 хүн амд ногдох промилль	60.7	60		

						өссөн, улаан бурхан өвчний тохиолдол шинээр 256 бүртгэгдсэн. Нийт халдварт өвчин 10000 хүн амд 195,25 промилль болж өмнөх оноос 135,19 промилоор өссөн байна.	
209	3.10.3.Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.3.1)	БТ 5.0	Сургалтад хамрагдах хүний тоо	3054	3000	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх төлөвлөгөөг 3 зорилт, 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулж, эрүүл мэндийн боловсрол олгох халдварт болон халдварт бус өвчлөл, эрт илрүүлэг, дархлаажуулалтын чиглэлээр 162 удаагийн сургалтад 3856 хүн хамрагдаж, төлөвлөгөөний хэрэгжилт 94.5%-тай байна.	100%
		БТ 1.0	Зохион байгуулах нөлөөллийн үйл ажиллагаа, хамрагдах хүний тоо	2 200	4 400		
210	3.10.4.Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалт, эрүүлжүүлэлтийн хувийг нэмэгдүүлэн нас баралтыг бууруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.3.2)	ДТ 5.0	Нийт хамрагдалт	69,6%	69,8%	Давхардсан тоогоор 44238 хүн 5 төрлийн эрт илрүүлэгийн үзлэгт хамрагдахаас 25549 буюу 57.8% нь хамрагдаж, эрүүлжүүлэлт 32.2%, нийт нас баралт 118 тохиолдол буюу 10000 хүн амд 39.4 промилль байна.	94.3%
			Эрүүлжүүлэлтийн хувь	31%	31,5%		
			Халдварт бус өвчний нас баралтын түвшин	47,02	47,01		
Зорилт 3.11.Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд” арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх. (Хариуцлагын гэрээний 3.3.2, ДЗДҮАХ ХАХТ-2.1.1)							
211	3.11.1.Төр хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтран “Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.1.1.3)	ДТ 5.0	Хөтөлбөрийн хүрээнд үзлэгт хамрагдах хүүхэд, эрүүлжилтийн хувь	100 70%	200 80%	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн 3 шүдний эмнэлэгтэй хамтран 6 настай 636 хүүхдүүдийн шүдний урьдчилан сэргийлэх үзлэгийг бүрэн хийж, эрүүлжилт 42%, урьдчилан сэргийлэх үзлэгт 242	100%

						хүүхдийг хамруулж, эрүүлжилт 82%-тай байна. Дүүргийн Засаг даргын 02 дугаар сарын 24-ний өдрийн А/56 дугаар захирамжаар “Шүд угаалтын дүүргийн аварга” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, Боловсролын хэлтэс, ЭМТ, ӨЭМТ, Монголын шүдний ерөнхий эмч нарын талст холбоо, хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүд, Дэлхийн Зөн Багануур ОНХ-тэй хамтран 05 дугаар сарын 08-ны өдөр IV-V, VI-VII анги гэсэн 2 ангиллаар өртөөчилсөн хэлбэрээр зохион байгуулсан. Тус тэмцээнд дүүргийн төрийн өмчийн ЕБ-ын 3 сургуулиас тус бүр 8 баг, нийт 24 багийн 192 суралцагч, 60 шүүгч, 10 зохион байгуулагч ажиллаж, тус бүр шилдэг 4 багийг шалгаруулсан.	
Зорилт 3.12.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, холбогдох стандартыг хангах ажлыг зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.3.12, ДЗДҮАХ ХАХТ-2.6.2)							
212	3.12.1.Мэргэжлийн байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний гэр бүлийн гишүүдийг спортоор дамжуулан сэргээн засах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.6.2.2)	ДТ 10.0	Спортоор дамжуулан сэргээн засах үйл ажиллагаа, хамрагдах хүний тоо	4 423	4 450	ХБИ-дэд Биеийн тамир, спортын хороо болон Хүний хөгжлийн ордны спорт заалаар 7 хоногт 2 өдөр тус бүр 2 цаг үнэ төлбөргүй үйлчилж давхардсан тоогоор 124	100%

			Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдах хүний тоо	162	165	хөгжлийн бэрхшээлтэй хүн, асран хамгаалагчид үйлчлүүлсэн бөгөөд 6 төрөлт спортын тэмцээнд 152 хүн хамрагдаж, Абилимп 2025 мэргэжлийн ур чадварын улсын уралдаанд 7 төрөлд 7 хүн оролцож, бариа заслын төрөлд тэргүүн байр эзэлсэн. Оюуны бэрхшээлтэй хүүхэд залуусыг спортоор дамжуулан сэргээн засах, хөгжүүлэх зорилгоор бочи спортоор ХБХ-тэй 18 хүүхэд 7 хоногт 4 цагаар хичээллэж, Ерөнхий боловсролын 70 дугаар сургууль, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Багануур орон нутгийн хөтөлбөртэй хамтран “Спорт тоглоомоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих нь” 2 удаагийн өдөрлөг, нөхөрсөг тэмцээнд 223, Монголын Рафа болон тусгай бочигийн спортын УАШ 8-р наадамд 16, НАШ Рафабочи болон тусгай бочигийн тэмцээнд 21 хүүхэд тус тус оролцож, багаараа 3-р байр, тусгай бочигийн төрөлд 4 мөнгө, 5 хүрэл, Бүх ард түмний наадам Бочи спортын төрөлд 18 тамирчин оролцож мөнгө, хүрэл медаль, Тусгай олимпийн хамтарсан Волейболын дэлхийн цомын тэмцээнд 1 хүүхэд тус тус амжилттай оролцоод байна. Нийт 5 удаагийн үйл ажиллагаанд 517 хүн хамрагдаад байна.	
--	--	--	---	-----	-----	---	--

						9,18,36 сартай хүүхдийн эрт илрүүлгийн үзлэгт 832 хүүхэд хамрагдахаас 655 хамрагдаж, 78,8%-тай, илэрсэн бэрхшээл 3 байна. Дэлхийн зөн Багануур орон нутгийн хөтөлбөрийн 5.4 сая төгрөгийн дэмжлэгээр ЭМТ-д ХБХ-ийн сэргээн засах тусламж үйлчилгээний танхимыг шинээр тохижуулж давхардсан тоогоор 600 гаран хүүхэдэд сэргээн засах тусламж үзүүлээд байна. Нийгмийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүйн болон эрүүл мэндийн боловсрол олгох 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1026 хүн хамрагдсан.	
Зорилт 3.13.Монгол хэлний тухай хууль, холбогдох стандартыг дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын хэмжээнд мөрдүүлэх, холбогдох хяналт, хэрэгжилтийг хангаж ажиллах, төрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтыг Хэлний бодлогын үндэсний зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.3.13, ДЗДҮАХ ХАХТ-2.4.1)							
213	3.13.1.Байгууллага ААН-ийн дунд "Үндэсний бичигтэн" уралдааныг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.4.1.6)	ДТ 3.0	Урамшуулах байгууллагын тоо	-	3	"Үндэсний бичиг-Өв соёл" нөлөөллийн аяныг 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 1 сарын хугацаатай зохиож байгуулан ажиллаж байна. Тус аяны хүрээнд байгууллагууд танилцуулгаа Монгол бичгээр бичин, цахим орчинд түгээх чөллэнжэд уриалан ажиллаж байна. Мөн "Өвөг дээдсийнхээ бичиг соёлыг өнөөдөр түгээмүй" илтгэлийн уралдааныг зохион	95%

						байгуулж, эхний шатанд шалгарсан 13 илтгэлийг хэлэлцүүлэн I байрт Татварын хэлтсийн улсын байцаагч Б.Ариунзул, II байрт Гүн галуутай сургуулийн монгол хэл бичгийн багш Б.Нарантуяа, Б.Циенханд нар, III байрт 193-р цэцэрлэгийн багш Л.Мягмарсүрэн тус тус нар шалгарч, шагнаж урамшуулсан.	
214	3.13.2.Дүүргийн байгууллагуудад Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022 стандартыг мөрдүүлж, бичиг хэргийн ажилтнуудыг монгол бичгийн дунд шатны сургалтад хамруулна.	-	Зохион байгуулах сургалт, хамрагдах ажилтны тоо	-	1 35	Дүүргийн хөмрөг үүсгэгч байгууллагуудын монгол бичгээр үйлдсэн захирамжлалын болон албан бичгийн хэвлэмэл хуудсыг хянаж нийслэлийн Архивын газарт хүргүүлсэн. Дүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран 44 байгууллагын 48 бичиг хэргийн ажилтан, албан хаагчдад монгол бичгийн сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 21-ний өдөр хүртэл зохион байгуулсан.	100%
Зорилт 3.14.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын чанар, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг ахиулахад чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.3.14, ДЗДҮАХ ХАХТ-2.3.1)							
215	3.14.1.Боловсролын салбарын багш, ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.1.1)	ДТ 3.0	Зохион байгуулах сургалт хамрагдах багш, ажилтны тоо	10 1720	3 300	“Хиймэл оюун ухааныг ашиглан ажлын ачаалал бууруулах нь”, “Цахим асуумж боловсруулж дүн шинжилгээ хийх”, “Цахим хэрэглэгдэхүүн боловсруулах асуулга” “Төлөвлөгөө гаргах дадал, цагийн менежмент”	100%

						сэдэвт 4 удаагийн сургалтад 174 багш, ажилтан хамрагдсан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг чадавхжуулах “Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн хөтөлбөрийн арга зүй”, “Цахим контент, сурах бичиг ашиглах арга зүй” сургалтыг зохион байгуулж, нийт 300 багш хамрагдсан.	
216	3.14.2.Мэргэжлийн хөгжлийн бүлгийг байгуулан, чадавхжуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.1.2)	ДТ 1.0	Мэргэжлийн хөгжлийн бүлгийн тоо	-	10	Боловсролын хэлтсийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/04 дугаар тушаалаар дүүргийн судлагдахууны мэргэжлийн хөгжлийн 10 бүлгийг мэргэжилтэн, сургалтын менежер, багшийн бүрэлдэхүүнтэй байгуулж, төл өвлөгөө боловсруулж, чадавхжуулах сургалтыг 1 удаа, дүүргийн түвшний шалгалт, олимпиадыг 2 удаа зохион байгуулсан. Сургуулийн өмнөх боловсролын нийслэлийн мэргэжлийн багш нарын бүлэгт эрхлэгч, арга зүйч, мэргэжилтэн гэсэн 5 хүний төлөөлөл ажиллаж, нийслэлд зохион байгуулагдсан 2 удаагийн туршлага судлах үйл ажиллагаанд оролцсон. "Мэргэжлийн багш нарын бүлгийн ажлын төлөвлөгөө, ажиллах арга зүй" сургалтыг 2	100%

						удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 100 багш хамрагдсан.	
217	3.14.3.Чадварлаг баг-Чанартай боловсрол” журмыг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.1.3)	ДТ 40.0	Урамшуулах ЗАН, судлагдахууны багш нар	16	8 Шаардлага хангасан суралцагчий г тухай бүр урамшуулна .	СӨББ-ын хүүхдийн хөгжлийн шалгалтад 10 цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 417 хүүхэд хамрагдсан бөгөөд гүйцэтгэл 88.01%-тай үнэлэгдсэн. ЕБС-ийн бичгийн шалгалтад төрийн өмчийн 3 сургуулийн 5 дугаар ангийн 18 бүлгийн 657 суралцагч хамрагдаж, гүйцэтгэл 61.2%-тай үнэлэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 5,9%-аар өссөн байна. СӨБ-ын 142, 131, 132 дугаар цэцэрлэг, нийслэлийн ерөнхий боловсролын Боловсрол сургуулийн 5 дугаар ангийн мэргэжлийн багш нарын бүлэг шагналт байранд шалгарсан. ЭЕШ-д 750 ба түүнээс дээш оноо авсан 10 суралцагч болон болзол хангасан ЗАН-үүдийг шалгаруулан шагнаж урамшуулсан. Дүүргийн элсэлтийн шалгалтын дундаж өнгөрсөн оныхоос 17,5 оноогоор өсч 488,5 болсон. Шалгалт зохион байгуулахад 3.6 сая, шагнал урамшуулалд 32.3 сая нийт 35.9 сая зарцуулсан. найруулах	100%
			Урамшуулах суралцагч	10			
218	3.14.4.Багш нарын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.1.4)	ДТ 3.0	Зохион байгуулах эрдэм шинжилгээний	1	1	Дүүргийн багш нарын “Оны шилдэг илтгэл” шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурлыг Боловсролын Үндэсний	90%

			бага хурлын тоо			судалгааны хүрээлэнгээс гаргасан удирдамжийн дагуу “Боловсролын шинэчлэлд эцэг эхийн оролцоо” сэдвийн дор 2 үе шаттай зохион байгуулахаар төлөвлөсөн. Эхний шатны шалгаруулалтад сургууль, цэцэрлэгээс 101 илтгэл ирсэн бөгөөд дараагийн шатанд шалгарсан 37 илтгэлийг 12 дугаар сарын 15-ны өдөр хэлэлцүүлж шалгаруулна.	
219	3.14.5.”Би багш” багш нарын ур чадварын уралдааныг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.1.5)	11.0 Дүүргийн төсөв	Зохион байгуулах ур чадварын уралдаан	1	1	Дүүргийн багш нарыг хөгжүүлэх зорилгоор “Би багш” ур чадварын уралдааныг жил бүр 2 үе шаттай зохион байгуулдаг. Энэ онд эхний шатанд буюу сургууль, цэцэрлэгийн түвшинд нийт 19 чиглэлээр 254 багш оролцож, 62 багш 2 дугаар шатанд шалгараад байна. Дүүргийн шатны шалгаруулалтыг 12 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд зохион байгуулах бөгөөд шалгарсан 19 багш Нийслэлийн ур чадварын уралдаанд оролцно.	100%
			Уралдаанд хамруулах багш нарын тоо	65	70		
Зорилт 3.15.Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдад эрүүл мэндийг дэмжсэн “Өглөөний цай”, “Сүү” хөтөлбөрийг орон нутаг болон эцэг эхийн оролцоотойгоор төсөв санхүүжилтийг шийдвэрлэн зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.3.22, ДЗДҮАХ ХАХТ-2.3.6)							
220	3.15.1.Боловсролын байгууллагуудад нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй “Сүү” зорилтот төслийг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-2.3.6.1)	ДТ 39.2	“Сүү” зорилтот төсөлд хамрагдах хүүхдийн тоо	0	2200	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд өөрсдийн нөөц бололцоогоор 2078 хүүхдэд 7 хоногийн 2-5 өдөрт 60-120гр сүү болон сүүн	94.4%

						бүтээгдэхүүн, Гүн галуутай сургууль үдийн хоолны цэсэнд тослог бууруулсан сүүг (1,6%) өдөр бүр, сүүн бүтээгдэхүүн болох ааруул, аарц, зөөхий зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг 7 хоногт 1-2 удаа өгч байгаа бөгөөд Боловсрол сургууль 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Үдийн хоолны цэсэнд 7 хоногт 1 удаа 150гр хэмжээтэй сүүг тогтмол олгож эхэлсэн.	
Зорилт 3.16.Дүүргийн хэмжээн дэх түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, иргэн аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр хариуцуулах ажлыг зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.3.26, ДЗДҮАХ ХАХТ-2.4.1)							
221	3.16.1.Түүх соёлын биет өв, үл хөдлөх дурсгалт газрын хадгалалт, хамгаалалтыг сайжруулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.4.1.2)	БТ 0.6	Зохион байгуулах үйл ажиллагааны тоо	-	2	50м	100%
ДЭД БҮТЦИЙН ХҮРЭЭНД							
Зорилт 3.17.Нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүд орчны 50м-ийн бүсэд цэвэрлэгээ, орох, гарах хэсгийн зам талбайг засварлуулах, орчны тохижилтыг сайжруулах, үүрэг өгч, хяналт тавьж ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.4.1)							
222	3.17.1.Дүүргийн аж ахуйн нэгж байгууллагуудын орчны 50м-ийн бүсэд цэвэрлэгээ хийлгэх, орох гарах хэсгийн зам талбайг засварлуулах, орчны тохижилтыг сайжруулах үүрэг өгч хяналт тавьж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	Үүрэг чиглэл өгч хяналт тавьж ажилласан байна	2025 оны жилийн эцсийн байдлаар Бүх нийтийн их цэвэрлэгээг дүүргийн нутаг дэвсгэрт нийт 6 удаа зохион байгуулснаас суурьшлийн бүсийн цэвэрлэгээ 4, Ногоон бүсийн цэвэрлэгээ 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 751 байгууллагын 6780 ажилтан, албан хаагчид 834,800м ² талбайг цэвэрлэж нийт 391 тонн хог хаягдлыг цуглуулж Багануур тохижилт ААТҮГ-т ачуулан төвлөрсөн хогийн цэгт буулгасан. Мөн	100%

						нийслэлийн хөрөнгө оруулалтаар Багануур тохижилт ААТҮГ дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн олон жил хуримтлагдсан хур хогийн цэг 30, малын өтөг бууц 40, барилгын туурь 31 цэгийг устгаж нийт 3137 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт буулгасан. Гэр хорооллын 3602 айл өрх хашаа гудамжны хог хаягдлыг цэвэрлэж орчны цэвэрлэгээг хийсэн.	
Зорилт 3.18.Хувийн орон сууцны конторуудын үйл ажиллагаанд хяналт тавих, шугамын ээлжит засвар, үйлчилгээг тогтмол хийлгүүлэхэд анхаарч, иргэд оршин суугчдын тав тухтай амьдрах нөхцөлийг хангаж ажиллах.(Хариуцлагын гэрээний 3.4.3)							
223	3.18.1.Багануур-Ус ААТҮГ-аас хийх шугам сүлжээний засварын ажлыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	Үйл ажиллагаанд хяналт тавьж, шугамын ээлжит засвар, үйлчилгээг тогтмол хийлгүүлсэн байна.	81 дүгээр байрны гадна шугам, Багануур хотын ус хангамж шугамын өргөтгөл, автоматжуулалтын ажил, Оюуны эрин сургуулийн гадна шугам шинэчлэлтийн ажлуудад захиалагчийн хяналтыг тогтмол хийж ажлыг бүрэн хүлээн аваад байна. Залуус хэсгийн шугам шинэчлэх ажил 85%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	100%
Зорилт 3.19.Нутаг дэвсгэрийн авто замд байршуулсан нийтийн эзэмшлийн хайс хашлагыг угааж цэвэрлэх, эвдэрсэн даруйд арга хэмжээг авдаг байх. (Хариуцлагын гэрээний 3.4.4)							
224	3.19.1.Нутаг дэвсгэрийн авто замд байршуулсан нийтийн эзэмшлийн хайс хашлагыг угааж цэвэрлэж, эвдэрсэн даруйд арга хэмжээг авч ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	Хайс хашлагыг угааж, засварлаж ажилласан байна.	“Багануур тохижилт” ААТҮГ-ын 53 үйлчлэгч сард 1 удаа батлагдсан хуваарийн дагуу нийтийн эзэмшлийн зам талбайн 2502 метр урт хайс, хашлага угааж цэвэрлэсэн.	100%

Зорилт 3.20.Хот нийтийн “Ulaanbaatar Engineering” Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт, удирдлагын цогц системийн үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлэн, мэдээллийн сангийн баяжилтыг тогтмол мэдээллээр ханган ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.4.6)

225	3.20.1. Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт удирдлагын цогц “UB-ENGINEERING” системийн үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлэн, мэдээллийн сангийн баяжилтыг хийнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	Удирдлагын цогц системийг бүрэн нэвтрүүлсэн байна.	УБЗАА-наас Улаанбаатар хотын нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн ашиглалт, үйлчилгээний нэгдсэн хяналт, удирдлагын цогц систем буюу “UB engineering” программд дүүрэгт 2025 онд ашиглалтад орсон 2 орон сууцны 3 лифтийг мэдээллийн санд оруулсан.	100%
-----	---	---	---------------------------	---	--	--	------

Зорилт 3.21.Халиа дошин, шар усны үерийн нөхцөл байдалд хариу арга хэмжээг Нийслэлийн Захирагчийн ажлын албатай уялдуулан зохион байгуулж шар усны үерт өртөх эрсдэлтэй байршилд газар олголт хийхгүй байх, шар усны үер, халиа дошинд өртөх эрсдэлтэй байршлыг иргэдэд тогтмол сэрэмжлүүлж ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.4.7)

226	3.21.1.Дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран шар усны үер, халиа дошинд өртөх эрсдэлтэй байршлыг иргэдэд тогтмол сэрэмжлүүлж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	Сэрэмжлүүлж ажилласан байна.	Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Багануур тохижилт ААТҮГ, Онцгой байдлын хэлтэс хамтран дүүргийн нутаг дэвсгэрийн үерийн хамгаалалтын далан, суваг шуудууны үзлэг шалгалтыг 7 удаа зохион байгуулсан. Багануур тохижилт ААТҮГ нь далан сувгийн цэвэрлэгээг 7 удаа хийж 560 м/куб хогийг цэвэрлэсэн ба төв зам дагуух 600м ус зайлуулах лотки болон орон сууц гэр хорооллын 38 байршлын авто зам, явган замын лоткины шороог гаргаж, ус хуримтлуулагч кольцон доторх усыг соруулж лаг шаврыг 4 удаагийн давтамжтай	100%
-----	--	---	---------------------------	---	------------------------------	--	------

						цэвэрлэж 410м/куб шороог гаргаж суваг шуудууг сэргээсэн.	
Зорилт 3.22.Дүүргийн иргэдийг үер, усны болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, хамгаалах, бүтээн байгуулах, үерийн хамгаалалтын далан, суваг, зам, талбайн борооны ус зайлуулах шугам, хөрсний усны шугамын хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор усны барилга байгууламжийн мэргэжилтэнд хариуцуулж, үерийн хамгаалалтын далан, сувгийн цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж, ус чөлөөтэй нэвтрэх бэлэн байдлыг хангаж ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.4.8)							
227	3.22.1.Үерийн хамгаалалтын сувгийг нэмэгдүүлж, сэргээн засварлана. (ДЗДҮАХ ХАХТ-1.4.4.1)	ДТ 1,262.7	Нэмэгдүүлэх үерийн хамгаалалтын суваг м	3200	2526.2	Зүүн энгэрийн үерийн далан суваг барих ажлыг “Говийн пирамид” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд нийт 2526,26 м далан сувгийн ажлыг хийж гүйцэтгэхээс 11 дүгээр сарын байдлаар 2350м даланг хийж гүйцэтгэн үлдсэн ажлыг 2026 оны 07 дугаар сард дуусгахаар гэрээг сунгаад байна. Ажлын явц 80%-тай.	93%
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХҮРЭЭНД							

Зорилт 3.23.Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг сайжруулж, иргэдээс харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг эрх хэмжээнийхээ хүрээнд бүх талаас нь судлан үзэж, шуурхай, хуулийн хугацаанд, үндэслэлтэй хариу өгч, бүрэн барагдуулж шийдвэрлэх. (Хариуцлагын гэрээний 3.5.1)

228	3.23.1.Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирж байгаа өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж шуурхай хариу өгч ажиллана.	-	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	13 хоног 02 цаг 23 минут	11 хоног	Засгийн газрын 11-11 төвөөс 111 өргөдөл, гомдол ирсэн ба 110 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 хоног 7 цаг 27 минут байгаа нь өмнөх оноос 1 хоног 19 цагаар бага байна. Шийдвэрлэсэн байдлаар авч үзвэл 70 өргөдлийг иргэний талд шийдвэрлэж, 40 иргэнд боломжгүй хариу өгсөн байна. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцдаа явцын тэмдэглэл хөтлөөгүй 6, өдөрт нь багтаан шилжүүлээгүй 4, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 2, нийт 12 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад (25) зөрчлийн тоо 13 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. Иргэнд хариу өгсөн хэлбэрээр нь авч үзвэл нийт өргөдлийн 48,2% буюу 53 иргэнд утсаар, 30,9% буюу 34 иргэнд албан бичгээр, 16,4 буюу 18 иргэнд биечлэн уулзаж, 4,5% буюу 5 иргэнд мессежээр хариу өгсөн байна.	87.2%
			Зөрчлийн тоо	27	13		
			Албан бичгээр хариу өгөх өргөдлийн хувь	16,9%	50%		

Зорилт 3.24.Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэж, шилжүүлэх үйл явцын зөрчлийг арилгах, шат дамжлага, шийдвэрлэлтийн хугацааг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг үр дүнтэй хангаж хугацааг 2 дахин бууруулах. (Хариуцлагын гэрээний 3.5.2, 3.5.4)

229	3.24.1.Засаг даргын Тамгын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүхий л хэлбэрээр хүлээн авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана.	-	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	9 хоног	Нийслэлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас бага байлгана.	Засаг даргын Тамгын газар нь 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 275 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 35 өргөдлийн холбогдох байгууллагад нь шилжүүлсэн 238 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 2 өргөдөл, гомдол шийдвэрлэх шатандаа байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 18 цаг 1 минут байгаа нь нийслэлийн дундаж хугацаа (8 хоног 13 цаг)-аас 2 хоногоор их байна. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад өдөрт нь багтаан хүлээн аваагүй 3, явцын тэмдэглэл хөтлөөгүй 8, нийт 11 зөрчил гаргасан нь өмнөх оны мөн үетэй (38) харьцуулахад 27 нэгж буюу 71%-иар буурсан байна.	75%
Зорилт 3.25.Дүүрэг, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар улирал бүр хийлгүүлж, дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх. (Хариуцлагын гэрээний 3.5.5)							
230	3.25.1.Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлнэ.	-	Хийлгэх судалгааны тоо	-	2	Бодлогын шийдэл ТББ-тай хамтран энэ оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд Засаг даргын Тамгын газрын шударга байдлын үнэлгээг хийх зорилгоор хөндлөнгийн 100 иргэн, 20 төрийн албан хаагчийг хамруулан судалгаа авсан бөгөөд дүнг 12 дугаар сард багтаан нэгтгэн гаргахаар төлөвлөөд байна.	50%
ХОТЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКСИЙН ХҮРЭЭНД							

Зорилт 3.26.Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран өөрийн байгууллагын хариуцах индексийн үзүүлэлтийг тогтох, индексийн суурь түвшинг нягтлах, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлыг 2025 онд багтаан хийж гүйцэтгэх. (Хариуцлагын гэрээний 3.6.1)							
231	3.26.1.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын индексийн үзүүлэлтийг тогтоож, суурь түвшинг нягталж сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллана.	-	Боловсруулах төлөвлөгөөний тоо	-	1	Хэрэгжээгүй.	0%
Зорилт 3.27.Хотын хөгжлийн индексийн өөрийн байгууллагын хамаарах үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох ажлыг зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.6.2)							
232	3.27.1.Хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох ажлыг зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	Хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцсон байна.	Хэрэгжээгүй.	0%
Зорилт 3.28.Хотын хөгжлийн индекс болон тухайн байгууллагын суурь мэдээллийг орон зайд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санд тухай бүр оруулж ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.6.3)							
233	3.28.1.Хотын хөгжлийн индекс болон тухайн байгууллагын суурь мэдээллийг орон зайд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санд тухай бүр оруулж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	Тухай бүр мэдээллийг оруулж ажилласан байна.	Хэрэгжээгүй.	0%
ХОТ НИЙТИЙН АЖ АХУЙН ХҮРЭЭНД							
Зорилт 3.29.Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд орж ирсэн адуу малыг гаргах, хашаанд түр саатуулах, эзэнд хүлээлгэж өгөх үйл ажиллагааг зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.7.1)							
234	3.29.1.Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсийн журмын хэрэгжилтийг хангаж, малтай иргэдийг гаргах ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.6.4.3)	ДТ 1.0	Суурьшлын бүсээс гаргах өрхийн тоо Малын тоо	44 1638	12 370	“Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд	100%

						01 дүгээр сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн 1863 адуу, 676 үхрийг хашиж 48 иргэнд Цагдаагийн байгууллагаас Зөрчлийн тухай хуулийн 6.30 дугаар зүйлийн 3 дахь заалтын дагуу торгуулийн арга хэмжээ авч, шийдвэрлүүлж ажилласан. Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 59 өрхийн 1290 малыг гаргасан.	
Зорилт 3.30. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мод тарьж, арчилж, ургуулах ажлыг нарийвчилсан судалгаа, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулж, мод тарих үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэд, олон нийтийг оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх. (Хариуцлагын гэрээний 3.7.2)							
235	3.30.1. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-4.1.2.1)	ДТ 20.0	Тарих мод, бут сөөгний тоо	247324	5000	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг дүүргийн хэмжээнд 05 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 07-ны өдрийн хооронд зохион байгуулсан бөгөөд 83 аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшлийн 50 метр газар болон Нарангийн ухаа 3 га талбайн хуваарьт газруудад нийт 11450 ширхэг мод бутыг тарьж, цэнэг усалгаа арчилгааг хийсэн. Намрын бүх нийтээр мод тарих өдрийн арга хэмжээг 10 дугаар сарын 11, 12-ны өдөр Нарангийн энгэр, Аз жаргалын төгөл, Нархан төглийн 3	100%

						байршил 8290 мод бутыг тарьж усалгаа арчилгааг хийсэн. 2025 онд нийт 19740 мод бутыг шинээр тарьж усалгаа арчилгааг хийсэн.	
Зорилт 3.31.Эзэнгүй нохой, муурын тоо толгойг бууруулах ажлыг зохион байгуулах, буудаж устгахаас бусад арга хэрэгслийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх. (Хариуцлагын гэрээний 3.7.4)							
236	3.31.1.Нохой, муур устгах ажлыг тогтмол зохион байгуулж, буудаж устгахаас бусад арга хэрэгслийг нэвтрүүлж, хэрэгжүүлнэ.(ДЗДҮАХ ХАХТ-4.3.2.4)	БТ 80.0	Устгах нохойны тоо	1839	2500	2025 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн 1-5-р хорооны нутаг дэвсгэрт 8 удаагийн золбин нохой, муурны устгалыг зохион байгуулж, 1349 нохой 79 муур устгасан.	60%
			Устгах муурны тоо	130	120		
Зорилт 3.32.Нийтийн бие засах газрын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах. (Хариуцлагын гэрээний 3.7.7)							
237	3.32.1.Нийтийн зориулалттай ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлнэ. (ДЗДҮАХ ХАХТ-4.3.2.7)	ДТ 360.0	Нэмэгдүүлэх нийтийн зориулалттай ариун цэврийн байгууламжийн тоо	2	2	Дүүргийн наадмын талбайд нийтийн зориулалттай ариун цэврийн 1 байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулсан. Хөлбөмбөгийн талбайд төвлөрсөн системд холбогдсон ариун цэврийн байгууламжийн дотор засал болон цахилгаан холболтын ажлууд дутуу байгаа ба дээрх 2 ажлыг Багануур тохижилт ААТҮГ хийж гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 80%-тай	80%
Зорилт 3.33.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрх шилжсэнтэй холбогдуулан аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэж хариу хүргүүлэх, тайлан мэдээг улирал бүр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэх. (Хариуцлагын гэрээний 3.7.8)							
238	3.33.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг цахимаар хүлээн авч, ажлын хэсгийн хурлаар оролцуулан шийдвэрлэнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	Тухай бүр хүсэлтийг авч, зөвшөөрлийг олгоно.	Тухай бүр хүсэлтийг авч, зөвшөөрлийг олгоно.	Согтууруулах ундаагаар үйлчлэх 1 тусгай зөвшөөрөл, худалдах 4 зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч дүгнэлт гаргах ажлын хэсгийн	100%

						хурлаар оролцуулан шийдвэрлэсэн.	
239	3.33.2.Тамхи худалдан борлуулах зөвшөөрлийг цахимаар хүлээн авч, Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийн хурлаар оролцуулан шийдвэрлэнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	Тухай бүр хүсэлтийг авч, зөвшөөрлийг олгоно.	Тухай бүр хүсэлтийг авч, зөвшөөрлийг олгоно.	Тамхи худалдан борлуулах зөвшөөрлийн 6 иргэн, 13 аж ахуйн нэгжийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, шаардлагыг хангуулж хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	100%
240	3.33.3.Мөнгөн зээлийн үйлчилгээний зөвшөөрлийг олгоно.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	-	100%	Дүүргийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 08-ний өдрийн А/281 дугаар захирамжаар барьцаалан зээлдүүлэх мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан 1 ААНБ бүртгэж баталгаажуулсан.	100%
Зорилт 3.34.Нийслэлийн хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн нөөцийн мах худалдан борлуулах дэлгүүрийн судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтран мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, бэлтгэл ажлыг ханган, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.7.9)							
241	3.34.1.Нөөцийн мах худалдан борлуулах ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.5.1.2)	ДТ 4.0	Худалдан авах нөөцийн махны хэмжээ тн	40	30	Нийслэлийн хүн амын 2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас нөөцийн мах худалдан борлуулах 9 аж ахуйн нэгжүүдэд 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр тавигдах шаардлагын талаар цахим сургалт зохион байгуулж, нөөцийн мах худалдаалах 12 хүнсний дэлгүүрүүдэд шаардлагын дагуу Цагдаагийн хэлтэс, Татварын хэлтэс,	100%

						Хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагчтай хамтран хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн нөөцийн махыг худалдан борлуулж эхэлсэн. Мөн 02 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд, 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 24 өдрийг хүртэл 7 хоног бүр өргөтгөсөн нөөцийн махны худалдаа зохион байгуулж, өргөтгөсөн худалдаанд “Чойбалсан групп” ХХК нийт 200тн мах борлуулсан байна.	
Зорилт 3.35.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-ын хэрэгжилтийг дүүргийн нутаг дэвсгэрт хангуулж, хагас, бүтэн жилээр тайлагнах. (Хариуцлагын гэрээний 3.7.10)							
242	3.35.1.Журмыг хэрэгжилтийг хангаж хагас бүтэн жилээр тайлагнана.	-	Журмын хэрэгжилт	-	Журмыг хэрэгжүүлж ажилласан байна.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/29 дүгээр тогтоолоор Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээг зохицуулах нийтлэг журмыг цуцалж Худалдаа үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага бүрдүүлэх баримт бичиг, худалдаа үйлчилгээ эрхлэгчийн эрх үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлагдсан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд	100%

						жилийн эцсийн тайланг хүргүүлсэн.	
ХОТЫН СТАНДАРТЫН ХҮРЭЭНД							
Зорилт 3.36.Стандарт, норм, дүрэм мөрдүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллага, Сууц Өмчлөгчдийн Холбоо, дүүрэг, хороодын албан хаагчдыг хотын стандартын сургалтад хамруулах ажлыг Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтарч зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.8.1)							
243	3.36.1.Худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагад стандартуудыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах, чадавхжуулах сургалт зохион байгуулна. (ДЗДҮАХ ХАХТ-3.5.1.1)	ДТ 1.0	Сургалтад хамрагдах хүний тоо	-	20	Монголын тогооч нарын холбоо, дүүргийн тогооч нарын холбоотой хамтран дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, цэцэрлэг, сургуулийн нийт 36 тогоочийн мэдлэг чадварыг сайжруулж, мэргэшүүлэх сургалтыг 11 дүгээр сарын 19,20-ны өдрүүдэд зохион байгуулж, сертификат олгосон.	100%
Зорилт 3.37.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдлыг хотын стандартын дагуу хангуулах, аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчин, гудамж зам талбайг засварлаж тохижуулах ажлыг зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.8.2)							
244	3.37.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчинг бүрдүүлж, шинээр баригдах байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбайн стандартыг хангуулна. (ДЗДҮАХ ХАХТ-2.6.2.4)	-	Стандартын хэрэгжилт хангах байгууллагын тоо	2	2	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчны болон дэд бүтцийн стандартыг сайжруулах чиглэлээр дүүргийн Засаг даргын 06 дугаар сарын 18-ны өдрийн 01/689 дугаартай албан бичгийг 80 байгууллагад хүргүүлсэн бөгөөд Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоотой хамтран 10 дугаар сарын 24-ний өдөр стандарт норм дүрмийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биечлэн үнэлэх аргачлалыг ашиглан төрийн болон үйлчилгээний 28 байгууллага, нийтийн эзэмшлийн зам талбайд хүртээмжийн үнэлгээ хийсэн бөгөөд Засаг даргын Тамгын газар, Улсын бүртгэлийн	100%
			Стандартын хэрэгжилт хангах нийтийн эзэмшлийн зам талбайн байршлын тоо	16	10		

						хэлтэс, Нацагдоржийн нэрэмжит нийтийн номын сан болон Гүн галуутай сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны ариун цэврийн 7 өрөөний хүртээмжийг сайжруулж, 2,4,5-р хорооны налуу шат, 6 байршилд 597,2 м2 явган замын стандартыг тус тус хангуулаад байна.	
Зорилт 3.38.Тохижилт бүтээн байгуулалтын ажилд (хүүхдийн тоглоомын талбай, явган зам, унадаг дугуйн зам, худалдаа үйлчилгээний газрын гадна орчин, хог хаягдал, ногоон байгууламж) зөвлөмж арга зүйгээр хангах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд холбогдох байгууллагатай хамтран ажиллах.(Хариуцлагын гэрээний 3.8.3)							
245	3.38.1.Худалдаа үйлчилгээний гадна орчны тохижилтод анхаарч, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 64 байгууллагатай гадна орчны тохижилтын стандартыг тогтмол мөрдүүлэн ажиллаж байна.	100%
Зорилт 3.39.Дүүргийнхээ хэмжээнд хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний үр дүнг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2025 оны эхний хагас жилд багтаан Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтарч танилцуулах. (Хариуцлагын гэрээний 3.8.4)							
246	3.39.1.Хотын стандартыг мөрдүүлж ажиллана.	-	Хотын стандартыг мөрдүүлэх байршлын тоо	10	20	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний байгууллагуудын гадна орчны стандартыг байнга мөрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд 4 дүгээр улирлын байдлаар 18 байгууллагын гадна орчны гэрэлтүүлэг, хогийн савыг шинэчлүүлэхээр хугацаатай үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан. Мөн хөрөнгө оруулалтын ажлууд	100%

						тохижилтын чиглэлээр 4, авто зам засвар шинэчлэлтийн 5, хороодын хөрөнгө оруулалтын 16 нийт 41 байршилд холбогдох стандартуудыг мөрдүүлэн ажиллаж байна	
Зорилт 3.40.Нийслэлийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллах. (Хариуцлагын гэрээний 3.8.5)							
247	3.40.1.Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулах сургалтын тоо	1	2	Хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор сургалтыг 2025 оны 07 сарын 04 ний өдөр Хяналт шалгалтын газар, Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтран дүүргийн удирдах ажилтан албан хаагчид, инженер техникийн ажилтнуудад шинээр батлагдсан болон мөрдөгдөж байгаа стандартын талаар мэдээлэл хүргэж ажилласан.	50%
БУСАД							
Зорилт 3.41.Энэхүү гэрээний 2.1.5-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах. (Хариуцлагын гэрээний 3.9.1)							
248	3.41.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтууд, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, “Бүтээн байгуулалтын жил”-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах. (Хариуцлагын гэрээний 2.1.5)	-	Хэрэгжилт тооцох бодлогын баримт бичгийн тоо	-	4	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн жилийн эцсийн хэрэгжилтэд , хяналт-шинжилгээ хийж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 11 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлсэн. Хэрэгжилт 81.6%-тай. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг	100%

						хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамаарах 18 заалтын биелэлтийг холбогдох хэлтэс албадаас авч нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд хэрэгжилт 85%-тай байна. Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд , хяналт-шинжилгээ хийж, 11 дүгээр сарын 25-ны өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн. Хэрэгжилт 57.5%-тай. “Бүтээн байгуулалтын жил”-ийн тайланг холбогдох хэлтэс ирүүлээгүй байна.	
Зорилт 3.42.Дүүргийн Засаг дарга нь энэхүү гэрээний 5.2, 5.3-т заасан хугацаанд гэрээний хэрэгжилтийн тайланг ирүүлэх. (Хариуцлагын гэрээний 3.9.2)							
249	3.42.1.Санхүүгийн хагас жилийн тайланг 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор батлагдсан заавар, журмын дагуу гаргаж, хөтөлбөрийн үр дүнгийн тайлангийн хамт тухайн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. (Хариуцлагын гэрээний 5.2)	-	Тайлан ирүүлэх давтамж хугацаа	-	2 удаа 7 сарын 25 03 сарын 25	Дүүргийн төсвийн 34 байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэж 03 дугаар сарын 24-ний өдөр Нийслэл дэх төрийн аудит болон Нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, аудитаар зөрчилгүй стандарт дүгнэлт авсан. Мөн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн 07 дугаар сарын 20-ний өдөр Нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэст хугацаанд нь хүргүүлээд байна.	100%

250	3.42.2.Гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ. (Хариуцлагын гэрээний 5.3)	-	Хүргүүлэх тайлангийн тоо	2	2	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас дүүргийн Засаг даргатай байгуулсан Хариуцлагын гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор ЗДТГ-ын болон дэргэдэх хэлтэс, албадын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж, тайланг 06 дугаар сарын 18-ны өдрийн 04/693 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Хариуцлагын гэрээний жилийн эцсийн биелэлтийг 12 дугаар сарын 03-ны өдөр нэгтгэн гаргахаар ажиллаж байна.	-
			Хэрэгжилтийн хувь	-	95%		
			Хяналт-шинжилгээ, үнэлгээний хувь	92%	92%		
Зорилт 3.43.Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга, хариуцлагыг шалгуур болгох. (Хариуцлагын гэрээний 3.9.3)							
251	3.43.1.Төрийн албан хаагчдын манлайлал, ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулна.	-	Зохион байгуулах сургалтын тоо	3	4	Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 03 дугаар сард зохион байгуулж, 101 албан хаагч хамрагдсан бол Монгол Улсын Ёс зүйн хороотой хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэглээ", "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" сэдэвт сургалтыг 05 дугаар сард зохион байгуулж, 37 байгууллагын 217 албан хаагч оролцсон. Засаг даргын Тамгын газрын хэлтэс, алба, хороодын	75%

						дунд төрийн албан хаагчийн “Ёс зүй” сэдэвт аяныг 06 дугаар сарын 09-20-ны өдрүүдэд зохион байгуулсан ба Тэргүүн байранд Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, дэд байранд 5-р хороо, гутгаар байранд Цэргийн штаб тус тус шалгарлаа. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс “Сайн жишигийг бид эхлүүлье, Хамтдаа хэвшүүлье”, Цэргийн штаб “Цэвэр цэмцгэр хувцаслалт, гадаад үзэмж дээр анхаарч байгууллагын соёлыг түгээцгээе”, 5-р хороо “Хүндлэлтэй харилцаж, шуурхай үйлчилье” уриаг дэвшүүлэн, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Ёс дэд хорооноос албан хаагчдын дунд “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг 12 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
252	3.43.2.Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, батлуулах, тайланг хүлээн авч үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга, хариуцлагыг шалгуур болгож, мэргэшил арга зүйн туслалцаа үзүүлнэ.	-	Хянаж, батлах байгууллагуудын төлөвлөгөөний тоо	35	34	Дүүргийн Засаг даргын дэргэдэх 35 хэлтэс, албадын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахад мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч, улмаар 03 дугаар сарын 10-ны өдөр үзэглэлээ. Дүүргийн 35 байгууллагын эхний хагас жилийн тайлантай танилцсаны үндсэн дээр 07 дугаар сарын 09-ний өдрийн “Төсвийн шууд	-
			Зохион байгуулах арга хэмжээний тоо	2	2		

						захирагчдад урамшуулал олгох тухай” Б/24 дугаар захирамжийг боловсруулан, батлуулж 07 дугаар сарын 21-ний өдөр дээрх байгууллагуудад хүргүүлсэн. Жилийн эцсийн тайлангаа ирүүлэх тухай 04/1327 дугаартай албан бичгийг хүргүүлж, тайлан боловсруулалтад мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.	
253	3.43.3.Байгууллагын нэгж, төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнахад мэргэшил арга зүйн зөвлөмж өгч, улирал, бүтэн жилээр үнэлүүлэхэд ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга, хариуцлагыг шалгуур болгоно.	-	Мэргэшил арга зүйн зөвлөмж өгөх нэгжийн төлөвлөгөөний тоо	7	8	Засаг даргын Тамгын газрын 8 нэгж, 39 албан хаагчдад Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын хүрээнд төлөвлөгөө боловсруулж тайлагнах, үнэлэх талаар арга зүйн зөвлөмж өгч, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
			Үнэлүүлэх тайлангийн тоо	7	8		
			Мэргэшил арга зүйн зөвлөмж өгөх төлөвлөгөөний тоо	36	39		
			Мэргэшил арга зүйн зөвлөмж өгч, үнэлүүлж, дүгнүүлэх тайлангийн тоо	36	39		
Зорилт 3.44.Төрийн албан хаагчийг томилохдоо “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын зохицуулалтын дагуу зохист хэлбэрүүдийг ашиглан хууль зөрчихгүй ажиллах, зөрчсөн тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээх. (Хариуцлагын гэрээний 3.9.4)							
254	3.44.1. Төрийн албан хаагчийг томилохдоо “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх	-	Зөрчилтэй томилгооны тоо	0	0	“Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд	100%

	журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ыг хэрэгжүүлж ажиллана.					шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сэлгэн ажиллах хугацаа дуусгавар болохоос өмнө урьд эрхэлж байсан албан тушаалдаа үргэлжлүүлэн ажиллахаар хүсэлт ирүүлсэн 3 , өөр байгууллага руу шилжин томилогдохоор хүсэлт гаргасан 2, нэгж хооронд шилжих хүсэлт гаргасан 1 төрийн албан хаагчийн хүсэлтийг тус тус журмын хүрээнд шийдвэрлэлээ.	
Зорилт 3.45.Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах. (Хариуцлагын гэрээний 3.9.5)							
255	3.45.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. (ДЗДҮАХ ХАХТ-5.1.6.1)	10.0 ДТ	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	83%	84%	Дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний төслийг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөртэй уялдуулан боловсруулж, Авлигатай тэмцэх газраас санал авч боловсруулан дүүргийн Засаг даргын 2025 оны А/86 дугаартай захирамжаар батлууллаа. Уг төлөвлөгөөг bnd.ub.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулахын зэрэгцээ дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа 41 байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг эхний хагас жилээр тооцон	100%

						ажилласан бөгөөд 85.2 хувийн хэрэгжилттэй байна.	
Зорилт 3.46.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгсөн ажлын хэсгээс хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд заагдсан ажлыг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж хагас, бүтэн жилээр тайлангийн хамт, үр дүнг нь үнэлэн нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний газарт ирүүлэх. (Хариуцлагын гэрээний 3.9.6)							
256	3.46.1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж, тайлагнана.	-	Батлуулах төлөвлөгөөний тоо	1	1	Энэ оны 06 дугаар сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн тухай” 32 дугаар зөвлөмж ирүүлсэн ба зөвлөмжийн хүрээнд 15 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулж батлуулан холбогдох албан хаагчдад хүргүүллээ. Уг зөвлөмж нь 6 сард ирсэн тул эхний хагас жилийн биелэлт гаргаагүй, жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор нэгтгэн гаргахаар ажиллаж байна.	-
			Хүргүүлэх тайлангийн тоо	2	2		
			Хэрэгжилтийн хувь	-	85%		
Зорилт 3.48.Сайн засаглалыг хөгжүүлэх, цахим засаглалыг нэвтрүүлэх, дотоод удирдлага хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх. (Хариуцлагын гэрээний 3.9.9)							
257	3.48.1.ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоо, стандарт нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд хамтарч ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	75%	85%	Засаг даргын Тамгын газрын даргын 03 дугаар сарын 21-ний өдрийн 05/256 дугаартай албан бичгийг “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-д хүргүүлж, 04 дүгээр сард сургалт авахаар төлөвлөсөн	75%

						боловч одоогоор сургалт хийгээгүй байна.	
Зорилт 3.49.Холбогдох хууль тогтоомжоор эрх олгосон тохиолдолд захиргааны хэм хэмжээний акт боловсруулж, батлан Нийслэлийн Засаг даргаар дамжуулан Хууль, зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.9.10)							
258	3.49.1.Захиргааны хэм хэмжээний акт боловсруулсан тохиолдолд бүртгүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Бүртгүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт	-	Шаардлагат ай тохиолдолд бүртгүүлсэн байна	Энэ онд хэм хэмжээний акт батлагдаагүй болно.	-
Зорилт 3.50.Дүүргийн Засаг дарга нь гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдлын эх үүсвэрийг бууруулах, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийн хэрэглээг нэмэгдүүлэх тухай төсөл, төлөвлөгөө боловсруулж, үр дүнтэй ажлыг зохион байгуулах. (Хариуцлагын гэрээний 3.9.11)							
259	3.50.1.Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг хийж, сургалт зохион байгуулна. (Хариуцлагын гэрээний 4.2.3.1)	-	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого хийх давтамж	-	1 удаа	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг 5 хороодтой хамтран хийж 3-15 квт хүчин чадалтай 3241, 16-100 квт хүчин чадалтай 25, 100-4200 квт хүчин чадалтай 4 эх үүсвэрийн мэдээллийг ub.toollogo.mn сайтад шивж оруулан нэгтгэлийг Дүүргийн менежерийн 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 03/221 дугаартай албан бичгээр нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт хүргүүлсэн. Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс “Сар шинийн баяр”-ын арга хэмжээтэй холбогдуулан гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг удирдамж, хуваарийн дагуу 02 дугаар сарын 22-ны өдөр 1,4,5 дугаар хороо, 02 дугаар сарын 23-ны өдөр 3 дугаар хороо, 02 дугаар сарын 24-ний өдөр 2	100%
			Зохион байгуулах сургалтын тоо	-	1		

						дугаар хорооны айл өрхүүдээр нэгдсэн арга хэмжээ, “Хэрлэн”, “Соронз”, “Номин”, “Гэрэл” худалдааны төвүүдийн гадна талбайд өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, гадна тусгай зориулалтын автомашины чанга яригчаар сэрэмжлүүлэг хүргэн, нийт 250 иргэнд 250 ширхэг гарын авлага брошур тараан ажилласан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтаар нийт 2250 айл өрхийн 5200 иргэнд урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг хийж, 1500 ширхэг гарын авлага тараан, худалдааны төвүүдийн мэдээллийн салбарт нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “4 асуудал, 1 шийдэл” аяны постерийг байршуулан ажилласан. Багануурын мэдээ, ЗДТГ-ын тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс пэйж хуудсанд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх мэдээллийг оруулж, дүүргийн Онцгой байдлыг хэлтэс хороодын ажлын албатай хамтран гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэн	
--	--	--	--	--	--	---	--

						зуухны аюулгүй байдал, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.	
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД							
Зорилт 3.51.Дүүргийн Засаг даргаас Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр хүлээх хариуцлага. (Хариуцлагын гэрээний 4.1)							
260	3.51.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу улс, нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөнд санал боловсруулж хүргүүлнэ. (Хариуцлагын гэрээний 4.1.1)	-	Санал боловсруулж хүргүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	Санал боловсруулж хүргүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн 03/1288, 05/19 дугаартай албан бичгээр тус тус Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.	100%
261	3.51.2.Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, үр дүнг нийслэлийн Засаг даргын өмнө хариуцна. (Хариуцлагын гэрээний 4.1.2)	-	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	2025 онд Барилга байгууламжийн чиглэлээр 11 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс 10 ажлын явц 79,3%-тай Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар дэд бүтцийн чиглэлээр 14 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна 2025 оны 09 дүгээр сарын байдлаар ажлын явц нийт 73%-тай байна. Төхижилтын чиглэлээр 4 төсөл арга хэмжээ	75.5%

						гэрээний хугацаанд хэрэгжиж байна. Ажлын явц 85%-тай. Авто замын чиглэлээр 5 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 4 ажил гэрээний хугацаанд хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн ба тойрог авто замын 8,9,10 дугаар трассын газар шорооны ажил дууссан гүйцэтгэл 80%-тай, дүүрэгт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажил нийт 75.5%-ын гүйцэтгэлтэй байна.	
262	3.51.3.Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангын хөрөнгөөр дүүрэгт 610,000,000 (зургаан зуун арван сая) төгрөгийн 2024-2025 он дамжин санхүүжих 3 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана. (Хариуцлагын гэрээний 4.1.3)	-	Фасад засвар хийх байрнуудын тоо	-	5	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 19, 84, 86 дугаар байрны гадна фасад засварын ажлыг “Хан багана” ХХК, 39, 42-р байрны фасад засварын ажлыг “Нор вү инж” ХХК тус тус гүйцэтгэж комисс ажиллаж хүлээн авсан. Захиалагчийн хяналтыг НХОГ-тай хамтран хэрэгжүүлж ажилласан.	100%
263	3.51.4.Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүрэгт 880,000,000 (найман зуун наян сая) төгрөгийг эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажлын төсөл арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг хэрэгжүүлсэн байна.	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Гүн галуутай сургуулийн хичээлийн 1-р байрны халаалтын шугам сүлжээг шинэчлэх, Эрүүл мэндийн төвийн Г, Д блокийн цонх, агааржуулалт, цэвэр, бохир усны шугамын засварын ажлыг	100%

зохион байгуулж хэрэгжүүлнэ. (Хариуцлагын гэрээний 4.1.4)					"Цахирт-Ану" ХХК гүйцэтгэж, ХШГ, НХОГ-аас комисс ажиллаж хүлээн авсан.	
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ						93%

Тайлбар: Засаг даргын Тамгын газрын нэгж, албан хаагчдын 2025 онд хийж хэрэгжүүлэх ёстой 263 арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:

"Бүрэн хангалттай" буюу 85% түүнээс дээш хувьтай-194

"Хангалттай" буюу 70-85%-25

"Хангалтгүй" буюу 70% хүртэл-16

"Үнэлэх боломжгүй"-28 арга хэмжээ тус тус байна.

"Хангалтгүй" буюу 70% хүртэлх ангилалд хамрагдсан 16 арга хэмжээнээс 8 арга хэмжээг Нийгмийн хөгжлийн хэлтэс, 7 арга хэмжээг Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, 1 арга хэмжээг Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс хариуцан хэрэгжүүлсэн.

ТАЙЛАН ХЯНАСАН:
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

С.ДАВААСҮРЭН

2025 оны 12 дугаар сарын 03

ТАЙЛАГНАСАН:
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАТТУШИГ

2025 оны 12 дугаар сарын 03

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 22

Багануур дүүрэг

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.3, 2.4, 2.5 дахь хэсгүүдийг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээг Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд нийт 263 арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд арга хэмжээний хэрэгжилтэд ХШҮ хийхэд:

- “Бүрэн хангалттай” буюу 85% түүнээс дээш хувьтай-194
- “Хангалттай” буюу 70-85%-25
- “Хангалтгүй” буюу 70% хүртэл-16
- “Үнэлэх боломжгүй”-28 арга хэмжээ тус тус байна.
- “Хангалтгүй” буюу 70% хүртэлх ангилалд хамрагдсан 16 арга хэмжээнээс 8 арга хэмжээг Нийгмийн хөгжлийн хэлтэс, 7 арга хэмжээг Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, 1 арга хэмжээг Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс хариуцан хэрэгжүүлсэн. Тайлангийн үнэлгээний дундаж 93% хувийн гүйцэтгэлтэй буюу “Бүрэн хангалттай” гэж дүгнэж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн ХШҮ-ний дундаж 93%-тай байна. “Хангалтгүй” буюу 70 хүртэлх хувь үүнээс 0-30 хувийн хэрэгжилттэй 7 арга хэмжээг тодруулахад тайланд дурдсанаар:

1. 1.24.2.Хүнсний ногоо тариалах өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Биелэлт: Дүүрэгт 2024 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр Мянганы зам дагуу байршилд өвлийн хүлэмж барих ажлын тендерт “Богд сэрүүн хайрхан” ХХК шалгарсан. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас зургийг шаардлага хангахгүй байна барилгын иж бүрэн ажлын зураг байх, магадлалаар оруулах гэсэн шаардлагын дагуу иж бүрэн зураг, төсөв магадлан дүгнэлтээр орж эцэслэгдсэн. Барилгын норм, дүрмийн дагуу нэмэлт ажлууд хийлгэх төсөв нэмэгдэж Багануур дүүрэг 671,5 сая төг, Налайх дүүрэг 710,0 сая төг болсон. Налайх дүүргийн магадлалын дүгнэлт эцэслэж гараагүй байна. Иймээс батлагдсан байсан 500,0 сая төгрөгт дүүргийн хүлэмжийн ажлыг эхлүүлж өгөх хүсэлтийг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ -т албан бичгээр хүргүүлсэн.

2. 3.1.8.9.193 дугаар цэцэрлэгийн гадна тохижилтын ажлыг хийнэ.

Биелэлт: 193 дугаар цэцэрлэгийн гадна тохижилтын ажлын төсөв 2021 оны төсөвтэй байсан тул тендер тухайн ажлын төсвийг шинэчлэх ажлыг “Бета энерги” ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа бөгөөд 11 дүгээр сарын 25-ны өдөр магадлалын дүгнэлтийг гаргуулан хүлээлгэн өгөөд байна.

3. 3.1.8.10.Суралцагчдын дотуур байрны зураг төсвийг боловсруулна.

Биелэлт: Зураг төсөв боловсруулах хөрөнгийг төсвийн тодотголын саналд тусган шийдвэрлэж, тендер зарлан “Скайлайн дизайн” ХХК шалгарч, геологи хийлгэх, эскиз батлуулах шатанд байна. Гүйцэтгэл 30%-тай.

4. 3.1.8.11.131 дүгээр цэцэрлэгийн их засварын зураг төсвийг боловсруулна.

Биелэлт: Зураг төсөв боловсруулах хөрөнгийг төсвийн тодотголын саналд тусган шийдвэрлэж, тендер зарлан “Очир огтлогч” ХХК шалгарч, засварын зураг төсвийг боловсруулж байна. Гүйцэтгэл 30%-тай.

5. 3.26.1.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын индексийн үзүүлэлтийг тогтоож, суурь түвшинг нягталж сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллана.

Биелэлт: Хэрэгжээгүй.0%

6. 3.27.1.Хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох ажлыг зохион байгуулна.

Биелэлт: Хэрэгжээгүй.0%

7. 3.28.1. Хотын хөгжлийн индекс болон тухайн байгууллагын суурь мэдээллийг орон зайд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санд тухай бүр оруулж ажиллана.

Биелэлт: Хэрэгжээгүй. 0%

ТАВ. ЗӨВЛӨМЖ

1. Хүнсний ногоо тариалах өвлийн хүлэмж барих ажлыг эрчимжүүлж, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.- Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс
2. 193 дугаар цэцэрлэгийн гадна тохижилт, суралцагчдын дотуур байр болон 131 дүгээр цэцэрлэгийн их засварын зураг төсвийн ажлуудыг эрчимжүүлэх, хэрэгжилтийг сайжруулахад онцгой анхаарч ажиллах - Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
3. Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран өөрийн байгууллагын хариуцах индексийн үзүүлэлтийг тогтох, индексийн суурь түвшинг нягтлах, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлыг эрчимжүүлэх-Нийгмийн хөгжлийн хэлтэс
4. Биелэлтийг тайлагнахдаа үг, үсэг утга найруулгын алдаа гаргахгүй товчлохгүй байх.-Бүх хэлтэс

5. Хэрэгжилтийн хувь бага дүгнэгдсэн буюу хэрэгжээгүй, цаашид үргэлжлүүлэх шаардлагатай дээрх 7 арга хэмжээг байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнг тооцож ажиллах.-Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ТУЯА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ЗАХИРГААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ХУЛАН

